**МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ**

---

# Геодези, зураг зүй. Нэр томьёо, тодорхойлолт

**MNS 3951:2021**

**Албан хэвлэл**

**Стандарт, хэмжил зүйн газар**
**Улаанбаатар хот**
**2021 он**

## ӨМНӨХ ҮГ

Стандарт, Хэмжил Зүйн Газар (СХЗГ) нь Олон Улсын Стандартын байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран стандартчиллын бодлогыг хэрэгжүүлэх ажил эрхэлдэг.
Стандартын төсөл боловсруулах ажлыг салбарын Стандартчиллын Техникийн хороо (ТХ), Дэд хороо (ДХ) эрхлэн гүйцэтгэдэг бөгөөд Техникийн хорооны хурлаар хэлэлцэж гишүүдийн 75%-иас доошгүй дэмжиж, зөвшилцсөн төслийг тогтоолоор баталснаар хүчин төгөлдөр болно.
Энэ стандарт боловсруулах судалгааг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Геодези, зураг зүйн хэлтэс хийж, геодези, зураг зүйн салбарын ахмад ажилтан Монгол Улсын геодезийн зөвлөх инженер Б.Дэмбэрэл боловсруулж, доктор (PhD), дэд профессор, Монгол Улсын зөвлөх инженер Т.Балжинням хянан тохиолдуулж хэлбэршүүлсэн.
Стандартын төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд, Монгол Улсын геодези, зураг зүйн салбарын эрдэмтэд, мэргэжилтнүүдээс саналыг авч, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дэргэдэх орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дэмжлэг авсан.
Стандартыг боловсруулахад хамтран ажилласан ГЗБГЗЗГ-ын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн гишүүд болон доктор (PhD), дэд профессор Т.Балжинням, доктор (PhD), дэд профессор Д.Түвшинбаяр, доктор (PhD) П.Эрдэнэчимэг, Монгол Улсын зөвлөх инженер С.Энхтуяа, Ц.Дашзэвгэ, Ч.Болорчулуун, Ч.Цэрэнбат, Я.Сандагдорж, Г.Нарантуяа, Б.Болормаа, магистр (MSc) А.Сумъяа, Э.Баярмаа, Н.Хаш-Эрдэнэ.

**Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)**
Энхтайваны өргөн чөлөө 46А
Шуудангийн хаяг
Улаанбаатар-13343, Ш/Х - 48
Утас: 976-51-263860 Факс: 976-11-458032
E-mail: standardinform@masm.gov.mn
www.estandard.gov.mn; www.masm.gov.mn

**© СХЗГ, 2022**

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.
(Стандартчиллын төв байгууллага)-т байна.

## ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ
ОРШИЛ
1 Зорилго
2 Хамрах хүрээ
3 Норматив эшлэл
4 Нэр томьёо, тодорхойлолтууд
Ерөнхий ойлголт
Дэлхийн хэлбэр
Астрономийн ойлголт
Хүндийн хүч
Гравиметрийн шинжлэх ухаан
Гравиметрийн багаж
Гравиметрийн сүлжээ
Гравиметрийн хэмжилт, үр дүнгийн боловсруулалт
Геодезийн цэг,тэмдэгт
Солбицлын тогтолцоо
Геодезийн сүлжээ
Өндрийн сүлжээ
Байрлал тодорхойлох даяарчлалын тогтолцоо
Геодезийн хэмжилтийн математик боловсруулалт
Байр зүй
Хэрэглээний геодези
Геодезийн хэмжилтийн үндсэн багажууд
Геодезийн багажийн эд ангиуд
Геодезийн багажийн эд ангиудын зохицол
Геодезийн хэмжилтийн хэрэглээний бусад багажууд
Фотограмметр ба агаарын зураглал
Фотограмметрийн боловсруулалт
Агаарын байр зүй, агаарын зураглал
Зураг зүй
Газрын зургийн элементүүд ба зураг зүйн дүрслэлийн арга
Тоон зураг зүй
Зураг зүйн бүтээгдэхүүн
Математик зураг зүй
Газрын зураг зохиолт, хэвлэлт
Газар зүйн мэдээллийн тогтолцоо
Геодези, байр зүйн ажилд холбогдох бусад ойлголт
Кадастрын ойлголт
НОМ ЗҮЙ

## ОРШИЛ

Нэр томьёоны үндсэн зорилго нь Монгол Улсын геодези, зураг зүйн салбарын нэр томьёог тодорхойлох, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ажлын төрөл, чиглэлээс үл хамааран үйл ажиллагаа эрхэлж байгаа төр, засгийн байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, их дээд сургууль, шинжлэх ухааны эрдэм шинжилгээний байгууллага, иргэн, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр хууль, эрх зүйн баримт бичиг, ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээл, туурвилд хэрэглэхэд оршино.

Энэхүү стандартад орсон геодези, зураг зүйн салбарт нийтлэг хэрэглэгддэг 1500-аад нэр төрлийн нэр томьёо, тодорхойлолтуудыг боловсруулахад “Улсын стандарт. Геодези, Нэр томьёо тодорхойлолт, УСТ 3951-86, Геодези, зураг зүйн тухай хууль, Кадастрын зураглал, газрын кадастрын тухай хууль, Газрын тухай хууль, Барилгын тухай хууль, Зөрчлийн тухай хууль зэрэг хууль, эрх зүйн баримт бичиг, геодези, зураг зүйн техникийн норматив баримт бичиг, геодези, зураг зүйн үйл ажиллагаанд хамаарах бусад салбарын баримт бичигт орсон нэр томьёонд нийцүүлж боловсруулсан.

Өмнө нь Улсын стандартаар батлагдсан геодезийн нэр томьёо, тодорхойлолт нь 160-аад нэр томьёог багтаасан, нэг чиглэлээр тухайн үед өргөн хэрэглэж байсан монгол нэр, эсхүл орос хэл дээр хэвшмэл болсон тодорхойлолтуудыг агуулсныг орчин үеийн хэллэгт нийцүүлсэн болно.

Орчин үеийн шинжлэх ухаан техникийн дэвшлийн дагуу геодези, зураг зүйн шинжлэх ухаанд маш олон нэр томьёо гадаад хэлээр хэрэглэгдэх болсон тул монгол хэлэнд хөрвүүлж стандарт болгон батлуулахаар энэ төслийг боловсруулла.

Стандартад лавлагаа байдлаар ижил утгатай стандартчилагдсан гадаадын нэр томьёог хүснэгтийн 3-р баганад орос хэл дээр-(Р), англи хэл дээр-(Е) тэмдэглээсээр оруулсан.

Газрын багц хуулиуд хэрэгжиж ирсэн үеэс эхлэн тус салбар нь газрын харилцааны салбарын чиглэлд онцгой ач холбогдолтой мэдээллийн технологийн чиглэлээр болон бусад чиглэлээр үндсэн суурь өгөгдлөөр хангах үүргийг гүйцэтгэж байгаа тул Газрын кадастрын зарим нэр томьёо, тодорхойлолтуудыг оруулла.

Энэ стандартын нэр, тодорхойлолтын төрлийг ашиглахад хялбар болгох зорилгоор үндсэн 29 хэсэгт хуваасан болно.

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Ангиллын код 01.040.73; 01.040.91**

| | |
|---|---|
| **Геодези, зураг зүй**<br>**Нэр томьёо, тодорхойлолт** | **MNS 3951:2021** |
| **Geodesy, cartography. General terms and definitions** | **MNS 3951:1986-ын оронд** |

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн С/35 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

## 1 Зорилго

Энэхүү стандартаар Монгол улсын геодези, зураг зүйн салбарт хамаарах нэр томьёог тодорхойлж, нэгдсэн бичиглэл, ойлголттой болоход оршино.

## 2 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь Монгол улсын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр геодези, зураг зүй, фотограмметрийн баримт бичгийн системд хамаарах бөгөөд геодезийн салбарын нэр томьёо, тодорхойлолтыг тогтооно.

Стандартаар тогтоогдсон нэр томьёо нь сурах бичиг, сургалтын гарын авлага, лавлах болон техникийн бүх төрлийн баримт бичигт мөрдөгдөнө.

## 3 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах стандарт, баримт бичгээс эш татсан бөгөөд эдгээрт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн үеийн албан ёсны эх материалаас эш татна. Үүнд:

- *ГОСТ Р 51833-2001. Фотограмметрия. Термины и определения. Москва, 2001;*
- *ГОСТ 52369 (2005). Фототопография. Термины и определения. Москва, 2005;*
- *ГОСТ Р 52438-2005. Географические информационные системы. Термины и определения, Москва, 2005;*
- *ГОСТ Р 52572-2006. Географические информационные системы. Координатная основа. Общие требования. Москва, 2006;*
- *ГОСТ 28441-99. Картография цифровая. Термины и определения. Москва, 1999;*
- *ГОСТ Р 53864-2010. Глобальная навигационная спутниковая система. Сети геодезические спутниковые. Термины и определения, 2010;*
- *ГОСТ 21830-76. Приборы геодезические. Термины и определения, Москва, 1976;*
- *Монгол Улсын стандарт.Иргэний нисэх.Ерөнхий нэр томьёо.тодорхойлолт.MNS 6409:2015.*

## 4 Нэр томьёо, тодорхойлолтууд

**Термины и определения**
**Terms and definitions**

Энэхүү стандартад тодорхойлолтыг төрөл зүйлийн дагуу ангилан хувааж, түүнд түгээмэл хэрэглэгдэх агуулгын дагуу нэр томьёог хүснэгтэд жагсаан байршуулсан.

Лавлах зориулалтаар нэр томьёог орос, англи хэл дээр бичиж хамт оруулсан бөгөөд эх хэлэнд нэвтэрсэн утга нь шууд ойлгогдох гадаад хэллэгт тодорхойлолт хийгдсэн боловч салбарын хамрах хүрээний асуудалд шууд нэр томьёоны дагуу хэрэглэнэ.

**ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ**
**ОБЩИЕ ПОНЯТИЯ**
**GENERAL CONCEPTS**

| д/д | **Нэр томьёо Монгол** | **Р:Термины-русский** | **Тодорхойлолт** |
|---|---|---|---|
| 1. | Геодези | **Р:**Геодезия<br>**E:**Geodesy | Дэлхий, гараг эрхсийн хэлбэр, хэмжээ, тэдгээрийн туйлын, царцдасны, гадаргын шилжих хөдөлгөөн, таталцлын орныг тодорхойлох цэгийн байрлал, өндөр, хүндийн хүчний хурдатгалыг цаг хугацаатай уялдуулан хэмжин тодорхойлж, математик боловсруулалт хийх шинжлэх ухаан |
| 2. | Дээд геодези | **Р:**Высшая геодезия<br>**E:**Higher geodesy | Дэлхийн хэлбэр хэмжээг болон газрын гадаргын түүний орчинд цэгийн солбицол тодорхойлох зорилгоор хийгдэх геодезийн өндөр нарийвчлалын хэмжилтийн аргыг судлах, боловсруулах геодезийн шинжлэх ухааны салбар |
| 3. | Геоматик | **Р:**Геоматика<br>**E:**Geomatics | Геодези, зураг зүй, зайнаас тандан судалгаа, фотограмметр, газар зүйн мэдээллийн болон орон зайн өгөгдлийг цуглуулах, боловсруулах арга, хэрэгслийг иж бүрэн нэгтгэн судалдаг геодезийн шинжлэх ухааны салбар |
| 4. | Геоинформатик | **Р:**Геоинформатика<br>**E:**Geoinformatics | Газар зүйн, зураг зүй, инженерчлэлийн болон бусад шинжлэх ухаанд тулгамдсан |

| | | | |
|---|---|---|---|
| | | | асуудлыг шийдвэрлэхийн тулд мэдээллийн шинжлэх ухааныг ашиглаж буй технологи, шинжлэх ухааны салбар.<br>Орон зайн мэдээллийг цуглуулах, хадгалах, боловсруулах, дүн шинжлэх, дүрслэх, түгээхтэй холбогдсон шинжлэх ухаан, технологийн цогц.<br>Байгаль, нийгэм, эдийн засаг, техник, хүмүүнлэгийн суурь шинжлэх ухаануудыг хамарсан, мэдээллийн технологи, зураг зүйн автоматчилсан, компьютер-графикийн хөгжлийн явцад үүссэн шинжлэх ухааны сонгомол интеграл чиглэл. |
| 5. | Геоиконик | **Р:**Геоиконика<br>**E:**Geoiconics | Гео-дүрслэлийн онолын асуудлууд болон түүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, өөрчлөх, ашиглах арга ажиллагааг судалдаг геодезийн шинжлэх ухааны салбар |
| 6. | Инерцийн геодези | **Р:**Инерциальная геодезия<br>**E:**Inertial geodesy | Солбицлыг автоматаар дамжуулахад инерцийн систем ашиглах геодезийн шинжлэх ухааны салбар |
| 7. | Сансрын геодези | **Р:**Космическая геодезия<br>**E:**Space geodesy/ | Дэлхийн хиймэл дагуулаас сансрын зураг авах, сансрын зургийн тайлал хийх, гурван хэмжээст гэрэл зургийн аргаар төрөл бүрийн масштабын газрын зураг зохиох, хиймэл дагуулаас хүлээн авсан мэдээллийг ашиглан геодезийн сүлжээ байгуулах геодезийн шинжлэх ухааны салбар |
| 8. | Астрономи-геодези | **Р:**Космическая геодезия<br>**E:**Geodetic astronomy | Од, гариг, сар болон сансрын бусад биетийн чиглэлийг ажиглах замаар уртраг, өргөрөг, азимутыг тодорхойлох шинжлэх ухааны салбар |
| 9. | Тэнгисийн геодези | **Р:**Морская геодезия<br>**E:**Marine geodesy | Далай, тэнгисийн ёроолын зураг авах, түүний нөөцийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | судалгаа хийхэд зориулсан гүний хэмжилт, зураглал хийх, усны гадарга ба гүний гравиметрийн хэмжилт хийхтэй холбоотой геодезийн шинжлэх ухааны салбар |
| 10. | Хэрэглээний геодези | **P:**Прикладная геодезия<br>**E:**Applied geodesy | Инженерийн эрэл хайгуулын төсөл зохиох, барилга, инженерийн олон төрлийн байгууламжуудыг барих, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжүүдийг угсрах болон тэдгээрийн ашиглалттай холбоотой хяналт, шалгалтын олон зорилтуудыг шийдвэрлэхэд чиглэсэн геодезийн тусгай аргачлалууд, техник технологийн асуудлуудыг боловсруулан шийдвэрлэдэг геодезийн шинжлэх ухааны салбар |
| 11. | Бөмбөрцгийн геодези | **P:**Сфероидическая геодезия<br>**E:**Spheroidal geodesy | Солбицлын эхлэл гадаргаар Дэлхийн эллипсоидыг сонгон авч газрын гадаргуу, түүний орон зайн орчинд цэгүүдийн харилцан байрлалыг тодорхойлох аргыг судлах геодезийн шинжлэх ухааны салбар |
| 12. | Онолын геодези | **P:**Теоретическая геодезия<br>**E:**Theoretical geodesy | Дээд геодезийн үндсэн асуудал болох Дэлхийн эллипсоидын хэлбэр, чиглүүлгийг тодорхойлох зорилгоор геодезийн, астрономийн, татах хүчний, хиймэл дагуулын хэмжилтийн үр дүнг хамтатган ашиглах асуудлыг судлах геодезийн шинжлэх ухааны салбар |
| 13. | Геодезич | **P:**Геодезист<br>**E:**Geodesists/Surveyor | Геодезийн салбарын астрономи-геодези, гравиметрийн, хиймэл дагуулын геодезийн хэмжилт, боловсруулалт, хэрэглээний геодезийн зэрэг геодезийн үйл ажиллагаа эрхлэх, гүйцэтгэх ажлын чадвар бүхий боловсролтой мэргэжилтэн |

| | | | |
|---|---|---|---|
| 14. | Геодинамик | **Р:**Геодинамика<br>**E:**Geodynamics | Дэлхийн царцдаст бүрхүүлд аажмаар нөлөөлөх үйл ажиллагааг судалдаг геофизикийн шинжлэх ухааны салбар |
| 15. | Геоморфологи | **Р:**Геоморфология<br>**E:**Geomorphology | Дэлхийн газрын гадаргын хотгор гүдгэрийн гадаад хэлбэр дүрс, гарал үүсэл, хөгжил өөрчлөлтийг судалдаг физик газар зүйн салбарын шинжлэх ухаан |
| 16. | Ус зүй | **Р:**Гидрография<br>**E:**Hydrography | Ус зүйн объектын зураглал хийх, үр дүнг газрын зурагт буулгах асуудлыг судлах, тэдгээрийн тухай тайлбарыг боловсруулах эх газрын ус судлалын шинжлэх ухааны салбар |
| 17. | Геодезийн сэлгэц | **Р:**Геодезический ход<br>**E:**Traverse | Тахир хэлбэрийн шугамаар байгуулсан геодезийн байгууламж |
| 18. | Задгай сэлгэц | **Р:**Ход висячий<br>**E:**Open traverse | Эхлэл нь геодезийн тулгуур цэгт холбогдож төгсгөл нь холболтгүй хийгдсэн сэлгэц |
| 19. | Битүү сэлгэц | **Р:**Ход замкнутый<br>**E:**Close traverse | Геометрийн хэлбэрийн хувьд нугарсан, эхлэл ба төгсгөл нь битүүрч холбогдсон сэлгэц |
| 20. | Сунасан сэлгэц | **Р:**Вытянутый ход<br>**E:**Chain traverse | Шулуун шугамд ойролцоо хэлбэртэйгээр сунаж байгуулагдсан сэлгэц |
| 21. | Шууд сэлгэц | **Р:**Прямой ход<br>**E:**Forward traverse | Эхлэлийн цэгээс эхлэн төгсгөл цэг хүртэл хийгдсэн сэлгэц |
| 22. | Урвуу сэлгэц | **Р:**Обратный ход<br>**E:**Reverse traverse | Төгсгөлийн цэгээс эхлэн эхлэл цэг хүртэл хийгдсэн сэлгэц |
| 23. | Нивелирдлэгийн сэлгэц | **Р:**Ход нивелирования<br>**E:**Leveling traverse | Цэгүүдийн хооронд өндөржилт дамжуулахын тулд дараалуулан байгуулагдсан цэгүүд |
| 24. | Теодолитын сэлгэц | **Р:**Теодолитный ход<br>**E:**Theodolitic traverse | Зураглалын үндэслэлийн цэгүүдийн байрлалыг теодолитын тусламжтайгаар тодорхойлох зорилгоор тухайн газарт байгуулсан мурийж тахиралдсан шугаман байгууламж |
| 25. | Полигонометрийн сэлгэц | **Р:**Полигонометрический ход<br>**E:**Plane-table Traverse | Геодезийн хэмжилтийн ажлын байрлалын тулгуур болгох зориулалтаар өнцөг, зайн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | өндөр нарийвчлалтай хэмжилтээр солбицлуудыг нь тодорхойлдог цэгүүд бүхий сэлгэц |
| 26. | Сэлгэцийн урт | **P:**Длина хода<br>**E:**Traverse length | Сэлгэцийн эхлэл, төгсгөлийн цэгүүд хооронд хэмжигдсэн талуудын уртын нийлбэр |
| 27. | Хараалах бай | **P:**Цель визирная<br>**E:**Sighting target | Геодезийн бусад цэгүүдээс хараалж хэмжилт хийхэд зориулагдсан геодезийн тэмдэгт |
| 28. | Хараалах бортого | **P:**Визирный цилиндр<br>**E:**Sighting cylinder | Хэмжилтийн дурангаар хараалж өнцөг хэмжихэд зориулагдсан тэмдэгтийн бортого |
| 29. | Хэмжилт, ажиглалт | **P:**Наблюдение<br>**E:**Observations | Сонгож авсан хэмжилтийн нэгжид физик хэмжигдэхүүний тоон холбогдлыг тодорхойлох зорилгоор хэмжилтийн багаж хэрэгслийн тусламжтайгаар гүйцэтгэж байгаа технологийн цогц үйл ажиллагаа |
| 30. | Хэмжилтийн арга | **P:**Метод измерения<br>**E:**Measurement method | Хэмжилтийн сонгосон зарчимд зохицсон хэмжиж буй хэмжигдэхүүнийг түүний хэмжилтийн нэгжтэй харьцуулах аргуудын нэгдэл эсвэл арга |
| 31. | Хэмжээс | **P:**Размерность<br>**E:**Dimension | Хэмжилтийн физик хэмжигдэхүүний нэг болон хэд хэдэн нэгжийг хадгалах ба тэдгээртэй хийсэн хэмжилтийг харьцуулах зориулалттай хэмжилтийн хэрэгсэл |
| 32. | Шууд бус хэмжилт | **P:**Косвенное измерение<br>**E:**Indirect measurement | Шууд хэмжилтүүдийн тусламжтайгаар тодорхойлж байгаа хэмжигдэхүүн |
| 33. | Харьцангуй хэмжилт | **P:**Измерение относительное<br>**E:**Relative measurement | Хэмжигдэхүүнийг нэг утгатай үүсгэл хэмжигдэхүүнд эсвэл харьцангуй өөрчлөгдөж байгаа хэмжигдэхүүнд харьцуулах зорилгоор хийж байгаа хэмжилт |
| 34. | Үнэмлэхүй хэмжилт | **P:**Абсолютное измерение<br>**E:**Absolute measurement | Хэмжүүрийн тогтмол утгыг ашиглаж нэг болон олон тооны хэмжигдэхүүнийг шууд хэмжих үйл ажиллагаанд тулгуурласан хэмжилт |
| 35. | Градусын хэмжилт | **P:**Градусное измерение<br>**E:**Degree measurements | Дэлхийн хэмжээг тодорхойлох зориулалттай хийсэн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | астрономийн ба геодезийн өндөр нарийвчлалын хэмжилт |
| 36. | Шаардлагатай буюу зайлшгүй хэмжилт | **P:**Необходимое измерение<br>**E:**Required measurement | Тодорхойлж буй хэмжигдэхүүний утгыг мэдэх зорилгоор зөвхөн нэг удаа хийгдэх хэмжилт |
| 37. | Нэг чигийн шулуун хэмжилт | **P:**Створное наблюдение<br>**E:**Casement observation | Хоёр цэгийг холбосон шулууны чиглэлээр хийгдэх хэмжилт |
| 38. | Шууд хэмжилт | **P:**Измерение прямое<br>**E:**Direct measurement | Хэмжиж буй хэмжигдэхүүнийг түүний хэмжүүрийн үзүүлэлттэй шууд харьцуулах хэмжилт |
| 39. | Геодезийн хэмжилт | **P:**Геодезическое измерение<br>**E:**Geodetic measurements | Шаардлагатай асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор геодезийн шинжлэх ухааны салбарт ашигладаг арга, техник, технологиор хийгдэж байгаа хэмжилтүүд |
| 40. | Илүүдэл хэмжилт | **P:**Измерения избыточные<br>**E:**Excess measurements | Шаардлагатай нэг удаагийн хэмжилтээс бусад давтагдсан хэмжилтүүд |
| 41. | Автомат хэмжилт | **P:**Измерение автоматическое<br>**E:**Automatic measurement | Автомат төхөөрөмжөөр хэмжилт хийх үйл ажиллагаа |
| 42. | Ижил бус нарийвчлалын хэмжилт | **P:**Измерения неравноточные<br>**E:**Unequal measurements | Ижил бус нөхцөл байдалд өөр өөр техник, технологиор гүйцэтгэсэн хэмжилт |
| 43. | Ижил нарийвчлалын хэмжилт | **P:**Измерения равноточные<br>**E:**Equal measurement | Ижил нөхцөл (нэг буюу ижил нарийвчлалын багаж, нэг арга, гүйцэтгэгчийн) байдалд гүйцэтгэсэн хэмжилт |
| 44. | Астрономийн хэмжилт | **P:**Астрономические определения<br>**E:**Astronomical measurements | Астрономийн өргөрөг, уртраг, зовхис тодорхойлох технологийн үйлдэл |
| 45. | Хэмжилтийн хэрэгсэл | **P:**Средство измерения<br>**E:**Means of measurement | Тодорхой цаг хугацааны туршид физик хэмжигдэхүүний үл өөрчлөгдөх нэгжийг хадгалан түүнтэй харьцуулан хэмжихэд зориулагдсан техник хэрэгсэл |
| 46. | Геодезийн хэмжилтийн тэмдэглэл /журнал/ | **P:**Журнал геодезический<br>**E:**Geodetic book | Байр зүйн зураглал, геодезийн хээрийн хэмжилтийн үр дүнг тэмдэглэх зориулалтын хүснэгттэй дэвтэр |

| | | | |
|---|---|---|---|
| 47. | Налуугийн өнцөг | **P:**Угол наклона<br>**E:**Angle inclination, Phase angle | Тухайн өгөгдсөн шулууны чиглэл ба хэвтээ хавтгайн хооронд үүссэн өнцөг |
| 48. | Огтлолын өнцөг | **P:**Угол засечки<br>**E:**Angle of crossing | Эхлэлийн нэг талаас тодорхойлж буй цэг рүү хэмжигдсэн хоёр чиглэлийг үүсгэсэн өнцөг |
| 49. | Параллактик өнцөг | **P:**Параллактический угол, угол параллакса<br>**E:**Parallactic Angle | Хэмжиж буй шугамын төгсгөлөөс оптикийн зай хэмжүүрт, түүний зай хэмжүүрийн суурь харагдах өнцөг |
| 50. | Тулах өнцөг | **P:**Угол примычный<br>**E:**Adjacent angle | Зүглэлийн өнцөг нь өгөгдсөн тал ба теодолитийн эсвэл полигонометрийн сэлгэцийн эхний тал хоорондох хэвтээ өнцөг |
| 51. | Босоо өнцөг | **P:**Вертикальный угол<br>**E:**Vertical angle | Босоо хавтгай дээр байгуулагдсан өнцөг |
| 52. | Хэвтээ өнцөг | **P:**Горизонтальный угол<br>**E:**Horizontal angle | Тухайн цэгийг дайрч гарсан эгц босоо шугамаас өгөгдсөн хоёр шулуун хооронд үүссэн хоёр ирмэгт өнцөг |
| 53. | Хавтгай өнцөг | **P:**Плоский угол, угол на плоскости<br>**E:**Plane angle | Нэг цэгээс гарсан хоёр цацраг буюу шулууны хоорондох өнцөг |
| 54. | Дэлгэмэл өнцөг | **P:**Угол развернутый<br>**E:**Straight angle | 180 градусын хэмжээнд ойр өнцөг |
| 55. | Дурангийн харах өнцөг | **P:**Угол поля зрения<br>**E:**Angle of view | Орой нь объективын оптик төвд, талууд нь дурангийн өрц (диафрагм)-ний утсан торны диаметр дээр орших өнцөг. Дурангийн харах талбай ихэвчлэн 1,0-1,50 байна. |
| 56. | Туйлын өнцөг | **P:**Полярный угол<br>E.Polar angle | Туйлын солбицол дахь өнцөг |
| 57. | Зүглэлийн өнцөг | **P:**Дирекционный угол<br>**E:**Grid bearing | Тэнхлэгийн голдоч ба түүнтэй зэрэгцээ шулууны хойт чиглэлээс өгөгдсөн чиглэл хүртэл цагийн зүүний эргэлтийн дагуу 0-360 градусын хооронд тоологдох хэвтээ өнцөг |
| 58. | Урвуу зовхис | **P:**Азимут обратный<br>**E:**Back azimuth | Аливаа шулууны төгсгөлийн хоёр цэг бүрээс эхний цэг рүү харсан чиглэлийг тодорхойлж буй зовхис |
| 59. | Шууд зовхис | **P:**Азимут прямой<br>**E:**Forward Azimuth | Аливаа шулууны төгсгөлийн хоёр цэгийн эхний цэгээс нөгөө төгсгөл цэг рүү харсан |

| | | | |
|---|---|---|---|
| | | | чиглэлийг тодорхойлж буй зовхис |
| 60. | Геодезийн оройн зай | **Р:**Геодезическое зенитное расстояние **E:**Geodetic zenith distance | Геодезийн оройн цэгээс буюу эгц босоогоос тухайн цэг хүртэл тооцогдсон босоо өнцгийн утга |
| 61. | Зовхис | **Р:**Азимут **E:**Azimuth | Хэмжилтийн цэгийг дайрах голдчийн хавтгай, энэ цэг болон ажиглаж буй объектыг дайрах босоо хавтгай хоорондын өнцөг өөрөөр хэлбэл голдчийн хойд чиглэлээс өгөгдсөн чиглэл хүртэл цагийн зүүний эргэлтийн дагуух хэвтээ өнцөг. *Тайлбар: Хэрэв босоо хавтгай хэмжилтийн цэгийн эгц шулууныг дайрч байгаа бол жинхэнэ зовхис гэнэ.* |
| 62. | Соронзон зовхис | **Р:**Магнитный азимут **E:**Magnetic azimuth | Соронзон голдчийн хойд чиглэлээс өгөгдсөн чиглэл хүртэлх цагийн зүүний эргэлтийн дагуу авсан 0-360° хүртэлх хэвтээ өнцөг |
| 63. | Соронзон хэвийлт | **Р:**Наклонение магнитное **E:**Magnetic inclination | Газрын гадаргын ямар нэгэн цэг дээрээс соронзон орны хүчний чиглэл хэвтээ хавтгай хоёрын хооронд үүсэх өнцөг |
| 64. | Геодезийн зовхис | **Р:**Геодезический азимут **E:**Geodetic azimuth | Тухайн цэгийг дайран гарсан геодезийн голдчийн хавтгай ба тухайн чиглэлийн нормаль дайрсан хавтгай хоорондох цагийн зүүний дагуу туйл руу харсан чиглэлээс тоолсон хоёр талт өнцөг |
| 65. | Лапласын зовхис | **Р:**Азимут Лапласа **E:**Laplace azimuth | Астрономийн тухайн зовхисоос эгц босоо шугамын хазайлтын нөлөөллийг засах замаар тодорхойлсон геодезийн зовхис |
| 66. | Газар зүйн зовхис | **Р:**Географический азимут **E:**Geographic (al) azimuth | Тухайн цэгийн голдчийн хавтгай болон тодорхой чиглэлийг дайран гарсан босоо хавтгай хоорондох туйл руу харсан чиглэлээс эхлэн цагийн дагуу хэмжигдсэн өнцөг. |
| 67. | Жинхэнэ зовхис | **Р:**Истинный азимут **E:**The true azimuth | Жинхэнэ голдчийн хойд чиглэлээс цагийн зүүний эргэлтийн дагуу өгөгдсөн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | чиглэл хүртэл хэмжигдсэн хэвтээ өнцөг |
| 68. | Хэвтээ тавилт | **Р:**Горизонтальное проложение<br>**E:**Horizontal distance | Шугамыг хэвтээ хавтгайд тусгагчаар буулгасан урт |
| 69. | Румб | **Р:**Румб<br>**E:**Rhumb | Тэнхлэгийн голдоч ба түүнтэй зэрэгцээ шулууны хойд ба урд чиглэлийн аль нэгнээс өгөгдсөн шулууны чиглэл хүртэл тооцогдох хурц өнцөг *r* |
| 70. | Соронзон румб | **Р:**Магнитный румб<br>**E:**Magnetic bearing | Соронзон голдчийн өмнөд буюу хойд чиглэлээс (соронзон зүүний тэнхлэг) өгөгдсөн чиглэл хүртэлх хэвтээ хурц өнцөг |
| 71. | Геодезийн хэмжил зүй | **Р:**Метрология геодезическая<br>**E:**Geodetic metrology | Геодезийн хэмжилтийн нэгдмэл байдал, шаардагдах хэмжилтийн нарийвчлалыг хангах геодезийн үйл ажиллагааны хэсэг |
| 72. | Байр зүйн ажил | **Р:**Топографические работы<br>**E:**Topographic work | Байр зүйн ба дэвсгэр зургийн эх гарган авах зориулалтаар хийгдэх зураглалын хээрийн ба суурин боловсруулалтын ажил |
| 73. | Гравиметрийн ажил | **Р:**Гравиметрические работы<br>**E:**Gravimetric work | Үнэмлэхүй болон харьцангуй хүндийн хүчний хурдатгал тодорхойлох хээрийн болон суурин боловсруулалтын ажил |
| 74. | Зураг зүйн ажил | **Р:**Картографические работы<br>**E:**Cartographic work | Зураглалын болон зураг зүйн эх материалаар зураг зүйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цогц ажил |
| 75. | Маркшейдерийн ажил | **Р:**Маркшейдерская работа<br>**E:**Mine Surveying | Ашигт малтмалын орд газрын хайгуул, судалгаа хийх, ашиглалт явуулах, газрын гадарга болон газар доор уулын үйлдвэр барьж байгуулах, ашиглах үеүдэд хийгддэг хэмжилтийн ажлуудын техник, хэрэгсэл, арга технологийн асуудлыг судалдаг мэргэжлийн салбар |
| 76. | Геодези, байр зүйн ажил | **Р:**Топографо-геодезические работы<br>**E:**Topographic and geodetic works | Нэгдсэн нэг төсөл, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэдэг геодези, байр зүйн ажил |
| 77. | Геодезийн үндсэн ажлууд | **Р:**Основные геодезические работы | Дэлхийн хэлбэр, таталцлын хүчний талбайг тодорхойлох, |

| | | | |
|---|---|---|---|
| | | **E:**Main geodetic works | газрын гадаргуун цэгүүдийн солбицол, тэдгээрийн цаг хугацааны өөрчлөлтийг тодорхойлох технологийн иж бүрэн үйл ажиллагаа |
| 78. | Геодези, зураг зүйн үйл ажиллагаа | **P:**Геодезическая (картографическая) деятельность<br>**E:**Geodetic (cartographic) activities | Шинжлэх ухаан, техникийн, үйлдвэрлэлийн, удирдлагын геодези, зураг зүйн салбарын үйл ажиллагааны цогц |
| 79. | Геодезийн цэгүүдийн солбицлын жагсаалт | **P:**Каталог координат геодезических пунктов<br>**E:**Coordinate catalog of geodetic points | Нутаг дэвсгэрийн геодезийн сүлжээний эсвэл хэсэг газрын геодезийн цэгүүдийн солбицлуудын эмхлэн нэгтгэсэн жагсаалт |
| 80. | Геодези, байр зүйн ажлын техникийн тайлан | **P:**Технический отчет по топографо-геодезическим работам<br>**E:**Drawing up the technical report (about geodetic, topographical works) | Геодези, байр зүйн хээрийн болон суурин боловсруулалтын ажлуудыг гүйцэтгэсэн арга зүй, ашигласан техник технологи, хэмжилтийн үр дүн, бодолт боловсруулалт, хэмжилтийн чанарын үнэлгээ, эцсийн бүтээгдэхүүний талаар хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт бүхий эмхэлж цэгцлэн баталгаажуулсан техникийн баримт бичиг |
| 81. | Геодези, байр зүйн ажлын техникийн төсөл | **P:**Технический проект топографо-геодезических работ<br>**E:**Drawing up the engineering design (on performance topographic-geodetic works) | Геодези, байр зүйн ажлын объектын шинж чанар, гүйцэтгэх ажлын төрөл, хэмжээ, ажил гүйцэтгэх техник технологи, аргачлал, нарийвчлал, хяналт тавих, хүлээн авах арга болон хөдөлмөр зарцуулалт, гүйцэтгэх хугацаа, төсөв бүхий техник-эдийн засгийн баримт бичиг |
| 82. | Геодезийн улсын хяналт | **P:**Государственный геодезический надзор<br>**E:**State geodetic control | Улсын мэргэжлийн хяналтын байгууллагаас геодези, зураг зүйн үйл ажиллагааны хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавих төрийн байгууллагын үйл ажиллагаа |
| 83. | Геодезийн техникийн хяналт | **P:**Технический контроль<br>**E:**Technical control | Геодезийн ажлын тогтоосон техникийн шаардлагыг хэрхэн биелүүлсэн эсэхэд хийх шалгалт |

| | | | |
|---|---|---|---|
| 84. | Геодези, зураг зүйн хөдөлмөр хамгаалал | **P:**Охрана труда картографо-геодезических работ **E:**Labour protection of cartographic and geodetic works | Нийгэм эдийн засгийн, зохион байгуулалтын, техникийн, эрүүл ахуйн, ариун цэвэр, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга, хэрэгсэл, арга хэмжээнд чиглэсэн хөдөлмөрийн аюулгүйн ажиллагааны тухай геодези, зураг зүйн хууль тогтоомжийн тогтолцоо |
| 85. | Геодези, зураг зүйн техникийн аюулгүй ажиллагаа | **P:**Техника безопасности картографо-геодезических работ **E:**Safety of cartographic and geodetic works | Үйлдвэрлэлийн аюултай нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх техник хэрэгсэл болон зохион байгуулах аргын тогтолцоо |
| 86. | Геодези, зураг зүйн хөдөлмөрийн аюулгүй нөхцөл | **P:**Безопасные условия труда картографо-геодезических работ **E:**Safety conditions of cartographic and geodetic works | Геодези, зураг зүйн үйлдвэрлэлийн аюултай, хортой нөхцөлийн нөлөөллийг арилгасан, эсвэл тогтоосон норм хэмжээнээс ихгүй байдалд хөдөлмөрлөх горим |
| 87. | Геодези, зураг зүйн бүтээл хугацааны норм | **P:**Единые нормы выработки (времени) на топографо-геодезические и картографические работы **E:**Norms for geodetic and cartographic work | Геодези, зураг зүйн ажил гүйцэтгэдэг байгууллага, аж ахуйн нэгжийн дагаж мөрдөх геодези, зураг зүйн ажлын бүтээлийн (хугацааны) нормыг тогтоох баримт бичиг |
| 88. | Геодезийн ажлын зэрэг | **P:**Категория трудности **E:**Category of difficulty | Геодезийн хээрийн хэмжилтийн ажилд нөлөөлөх физик газар зүйн хүндрэлийн нөхцөлийг мөн суурин бодолт боловсруулалтын ажилд хүндрэлийг тус тус тооцсон ажлын зэрэглэл |
| 89. | Геодези, байр зүйн ажлын дүрэм | **P:**Правила топографо-геодезических работ **E:**Instruction for geodetic and cartographic works | Геодези, байр зүйн ажил гүйцэтгэхэд зайлшгүй биелүүлэх үйл ажиллагааны норматив баримт бичгийн зохицуулалт |
| 90. | Геодези, зураг зүйн ажлын заавар | **P:**Инструкция топографо-геодезических работ **E:**Guidelines for geodetic and cartographic works | Үйлдвэрлэлийн ба удирдлагын үйл ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээг гүйцэтгэхэд ашиглах арга хэлбэр, зохион байгуулалт, дэс дарааллыг заасан удирдлага болгох баримт бичиг |

| | | | |
|---|---|---|---|
| 91. | Геодези, зураг зүйн ажлын техникийн заавар, дүрмийн эмхэтгэл | **Р:**Сборник технических инструкциий, нормы и правил по топографо-геодезическими работами **E:**Compilation of norms, Instructions and guidelines of geodetic and cartographic works | Геодези, байр зүй, зураг зүйн үйлдвэрлэлийн технологи, хэмжилтийн арга, хэрэгсэл, нарийвчлалын хэмжигдэхүүн, математик боловсруулалтын арга, нарийвчлалын үнэлгээ хийх, ажлын чанар, хяналт шалгалт, хүлээн авах журмын нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн улсын болон салбарын норматив техникийн албан ёсны хэвлэл/эмхэтгэл |
| 92. | Геодези, зураг зүйн үйл ажиллагааны стандарт, норм ба заавар, дүрмийн тогтолцоо | **Р:**Система геодезических, картографических стандарт, инструкций, нормы и правил **E:**Geodesy and cartography norms and standards framework | Геодези, зураг зүйн үйл ажиллагааны хүрээний төрөл бүрийн ангиллын норматив-техникийн ба аргачлалын баримт бичгийн бүрдэл |
| 93. | Геодези, зураг зүйн архив | **Р:**Картографо-геодезический фонд **E:**Archive of geodetic and cartographic work | Геодези, зураг зүйн үйл ажиллагааны үр дүнд бий болсон тоон, зурган, бичлэгэн, төрөл бүрийн зөөвөрлөх төхөөрөмжүүдэд хадгалагдсан тодорхой хугацаанд хадгалах, ашиглах зориулалттай материалуудын нэгдсэн сан |
| 94. | Геодезийн багажуудын шалгалтууд | **Р:**Поверки геодезических приборов **E:**Calibration of geodetic instruments | “Геодезийн хэмжилтийн багаж шалгах, тохируулах хэрэгсэл, аргын тухай заавар”-ын дагуу багажийн хэмжилтийн алдааг илрүүлэх, засварлах, тохируулах үйлдэл |
| 95. | Геодезийн цэг, тэмдэгтийн хамгаалалтын бүс | **Р:**Охранная зона геодезического пункта **E:**Protection zone of geodetic points/marks | Геодезийн цэгийг байгалийн ба хүний хүчин зүйлээр устгаж, гэмтээхээс сэргийлэн хамгаалах зориулалтаар түүний эргэн тойронд хийгдсэн ус зайлуулах суваг шуудуу бүхий хэсэг газар |
| 96. | Геодезийн полигон | **Р:**Полигон геодезический **E:**Geodetic polygon | 1.Геодезийн ажил, сургалт, судалгаа, шинжилгээ, туршилт явуулах хэсэг газар<br>2. Олон өнцөгт геодезийн байгууламж |
| 97. | Масштаб | **Р:**Масштаб **E:**Scale | Газрын хотгор гүдгэр ба түүн дээр байгаа биет юмсыг |

| | | | |
|---|---|---|---|
| | | | газрын зураг, агаарын зураг дээр тодорхой хэмжээгээр жижгэрүүлж дүрсэлснийг илтгэх зэрэг |
| 98. | Хэвтээ масштаб | **P:**Горизонтальный масштаб<br>**E:**Horizontal scale | Инженерийн шугам сүлжээний зураглалын пикет хоорондын газрын гадаргуун зүсэлтийн зураг зохиох масштаб |
| 99. | Босоо масштаб | **P:**Вертикальный масштаб<br>**E:**Vertical scale | Гурван хэмжээст дүрслэл дахь босоо хэрчмийн уртыг бодит уртад харьцуулсан харьцаа |
| 100. | Хилийн тэмдэгтийн солбицол тодорхойлох | **P:**Делиметация государственных границ<br>**E:**Delimitation | Улсын хилийн шугам өнгөрөх талбарын дагуу солбицол тодорхойлж, хэлэлцээрийн дагуу байр зүйн зурагт буулгах үйл явц |
| 101. | Улсын хилийг тэмдэглэх | **P:**Демаркация границ<br>**E:**Demarcation | Улсын хилийг тогтоосон баримт бичгийн дагуу хилийн шугамыг хилийн тэмдэгтээр газар дээр тэмдэглэх үйл явц |
| 102. | Аналитик цэг | **P:**Аналитическая точка<br>**E:**Analytical point | Оптик зай хэмжүүрийн параллактик өнцгийн орой |

## ДЭЛХИЙН ХЭЛБЭР
## ФИГУРА ЗЕМЛИ
## EARTH FIGURE

| | | | |
|---|---|---|---|
| 103. | Дэлхий | **P:**Земля<br>**E:**Earth | Нарны системийн гурав дахь гариг, радиус нь 6371км, масс-6,0x$10^{24}$ кг, дундаж нягт нь 5,517 г/см$^2$, гадаргын талбай нь 510 сая км$^2$, Нарны шар замаар 29,76 км/сек хурдтай, 149,6 сая км зайтай, Нарны цагийн хугацаанд 365 хоног 5 цаг, 46 сек Нарыг нэг удаа бүтэн тойрно. Дэлхий өөрийн тэнхлэгийн дагуу эргэхэд Нарны шар замын хавтгайд 66°33'38,57" налуу өнцөг үүсгэх ба энэ үед өдөр, шөнө солигдоно |
| 104. | Дэлхийн хэлбэр | **P:**Фигура Земли<br>**E:**Earth’s figure | Хүндийн хүчний потенциалын түвшний гадаргатай ойролцоогоор давхцаж байгаа Дэлхийн гадаргын ерөнхий хэлбэр. Дэлхийн ерөнхий хэлбэрийг геоид гадаргаар авна |
| 105. | Геодезийн референц тогтолцоо | **P:**Геодезические референцные системы | Дэлхийн хэлбэр, хэмжээ, татах хүчний орон зайг тодорхойлох үзүүлэлтийг тогтоох тогтолцоо |

| | | | |
|---|---|---|---|
| | | **E:**Geodetic reference systems | |
| 106. | Дэлхийн үндсэн үзүүлэлтүүд | **P:**Основные параметры Земли<br>**E:**Basic parameters of the Earth | Татах хүчний тогтмол ба массын үржвэр, эргэлтийн өнцгийн хурд, экваторын радиус, шахалт, битүүмжлэлийн орчин дэх гэрлийн хурд, Дэлхийн татах хүчний талбайг илэрхийлэгч итгэлцүүр зэрэг нь Дэлхийн үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлно |
| 107. | Дэлхийн эргэх тэнхлэг | **P:**Ось вращения Земли<br>**E:**Earth rotation axis | Дэлхий нь Нар-Дэлхийг дайрсан хавтгайтай харьцуулахад 23.5 градусын хазайлтаар 23 цаг, 56 минут, 4.091 секундийн хугацаанд нэг бүтэн тойргон эргэлт хийх эргэлтийн тэнхлэг |
| 108. | Дэлхийн физик гадарга | **P:**Физическая поверхность Земли<br>**E:**Physical surface of the Earth | Химийн найрлага, физик шинж чанар, бодисын төлөв байдлаараа хоорондоо ялгаатай Дэлхийн соронзон бүрхэвч, хийн мандал, астеносфер, манти, цөм зэрэг харилцан нэг нэгэндээ нэвтэрдэг шүтэлцээ үйлчлэл бүхий Дэлхийн бүрхүүл хэсэг |
| 109. | Геопотенциал | **P:**Геопотенциал<br>**E:**Geopotential | Дэлхийн хүндийн хүчний бодит потенциал |
| 110. | Геопотенциал хэмжигдэхүүн | **P:**Геопотенциальная величина<br>**E:**Geopotential value | Дэлхийн гадарга болон геоидын гадарга дахь өгөгдсөн цэгийн хүндийн хүчний потенциалын ялгаврын утга |
| 111. | Дэлхийн хүндийн хүчний потенциал | **P:**Потенциал силы тяжести<br>**E:**Gravity potential | Дэлхийн хүндийн хүчний орон зайд нэгж жинтэй биетийг, хязгааргүй цэгээс тухайн цэгт шилжүүлэх ажилтай тэнцэх хэмжигдэхүүн |
| 112. | Хүндийн хүчний потенциал *W* (гравиметрийн хайгуул) | **P:**Потенциал силы тяжести, *w (гравиразведка)*<br>**E:**Gravitational potential | *W*(*P*) функцийн градиент хүндийн хүчний утгатай тэнцүү байх тохиолдол. Үүнд *P*-орон зайн цэг |
| 113. | Вариометрийн цэг, тэмдэгт | **P:**Вариометрический пункт<br>**E:**Variometric station | Солбицол болон *Wxz, Wyz, Wxy, WD* хүндийн хүчний потенциалын хосолсон үржвэрүүд нь тодорхой цэг, тэмдэгт |
| 114. | Нормаль потенциал | **P:**Нормальный потенциал<br>**E:**Normal potential | Нормаль эллипсоидын хүндийн хүчний потенциал |

| | | | |
|---|---|---|---|
| 115. | Дэлхийн хүндийн хүчний долгиосол потенциал | **Р:**Возмущающий потенциал силы тяжести Земли<br>**E:**Disturbing potential | Дэлхийн хүндийн хүчний потенциал түүний хэвийн утгын ялгавар |
| 116. | Геоид | **Р:**Геоид<br>**E:**Geoid | Далайн нам тайван тэнцвэртэй нөхцөлд байх үеийн гадаргын шугамыг эх газарт үргэлжлүүлэн татахад үүссэн Дэлхийн хэлбэр |
| 117. | Дэлхийн хүндийн хүчний орны хүчний шугам | **Р:**Силовая линия поля силы тяжести Земли (Силовая линия)<br>**E:**Power line of the Earth's gravity field (Power line) | Тухайн цэг бүрд татсан шахагч шугам, Дэлхийн хүндийн хүчний үйлчлэлийн чиглэлтэй давхацсан орон зайн муруй шугам |
| 118. | Дэлхийн хүндийн хүчний орны шулуун | **Р:**Линия поля силы тяжести Земли<br>**E:**Line of the Earth's gravity field | Цэг болон шүргэгч нь Дэлхийн хүндийн хүчний чиглэлтэй давхцаж байдаг орон зайн муруй |
| 119. | Эгц босоо шулуун | **Р:**Отвесная линия<br>**E:**Plumb line | Хүндийн хүчний чиглэлтэй давхцаж байдаг аливаа биетийн чөлөөтуналтын чиглэлийн шулуун буюу физик гадаргуугийн цэгийн шүргэгчид перпендикуляр шулуун |
| 120. | Эгц босоо шулууны хазайлт | **Р:**Уклонение отвесной линии<br>**E:**Deflection of the plumb line | Эгц босоо шулуун ба тухайн цэгийн Дэлхийн эллипсоидын гадаргууд буулгасан нормаль хоорондох өнцөг |
| 121. | Нормаль шулуун | **Р:**Нормальная линия<br>**E:**Normal line | Эллипсоидын гадаргуу дээрх цэгийн шүргэгчид перпендикуляр шулуун |
| 122. | Нормаль хавтгай | **Р:**Нормальная плоскость<br>**E:**Normal plane | Тухайн цэгийн нормаль шугамыг дайран гарч байгаа бүх хавтгайнууд |
| 123. | Нормаль огтлолууд | **Р:**Нормальное пересечение<br>**E:**Normal intersection | Нормаль хавтгайнууд эллипсоидын гадарга хоёрын огтлол муруй шугам |
| 124. | Анхны эгц босоогийн хавтгай | **Р:**Плоскость начальных вертикальных линий<br>**E:**The plan of the initial plumb lines | Тухайн цэгийн голдчийн хавтгайд перпендикуляр нормаль хавтгай |
| 125. | Анхны эгц босоогийн огтлол | **Р:**Засечка начальных вертикальных линий<br>**E:**Intersection of the initial plumb lines | Харин анхдагч эгц босоогийн хавтгай эллипсоидын гадарга хоёрын огтлол |
| 126. | Анхны босоо дугуй | **Р:**Начальный вертикал<br>**E:**Basic vertical | Гринвичийн одон орны оргилын төв цэг ба хойд, өмнөд туйлуудыг дайрсан дугуй нум |

| | | | |
|---|---|---|---|
| 127. | Эллипсиод | **Р:**Эллипсоид<br>**E:**Ellipsoid | Төрөл бүрийн тооцоолол хийхэд тохиромжтой математик талаасаа судлагдсан Дэлхийн зөв хэлбэр дүрс |
| 128. | Нормаль эллипсоид | **Р:**Нормальный эллипсоид<br>**E:**Normal ellipsoid | Дэлхийн таталцлын оронд хамгийн ойролцоо таталцлын орон үүсгэж байгаа эргэлтийн эллипсоид |
| 129. | Дэлхийн эллипсоид | **Р:**Земной эллипсоид<br>**E:**Earth ellipsoid | Дэлхийн хэлбэр, хэмжээг тодорхойлогч эллипсоид |
| 130. | Дэлхийн ерөнхий эллипсоид | **Р:**Общий земной эллипсоид<br>**E:**Mean earth ellipsoid | Туйлын шахалт нь хамгийн бага эллипсоид |
| 131. | Референц-эллипсоид | **Р:**Референц-эллипсоид<br>**E:**Reference ellipsoid | Дэлхийн бодит биетэд чиглүүлэгдэн тухайн бүс нутгийн хэмжээнд тохирсон геодезийн хэмжилтийн үр дүн боловсруулахад ашиглагддаг ажлын хэмээн нэрлэгдсэн эллипсоид |
| 132. | Үндэсний референц-эллипсоид | **Р:**Нациальный референц эллипсоид<br>**E:**National reference ellipsoid | Монгол Улсын нутаг дэвсгэрийн бодит гадаргыг бүхэлд нь хамгийн их нийцтэй байхаар сонгосон эллипсоид |
| 133. | Красовскийн эллипсоид | **Р:**Эллипсоид Красовского<br>**E:** Krasovsky Ellipsoid | Ф.Н.Красовский ба А.А.Изотов нарын удирдлагаар эрдэмтдийн тодорхойлсон Дэлхийн математик загварын нэг болон хэрэглэгддэг Дэлхийн гадаргын референц эллипсоид |
| 134. | Түвшний эллипсоид | **Р:**Уровенный эллипсоид<br>**E:**Level ellipsoid | Гадаргад нь хүндийн хүчний потенциал ихэнхдээ адил утгатай байх Дэлхийн эллипсоид |
| 135. | Түвшний гадарга | **Р:**Уровенная поверхность<br>**E:**Level surface equipotential surface | Дэлхийн хүндийн хүчний потенциал ямар ч цэгт адил утгатай байх гадарга |
| 136. | Эллипсоид гадарга | **Р:**Эллипсоидальная поверхность<br>**E:**Ellipsoidal surface | Бөмбөрцгийн харилцан перпендикуляр гурван тэнхлэгийн дагуух хэв гажилтаар үүсэх гурван хэмжээст орон зайн гадарга |
| 137. | Тооллын гадарга | **Р:**Отсчетная поверхность<br>**E:**Reference surface | Хүндийн хүчний цэгүүд нь бодогдсон бөмбөрцөг хэлбэрийн түвшний гадарга |
| 138. | Түвшний сфероид | **Р:**Уровенный сфероид **E:**Level spheroid | Гадаргууд нь хүндийн хүчний потенциал ижил адил утгатай байх Дэлхийн сфероид |
| 139. | Сфероид - зууванцаг | **Р:**Сфероид<br>**E:**Spheroid | Эллипс бага тэнхлэгийн дагуу эргэхэд үүссэн биет |

| | | | |
|---|---|---|---|
| 140. | Дэлхийн сфероид | **Р:**Земной сфероид<br>**E:**Earth spheroid | Дэлхийн усан тэнцэллэгийн тэнцвэрт нөхцөл байх үед зөвхөн түүний хэсгүүдийн харилцан таталцлын хүч болон Дэлхийн тодорхой тэнхлэгт эргэх үед төвөөс зугтах хүчний нөлөөнд байх Дэлхийн хэлбэр |
| 141. | Дэлхийн махиа | **Р:**Кривизна Земли<br>**E:**Curvature of Earth | Дэлхийн хэлбэр ба хэмжээнээс нөлөө бүхий түүний гадаргын өөрчлөлт |
| 142. | Астрономийн нивелирдлэг | **Р:**Астрономическое нивелирование<br>**E:**Astronomic(al) levelling | Астроном-геодезийн хэмжилтийн өгөгдлөөр геоидын өндрийг тодорхойлох арга |
| 143. | Астроном-гравиметрийн нивелирдлэг | **Р:**Астрономо-гравиметрическое нивелирование<br>**E:**Astro-gravimetric levelling | Астроном-геодези ба гравиметрийн хэмжилтийн хосолсон өгөгдлөөр геоидын өндрийг тодорхойлох арга |
| 144. | Геоидын өндөр | **Р:**Высота геоида<br>**E:**Geoid height | Дэлхийн эллипсоидын гадаргад татсан нормалийн дагуу тухайн цэг дахь геоидын гадаргын өндөр |
| 145. | Эллипсиод өндөр $h$ | **Р:**Эллипсоидальная высота $h$<br>**E:**Ellipsoidal height $h$ | Эллипсиодод перпендикуляр татсан шугамын дагуу эллипсоидоос тухайн цэг хүртэлх зай, хэрвээ зайг эллипсоидын хавтгайгаас дээш нь авсан бол нэмэх утгатай байна. *ТАЙЛБА**Р:**Үүнийг зөвхөн гурван хэмжээст эллипсиод солбицлын тогтолцооны нэг хэсэг шиг ашиглахаас гадна, солбицлын тогтолцоонд өөрт нь огт хэрэглэдэггүй.* |
| 146. | Квазигеоид | **Р:**Квазигеоид (бараг геоид)<br>**E:**Quasigeoid (almost geoid) | Астрономи-геодезийн цогц хэмжилтийн үр дүнгээр тооцоолон бодож гаргасан геоидтой төстэй Дэлхийн хэлбэртэй ойролцоо гадарга. *Тайлбар: Квазигеоидын өндрийг эллипсоидын гадаргаас тоолно.* |
| 147. | Квазигеоидын өндөр | **Р:**Высота квазигеоида<br>**E:**Quasigeoid height | Ортометрийн өндөр, нормаль өндөр хоорондын зөрүү |
| 148. | Эхлэл өгөгдөл | **Р:**Исходная дата<br>**E:**Datum | Солбицлын тогтолцооны чиглэл, масштаб, эхлэлийн байршил зэргийг тодорхойлдог үзүүлэлт буюу үзүүлэлтийн багц |

| | | | |
|---|---|---|---|
| | | | Референц эллипсоид дээрх эхлэл цэгийн геодезийн уртраг, өргөрөг, эхлэл чиглэлийн геодезийн зовхис, эхлэл цэг дээрх эгц босоо шугамын хазайлтыг байгуулагч, эхлэл цэгийн геоидын (квазигеоидын) өндөр зэрэг үзүүлэлтүүд |
| 149. | Геодезийн эхлэл өгөгдөл | **Р:**Исходные геодезические даты **E:**Geodetic datum | Астрономи ба геодезийн солбицлын тогтолцооны үндсэн хавтгай ба тэнхлэгийг тодорхойлох болон Дэлхийн биетэд референц эллипсоидын чиглэлийн үзүүлэлтийг заах гурван хэмжигдэхүүн |
| 150. | Их-хагас тэнхлэг- *a* | **Р:**Большая полуось- *a* **E:**Semi-major axis- *a* | Эллипсиодын их тэнхлэгийн диаметрийн хагас буюу эллипсоидын хамгийн их радиус |
| 151. | Бага-хагас тэнхлэг- *b* | **Р:**Малая полу ось- *b* **E:**Semi-minor axis-*b* | Эллипсиодын бага тэнхлэгийн диаметрийн хагас буюу эллипсоидын туйлын тэнхлэг |
| 152. | Эллипсоидын шахалт | **Р:**Сжатие эллипсоида **E:**Flattening of the ellipsoid | Эллипсоидын их ба бага хагас тэнхлэгийн зөрүүг эллипсоидын их хагас тэнхлэгт харьцуулсан харьцаа: $\boldsymbol{\alpha} = (\boldsymbol{a} - \boldsymbol{b})/\boldsymbol{a}$ |
| 153. | Экватор | **Р:**Экватор **E:**Equator | Хоёр туйлаас адил зайнд орших дэлхийг ороосон хамгийн том цагариг буюу Дэлхийн эргэлтийн тэнхлэгтэй перпендикуляр хавтгайн Дэлхийн гадаргатай огтлолцож буй шугам. *Тайлбар: Экваторын урт 40075696 м (Красовскийн тодорхойлсноор), WGS-84 солбицлоор 40075017 м* |
| 154. | Геодезийн экватор | **Р:**Геодезический экватор **E:**Geodetic equator | Төвийг нь дайрсан бага тэнхлэгт нь перпендикуляр хавтгайгаар референц-эллипсоидыг огтлоход түүний мөрөөр үүсэх цагариг |
| 155. | Тэнгэрийн экватор | **Р:**Небесный экватор **E:**Celestial equator | Огторгуйн эргэлтийн тэнхлэгт перпендикуляр хавтгайд орших тэнгэрийн бөмбөрцгийн хамгийн том цагариг |
| 156. | Соронзон экватор | **Р:**Экватор магнитный **E:**Magnetic equator | Дэлхийн бөмбөрцөг дээрх цэгийн соронзон хазайлт тэгтэй тэнцүү байх ижил хазайлттай шулуун |
| 157. | Дундаж экватор | **Р:**Средний экватор **E:**Average equator | Дэлхийн эргэлтийн дундаж тэнхлэгт перпендикуляр бүхий түүний массын төвийг дайрах хавтгай |

| | | | |
|---|---|---|---|
| 158. | Бөмбөрцгийн илүүдэл | **P:**Сферический избыток **E:**Spherical excess | Том дугуйн нумаар үүссэн бөмбөрцгийн олон өнцөгтүүдийн нийлбэр ба хавтгай дээрх олон өнцгүүдийн нийлбэр хоёрын зөрүү |
| 159. | Бөмбөрцгийн гурвалжин | **P:**Треугольник сферический **E:**Spherical triangle | Том дугуйн гурван нум огтлолцоход үүссэн бөмбөрцгийн гадарга дээрх гурвалжин |
| 160. | Босоо хавтгай | **P:**Плоскость вертикальная **E:**Vertical plane | Тухайн цэгийг дайрсан эгц босоо шугамын дагуу өгөгдсөн хавтгай |
| 161. | Экваторын хавтгай | **P:**Плоскость экватора **E:**Equatorial plane | Дэлхийн төвийг дайрах түүний эргэлтийн тэнхлэгтэй перпендикуляр хавтгай |
| 162. | Геодезийн шулуун | **P:**Геодезическая линия **E:**Geodetic distance | Математик аргаар тодорхойлсон эллипсоид гадарга дээрх аливаа хоёр цэгийн хоорондох хамгийн богино зай |
| 163. | Голдоч | **P:**Меридиан **E:**Meridian | Эллипсоидын туйлуудыг холбож тухайн цэгийг дайрсан нум *Тайлбар: Энэ нэр томьёо нь энэ утгаас илүүтэйгээр туйлуудыг холбосон нум гэдэг утгаар түлхүү хэрэглэгддэг.* Дэлхийн бөмбөрцгийн өгөгдсөн нэг цэг ба дэлхийн эргэлтийн тэнхлэгийг дайрсан хавтгайгаар огтлоход үүсэх тойргийн хагас буюу нумыг цэгийн голдоч гэнэ |
| 164. | Анхны голдоч | **P:**Начальный меридиан **E:**Prime meridian | Эхлэлийн хэмээн Дэлхийн хэмжээнд авч үздэг Гринвичийн голдоч *Тайлбар.Геодезийн өгөгдөлд ихэвчлэн Гринвичийн голдоч ашиглана.* |
| 165. | Гринвичийн голдоч | **P:**Гринвический меридиан **E:**Greenwich meridian | Английн Нэгдсэн Вант Улсын Эзэн Хааны Гринвичийн одон орны оргилын астрономийн хэмжилтийн дурангийн их дугуйн хавтгайг дайрч буй голдоч |
| 166. | Тэнгэрийн голдоч | **P:**Меридиан небесный **E:**Celestial meridian | Тэнгэрийн оройн цэг ба зогсож буй цэгийн оройн цэгийг дайрч өнгөрөх тэнгэрийн бөмбөрцгийн том цагариг |
| 167. | Зураг зүйн голдоч | **P:**Меридиан картографический **E:**Cartographic meridian | Дэлхийг бөмбөрцөг гадаргуу гэж үзэхэд түүний эргэлтийн тэнхлэгийг дайрсан хавтгайгаар огтлоход үүсэх шугам |
| 168. | Голдчийн нум | **P:**Дуга меридиана **E:**Meridian arc | Дэлхийн бөмбөрцөг буюу эллипсоидын хоёр өөр өргөргийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | цэгүүдийн хоорондох голдчийн хэсэг |
| 169. | Голдчийн нумын урт | **Р:**Длина дуги меридиана<br>**E:**Length of meridian arc | Өгөгдсөн голдоч дээр орших хоёр зэргэдийн хооронд хэмжигдэх зай |
| 170. | Голдчуудын ойртолт | **Р:**Сближение меридианов<br>**E:**Meridian convergence | Тухайн цэгийг дайрах голдоч ба тэнхлэгийн голдоч эсвэл түүнтэй зэрэгцээ шугам хоорондын өнцөг<br>*Тайлбар:Дэлхийн эллипсоидын хавтгайд буулгах Тусгагийн сонголтоос хамаарч геодезийн голдчийн ойртолт, Гауссын голдчийн ойртолт гэж ангилна* |
| 171. | Зэргэд | **Р:**Параллель<br>**E:**Parallel | Гаригийн гадаргын хавтгай, экваторын зэрэгцээ хавтгайтай огтлолцох шулуун<br>Дэлхийн бөмбөрцгийн экваторын хавтгайтай параллель хавтгайгаар огтлоход үүсэх тойргийн нумыг зэргэд гэнэ |
| 172. | Зэргэдийн нум | **Р:**Длина дуги параллели<br>**E:**Length of parallel arc | Өгөгдсөн зэргэд дээр орших хоёр голдчийн хооронд хэмжигдэх зай |
| 173. | Уртраг | **Р:**Долгота<br>**E:**Longitude | Анхны голдочтой харьцуулсан бөмбөрцгийн хэд хэдэн солбицол (газар зүйн, газрын соронзон, эрхсийн, нарны шар замын зэрэг солбицлууд)-ын тогтолцоонуудын нэг солбицол |
| 174. | Геодезийн уртраг Эллипсиод уртраг $\lambda$ өнцөг | **Р:**Геодезическая долгота, эллипсоидальная долгота угол λ<br>**E:**Geodetic longitude ellipsoidal longitude λ angle | Анхны голдчийн хавтгай болон тухайн цэгийн голдчийн хавтгай хооронд үүсэх талст өнцөг бөгөөд голдчоос зүүн тийш эерэг утгатай байна |
| 175. | Астрономийн уртраг | **Р:**Астрономическая долгота<br>**E:**Astronomical longitude | Анхны голдчийн хавтгай ба газрын гадарга дээр байгаа цэгийн астрономийн голдчийн хавтгай хоёрын хооронд үүсэх талст өнцөг |
| 176. | Газар зүйн уртраг | **Р:**Географическая долгота<br>**E:**Geographic longitude | Анхны голдчийн хавтгай ба газрын гадарга дээр байгаа цэгийн геодезийн голдчийн хавтгай хоёрын хооронд үүсэх талст өнцөг |
| 177. | Эллипсоид өргөрөг, | **Р:**Эллипсоидальная | Экваторын хавтгай болон тухайн цэгийг дайруулан эллипсоидод |

| | | | |
|---|---|---|---|
| | геодезийн өргөрөг φ өнцөг | широта, геодезическая широта $\varphi$ угол<br>**E:**Ellipsoidal latitude geodetic latitude $\varphi$ angle | перпендикуляр татсан шугам хоёрын хоорондох өнцөг, экватороос хойшоо эерэг утгатай байна. |
| 178. | Эклиптик-Нарны шар зам | **P:**Эклиптика<br>**E:**Ecliptic | Тэнгэрийн бөмбөрцгийн том цагариг, нарны харагдах, жилийн хөдөлгөөн явагдах тэнгэрийн бөмбөрцгийн том цагариг |
| 179. | Тооллын шулуун | **P:**Отсчетная линия<br>**E:**Reference line | Солбицлын тогтолцоонд солбицлын тоолол эхлэх шулуун |

**АСТРОНОМИЙН ОЙЛГОЛТ**
**АСТРОНОМИЧЕСКИЕ ПОНЯТИЯ**
**ASTRONOMICAL CONCEPTS**

| | | | |
|---|---|---|---|
| 180. | Астрономи, Одон орны судлал | **P:**Астрономия<br>**E:**Astronomy | Тэнгэрийн эрхсийн бүтэц ба хөгжлийг судалдаг шинжлэх ухаан |
| 181. | Бөмбөрцгийн астрономи | **P:**Сферическая астрономия<br>**E:**Spherical astronomy | Ажиглалтын цэг дээрээс тэнгэрийн одны байрлал ба чиглэлийг тодорхойлох ерөнхий арга ажиллагааг судалдаг одон орон судлалын салбар ухаан |
| 182. | Геодезийн астрономи, Астрономи-геодези | **P:**Геодезическая астрономия<br>**E:**Geodetic astronomy | Нар, Одны хэмжилтийн багажаар астрономийн буюу газар зүйн солбицлууд, зовхисыг тодорхойлох аргыг судалдаг астрономийн ба геодезийн салбар ухаан<br>Од, гариг, сар болон сансрын бусад биетийн чиглэлийг ажиглах замаар уртраг, өргөрөг, азимутыг тодорхойлох шинжлэх ухааны салбар |
| 183. | Астрометр | **P:**Астрометрия<br>**E:**Astrometry | Тэнгэрийн эрхсийн байрлал, тэдгээрийн цаг хугацааны өөрчлөлт, Дэлхийн эргэлтийг судлах, астрономийн нарийн цагийг хэмжих, астрономийн тогтмолыг тодорхойлох астрономийн суурь салбар ухаан |
| 184. | Дадлагын астрономи | **P:**Практическая астрономия<br>**E:**Practical astronomy | Газар зүйн солбицол олох, тэнгэрийн эрхсийн солбицол тодорхойлох, нарийн цагийг тооцоолох, зовхисыг олох асуудлыг шийдвэрлэдэг астрометрийн ухааны нэг хэсэг |

| | | | |
|---|---|---|---|
| 185. | Астрономийн өргөрөг | **Р:**Астрономическая широта **Е:**Astronomic (al) latitude | Дэлхийн эргэлтийн тэнхлэгтэй перпендикуляр хавтгай ба тухайн цэгийн эгц босоо шугам хооронд үүссэн өнцөг |
| 186. | Астрономийн голдчийн хавтгай | **Р:**Плоскость астрономического меридиана **Е:**Astronomic (al) meridian | Дэлхийн эргэлтийн тэнхлэгтэй зэрэгцээ, тухайн цэгийн эгц босоо шугамыг дайрах хавтгай |
| 187. | Астрономийн орой | **Р:**Астрономический зенит **Е:**Astronomic(al) zenith | Эгц босоо шугамын тэнгэрийн бөмбөрцөгтэй огтлолцсон цэг |
| 188. | Орой | **Р:**Зенит **Е:**Zenith | Тэнгэрийн бөмбөрцөгтэй Дэлхийн эллипсоидын гадаргад нормаль эсвэл эгц босоо шугам огтлолцох цэг |
| 189. | Оройн зай | **Р:**Зенитное расстояние **Е:**Zenith distance | Тухайн цэгийн оройн цэг болон газрын гадарга дээрх цэг хүртэл хэмжигдсэн босоо өнцөг |
| 190. | Астрономийн оройн зай | **Р:**Астрономическое зенитное расстояние **Е:**Astronomic (al) zenith distance | Тухайн цэгээс астрономийн оройн цэг болон хоёр дахь цэг рүү харсан чиглэлийн хоорондох өнцөг |
| 191. | Астрономийн зовхис | **Р:**Астрономический азимут **Е:**Astronomic (al) azimuth | Тухайн цэгийг дайран гарсан астрономийн голдчийн хавтгай ба тодорхой чиглэлийг дайран гарсан босоо хавтгай хоорондох цагийн зүүний дагуу туйл руу харсан чиглэлээс тоолсон хоёр талст өнцөг |
| 192. | Астрономийн нэгж | **Р:**Астрономическая единица **Е:**Astronomical unit | AU үсгээр тэмдэглэх Дэлхийгээс Нар хүртэлх зай |
| 193. | Астрономийн солбицлууд | **Р:**Астрономические координаты **Е:**Astronomic(al) coordinates | Дэлхийн эргэлтийн тэнхлэгийн хавтгай болон астрономийн анхны голдочтой перпендикуляр хавтгайтай харьцангуй орон зайн тухайн цэг дахь эгц босоо шулууны бүрдлүүд |
| 194. | Астрономийн тодорхойлолт | **Р:**Астрономические определения **Е:**Astronomical definitions | Геодезийн зорилгоор астрономийн өргөрөг, уртраг, зовхис тодорхойлох технологийн үйлдэл |
| 195. | Астрофизик | **Р:**Астрофизика **Е:**Astrophysics | Астрономи судлалд физик, химийн шинжлэх ухаан ашиглах салбар |
| 196. | Космолог | **Р:**Космология **Е:**Cosmology | Орчлонт ертөнц судлал, сансар судлал |
| 197. | Селенограф | **Р:**Селеография | Сарны гадарга судлалын ухаан |

| | | | |
|---|---|---|---|
| | | **E:**Selenography | |
| 198. | Астрограф | **P:**Астрограф<br>**E:**Astrograph | Тэнгэрийн эрхсийн зураг авах астрономийн багаж |
| 199. | Астроляб | **P:**Астролябия<br>**E:**Astrolabe | Тэнгэрийн одны байрлалыг тодорхойлох өнцөг хэмжилтийн эртний багаж |
| 200. | Терминатор | **P:**Терминатор<br>**E:**Terminator | Тэнгэрийн аливаа эрхэс дээр өдөр, шөнийн заагийн шугам |
| 201. | Агаар | **P:**Атмосфера<br>**E:**Atmosphere | Дэлхийн мандлыг бүрдүүлж байгаа байгалийн хийн хольц, түүнтэй холбоотой хүндийн хүч ба бусад гариг, огторгуйн биетүүд, нар, одны хийн бүрхүүл |
| 202. | Альбедо | **P:**Альбадо<br>**E:**Albedo | Объектын гадаргын гэрэл ойлгох чадвар |
| 203. | Альмукантарат (астрономид) | **P:**Альмукантарат (астр.)<br>**E:**Almucantarat (aster.) | Тэнгэрийн хавтгайтай зэрэгцээ аливаа тэнгэрийн дурын бага тойрог бөгөөд альмукантаратын бүх цэгүүд хавтгайд ижил өндөртэй байна |
| 204. | Аберрац гажиг | **P:**Аберрация<br>**E:**Aberration | Оптик багажаар аливаа биет юмсыг харахад дүрс гажилттай эсвэл тодорхой биш бүдгэрч харагдах гажиг үзэгдэл |
| 205. | Астрономийн аберрац | **P:**Аберация астрономическая<br>**E:**Astronomical aberration | Тэнгэрийн оддыг харж чиглэлийг тодорхойлж байгаа эцсийн үр дүнд, Нарыг Дэлхий тойрох жилийн хөдөлгөөн, Дэлхий өөрийн тэнхлэгээр хоногт тойрон эргэх эргэлтийн улмаас үүсэх нөлөөлөл |
| 206. | Агаарын займраа, рефракц | **P:**Рефракция атмосферная<br>**E:**Atmospheric refraction | Агаарын давхаргуудын ижил бус байдлаас шалтгаалан гэрлийн цацрагийн тархах чиглэл мурийж өөрчлөгдөх үзэгдэл |
| 207. | Босоо рефракц | **P:**Рефракция вертикальная<br>**E:**Vertical refraction | Хэмжиж буй цэг дээр үүсэх харах цацрагийн нумын шүргэгч ба харж буй цэг рүү авсан шулуун хорын хооронд үүсэх босоо өнцөг бөгөөд тригонометр(геодезийн)-ийн нивелирдлэгт тооцно |
| 208. | Хэвтээ рефракц | **P:**Рефракция горизонтальная<br>**E:**Horizontal refraction | Хэмжилт хийж буй цэг дээрээс үүсэх харах цацрагийн нумын шүргэгч ба харж буй цэг рүү авсан шулуун хооронд үүсэх хэвтээ өнцөг |
| 209. | Бөмбөрцгийн аберрац | **P:**Аберрация сферическая<br>**E:**Spherical aberration | Ажиглаж байгаа биетээс ирж байгаа гэрлийн цацрагууд дурангийн объективийг дайрч |

| | | | |
|---|---|---|---|
| | | | хугарч өнгөрөхдөө нэг цэгт цуглахгүйн улмаас дүрс бүдгэрч бүүдгэр харагдах үзэгдэл |
| 210. | Эгц босоо шулуун /Астрономид/ | **Р:**Вертикал в астрономии<br>**E:**Vertical in astronomy | Ажиглалт хийж буй цэгийн оройг дайрч буй тэнгэрийн бөмбөрцгийн тойм тойргууд |
| 211. | Дэлхийгээс алсрах цэг | **Р:**Апогей<br>**E:**Apogee | Сарны тойрог замын манай Дэлхийгээс хамгийн хол орших цэг |
| 212. | Алсрах цэг | **Р:**Афелий (астр.)<br>**E:**Aphelios | Нарнаас тэнгэрийн эрхсийн тойрог замын хамгийн хол алсрах цэг |
| 213. | Надир цэг | **Р:**Надир<br>**E:**Nadir | Дэлхийн эллипсоидын гадаргад эгц босоо шулуун ба эгц шулууны (нормаль) түвшний хавтгайгаас доош орших тэнгэрийн бөмбөрцөгтэй огтлолцох цэг |
| 214. | Наранд ойртох цэг | **Р:**Перигелий (астр.)<br>**E:**Perihelion | Тэнгэрийн эрхэс (гариг, сүүлт од)-ын тойрог Наранд хамгийн ойртох цэг |
| 215. | Астрономийн голдоч буюу жинхэнэ голдоч | **Р:**Астрономический меридиан<br>**E:**Astronomical meridian | Геоидын гадарга астрономийн хавтгайтай огтлолцох шулуун |
| 216. | Голдоч дайрах | **Р:**Кульминация<br>**E:**Culmination | Од тэнгэрийн голдчийг дайрч өнгөрөх агшин. *Тайлбар:Дээд ба доод голдоч дайрах гэж байна.* |
| 217. | Доод голдоч дайрах | **Р:**Нижняя кульминация<br>**E:**Lower culmination | Од тэнгэрийн голдчийг дээгүүр дайрч өнгөрөх агшин |
| 218. | Дээд голдоч дайрах | **Р:**Верхняя кульминация<br>**E:**Upper culmination | Од тэнгэрийн голдчийг доогуур дайрч өнгөрөх агшин |
| 219. | Бөмбөрцгийн тригонометр | **Р:**Сферический тригонометрия<br>**E:**Spherical trigonometry | Бөмбөрцгийн гурвалжны элементүүдийн хоорондын харьцааг судлах ухаан |
| 220. | Дэлхийн бөмбөрцөг | **Р:**Земной шар<br>**E:**Globe | Дэлхийн массын төвд төвтэй, дундаж радиустай тэнцүү тойргийг эргэлтийн тэнхлэгийн дагууд эргүүлэхэд үүсэх биет |
| 221. | Тэнгэрийн бөмбөрцөг | **Р:**Небесная сфера<br>**E:**Celestial sphere | Тэнгэрийн одод (эрхэс)-ын харилцан байрлал ба харагдах хөдөлгөөнийг судлах үед бөмбөрцгийн астрономид ашигладаг математик төсөөллийн бөмбөрцөг |
| 222. | Нутац | **Р:**Нутация (астр.)<br>**E:**Nutation (aster.) | Нар, Сарны татах хүчний нөлөөгөөр Дэлхийн эргэлтийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | тэнхлэгийн маш хэмжээний хэлбэлзэл ($9^0$ хүртэл) |
| 223. | Прецесс | **Р:**Прецессия<br>**E:**Precession | Эргэлдэж байгаа эрхсийн тэнхлэгийг тайван байдлаас гаргахад анхны байрлалыг тойрон, нэмэлт эргэлтэд орохуй үзэгдэл |
| 224. | Эрхэс | **Р:**Астероид<br>**E:**Asteroid | Нарыг тойрон эргэлддэг тэнгэрийн хатуу биетүүд буюу жижиг гаригууд |
| 225. | Өдөр шөнийн тэнцэл | **Р:**Равноденствие<br>**E:**Equinox | Тэнгэрийн бөмбөрцөг дээр Нарны жилийн эргэлтийн төв, хавар, намрын тэнцлийн цэг дээр тэнгэрийн экватор огтлолцох үеийн хугацаа |
| 226. | Тэнцлийн цэг | **Р:**Точка равноденствии (астр.)<br>**E:**Point equinoxes | Нарны шар зам тэнгэрийн экватортай огтлолцох цэг. Хаврын тэнцлийн цэг (III сарын 21), намрын тэнцлийн цэг (IX сарын 23) |
| 227. | Гэрлийн жил | **Р:**Световой Год<br>**E:**Light year | Гэрлийн цацраг нэг жилийн хугацаанд туулах замын урт |

## ХҮНДИЙН ХҮЧ
## СИЛА ТЯЖЕСТИ
## GRAVITY

| | | | |
|---|---|---|---|
| 228. | Чөлөөт уналтын хурдатгал тодорхойлох динамик арга | **Р:**Динамический метод<br>**E:**Dynamic method | Таталцлын орон зайд биетийн хөдөлгөөнийг судлах замаар чөлөөт уналтын хурдатгал тодорхойлох арга |
| 229. | Чөлөөт уналтын хурдатгал тодорхойлох статик арга | **Р:**Статический метод<br>**E:**Static method | Хүндийн хүч ба харьцуулах хүчний үйлчлэлийн нөлөөгөөр үүсэх биетийн тэнцвэрийн байрлалын өөрчлөлтийг бүртгэх замаар чөлөөт уналтын хурдатгал тодорхойлох арга |
| 230. | Хүндийн хүч | **Р:**Сила тяжести<br>**E:**Gravity | Биетийн массын нэгжид шилжүүлсэн Дэлхийн өөрийн эргэлтийн тэнхлэгт тэнцүү үйлчлэх татах хүч ба төвд тэмүүлэх хүч |
| 231. | Хүндийн хүчний орон зай | **Р:**Поле (силы) тяжести **E:**Gravity field | Цэг бүрд хэд хэдэн хүндийн хүчний утга тохирох орон зайн хүрээ |
| 232. | Дэлхийн хүндийн хүч | **Р:**Сила тяжести Земли **E:**Earth gravity | Дэлхийн эргэлтийн төвөөс зугтах хүч, татах хүч зэргээс бүрдэх таталцлын масст Дэлхийн ба бусад гариг эрхсийн нөлөөлөх хүч |

| | | | |
|---|---|---|---|
| 233. | Хүндийн хүчний градиент | **Р:**Градиент силы тяжести<br>**E:**Gravity gradient | Солбицлын Декартын тогтолцоонд буулгасан векторын тусгаг энэ тогтолцооны тэнхлэгийн дагуух хүндийн хүчний эхний уламжлалын тоон утгатай тэнцүү байх утга |
| 234. | Хүндийн хүчний босоо градиент | **Р:**Вертикальный градиент силы тяжести<br>**E:**Vertical gravity gradient | Эгц босоо шугамын дагуу хүндийн хүчний өөрчлөгдөх хурдыг илэрхийлэх хэмжигдэхүүн |
| 235. | Хүндийн хүчний хэвтээ градиент | **Р:**Горизонтальный градиент силы тяжести<br>**E:**Horizontal gravity gradient | Хэвтээ чиглэлд хүндийн хүчний өөрчлөгдөх хурдыг илэрхийлэх хэмжигдэхүүн |
| 236. | Хүндийн хүчний хурдатгалын градиент | **Р:**Градиент ускорения силы тяжести<br>**E:**The gradient gravity acceleration | Хүндийн хүчний хурдатгалаас орон зайн солбицлуудын тэнхлэгүүдээр авсан эхний уламжлалын тоон утга<br>*Жич:Хүндийн хүчний хурдатгалын градиентийг хэвтээ ба босоо гэж ялгана.* |
| 237. | Хүндийн хүчний хамааралгүй хэмжилт | **Р:**Независимые измерения (силы) тяжести<br>**E:**Independent gravity measurement | Гравиметрийн цэг дээр өөр өөр цаг хугацаанд, өөр өөр багаж, гүйцэтгэгч хийсэн хэмжилт |
| 238. | Хүндийн хүчний үнэмлэхүй тодорхойлолт | **Р:**Абсолютное определение силы тяжести<br>**E:**Absolute determination of gravity | Биетийн чөлөөт уналтын хурдатгалыг хэмжих замаар хүндийн хүчийг шууд хэмжих арга |
| 239. | Чөлөөт уналтын хурдатгал | **Р:**Ускорение свободного падения<br>**E:**Free fall Acceleration | Хүндийн хүчний орон зайд биетийн авах хурдатгалын хэмжээ |
| 240. | Хүндийн хүчний хурдатгал | **Р:**Ускорение силы тяжести Земли<br>**E:**Gravitational acceleration | Хүндийн хүчний орон зайд биетийн чөлөөт уналтаар унаж буй хурдатгалын утга |
| 241. | Хүндийн хүчний нормаль хурдатгал | **Р:**Нормальное ускорение силы тяжести<br>**E:**Normal gravitational acceleration | Дэлхийн онолын загварт тохирсон хүндийн хүчний хурдатгалын утга |

| | | | |
|---|---|---|---|
| 242. | Хүндийн хүчний ердийн утга | **P:**Нормальное значение силы тяжести Нормальная сила тяжести **E:**Normal gravity value | Дэлхийн онолын загварт тохирсон хүндийн хүчний тоон утга |
| 243. | Хүндийн хүчний хурдатгалын өсөлт | **P:**Приращение ускорения силы тяжести **E:**The increment acceleration gravity | Эхлэлийн ба тодорхойлж буй цэг (тулгуур) хоорондын хүндийн хүчний хурдатгалын зөрүү |
| 244. | Хүндийн хүчний хурдатгалын өөрчлөлт | **P:**Вариации ускорения силы тяжести **E:**Variations of gravity acceleration | Далайн усны түвшний өөрчлөлт, Дэлхийн массын байрлал, тэнгэрийн эрхсүүдийн нөлөөллөөс үүсэх тухайн цэг дэх хүндийн хүчний хурдатгалын цаг хугацааны өөрчлөлт |
| 245. | Хүндийн хүчний өөрчлөлт | **P:**Вариация (силы) тяжести **E:**Gravity variation | Тухайн цэг дахь хүндийн хүчний цаг хугацааны өөрчлөлт |
| 246. | Түрэлтээс хамаарах хүндийн хүчний хурдатгалын өөрчлөлт | **P:**Приливные вариации ускорения силы тяжести **E:**Tidal variations of gravity acceleration | Дэлхий, нар, сар ба гаригуудын харилцан үйлчлэлээс үүсэх хүндийн хүчний хурдатгалын өөрчлөлт |
| 247. | Түрэлтээс үл хамаарах хүндийн хүчний хурдатгалын өөрчлөлт | **P:**Неприливные вариации ускорения силы тяжести **E:**Unpleasant gravity acceleration variations | Дэлхий, нар, сар ба гаригуудын хөдөлгөөнөөс үл хамаарах хүндийн хүчний хурдатгалын өөрчлөлт |
| 248. | Хүндийн хүчийг хөрвүүлэх | **P:**Редукция силы тяжести **E:**Gravity reduction | Газрын гадарга дээр хэмжсэн хүндийн хүчний холбогдолд түүнийг геоид ба өгөгдсөн түвшний гадаргад шилжүүлэх зорилгоор өгсөн засвар |
| 249. | Гадаргын засвар | **P:**Поправка за рельеф **E:**Terrain (topographic) correction | Орчны газрын гадаргын массын үүсгэж байгаа нөлөөллийг арилгах зорилгоор хүндийн хүчний хэмжилтийн үр дүнд хийх засвар |
| 250. | Хонкасало засвар | **P:**Поправка Хонкасало **E:**Honkasalo amendment | Хүндийн хүчний хурдатгалын хэмжилтийн үр дүнд өгөх өргөргөөс хамаарах нар, сарны цаг хугацааны байнгын нөлөөллийн засвар |

## ГРАВИМЕТРИЙН ШИНЖЛЭХ УХААН
## ГРАВИМЕТРИЯ, GRAVIMETRY

| | | | |
|---|---|---|---|
| 251. | Гравиметрийн шинжлэх ухаан | **P:**Гравиметрия **E:**Gravimetry | Дэлхий болон бусад гаригуудын биетийн таталцлын орон, хүндийн хүчний элементүүдийн өөрчлөлтийг хэмжих, тэдгээрийн үр дүнг шинжлэх ухаан, эдийн засаг, техникийн төрөл бүрийн салбарт ашиглах тухай шинжлэх ухаан |
| 252. | Геодезийн гравиметр | **P:**Гравиметрия геодезическая **E:**Geodesic gravimetry | Дэлхийн хэлбэр хэмжээг тодорхойлох геодезийн хэмжилтийн асуудлыг шийдвэрлэх, геодезийн хэмжилтийг эллипсоидын гадаргад хөрвүүлэх, геодезийн төрөл бүрийн солбицлын тогтолцоо хоорондын холбоог тогтоох, Дэлхийн хиймэл дагуул, пуужингийн тойрог замын уртыг бодох гравиметрийн салбар шинжлэх ухаан |

## ГРАВИМЕТРИЙН БАГАЖ
## ГРАВИМЕТР
## GRAVIMETER

| | | | |
|---|---|---|---|
| 253. | Гравиметр багаж | **P:**Гравиметр **E:**Gravimeter | Тооллын төхөөрөмжид бүртгэгддэг хүндийн хүчний хурдатгалын өөрчлөлтийг тодорхойлох нарийн мэдрэмтгий системтэй гравиметрийн багаж. *Тайлбар: зориулалтаар нь газрын, тэнгисийн, гүний, уурхайн, агаарын гравиметр гэж нэрлэнэ.* |
| 254. | Газрын гравиметр | **P:**Наземный гравиметр **E:**Land gravimeter | Газрын гадаргын хүндийн хүчний хурдатгал хэмжилтийн гравиметр |
| 255. | Абсолют гравиметр | **P:**Абсолютный гравиметр **E:**Absolute gravimeter | Ашигт малтмалын эрэл хайгуулд зориулсан гравиметр |
| 256. | Статик гравиметр | **P:**Статический гравиметр **E:**Static gravimeter | Хүндийн хүчний үйлчлэлийг тэнцвэржүүлэх уян хүчдэлтэй гравиметр |
| 257. | Пүрштэй гравиметр | **P:**Пружинный гравиметр **E:**Spring gravimeter | Хүндийн хүчийг уян хүчтэй пүршээр тэнцвэржүүлэх статик гравиметр |
| 258. | Агаарын гравиметр | **P:**Аэрогравиметр **E:**Aerogravimeter Airborne gravimeter | Нисэх төхөөрөмжөөс хэмжилт хийх зориулалтын гравиметр |

| | | | |
|---|---|---|---|
| 259. | Баллистик гравиметр | **Р:**Баллистический гравиметр **E:**Ballistic gravimeter | Биетийн чөлөөт уналтын замын хэсгийн урт, хугацааны хэмжилтэд тулгуурлан хүндийн хүчний хурдатгалыг тодорхойлох гравиметрийн багаж |
| 260. | Хийн гравиметр | **Р:**Газовый гравиметр **E:**Gas gravimeter | Битүү саванд байгаа хийн даралтын өөрчлөлтийг ашиглаж хүндийн хүчний хурдатгалын өөрчлөлтийг тодорхойлох гравиметрийн багаж |
| 261. | Гүний усны гравиметр | **Р:**Донный гравиметр **E:**Base (underwater) gravimeter | Усны сав газрын ёроолын хүндийн хүчний хурдатгал тодорхойлох гравиметр |
| 262. | Металл гравиметр | **Р:**Металлический гравиметр **E:**Metal gravimeter | Мэдрэмтгий системийг металлаар хийсэн хүндийн хүчний хурдатгал тодорхойлох гравиметр |
| 263. | Цахиуран гравиметр | **Р:**Кварцевый гравиметр **E:**Quartz gravimeter | Мэдрэмтгий системийг нь зөөлөн цахиураар хийсэн гравиметр |
| 264. | Дүүжмэг багаж | **Р:**Маятниковый прибор **E:**Pendular device | Хүндийн хүчний хурдатгалыг дүүжмэгийн хэлбэлзлийн функцийн үзүүлэлтээр тодорхойлох гравиметрийн багаж |
| 265. | Гар утасны гравиметр | **Р:**Мобильный гравиметр **E:**Mobile gravimeter | Хүндийн хүчний хурдатгалыг гар утсаар тодорхойлох хэрэгсэл |
| 266. | Гравиметрийн хэмжилтийн багтаамж | **Р:**Диапазон работы гравиметра **E:**The range of the gravimeter | Гравиметрийн системийн тохиргоог өөрчлөхгүйгээр хүндийн хүчний хурдатгалын зөрүүг тодорхойлох хязгаар |
| 267. | Хязгаарлагдсан багтаамжтай гравиметр | **Р:**Узкодиапазонный гравиметр **E:**Narrow range gravimeter | Багтаамжийн төхөөрөмжийг өөрчлөн тохируулахгүйгээр хүндийн хүчний хурдатгалын зөрүүг 200 мГал хүртэл тодорхойлох гравиметр |
| 268. | Өргөн цар хүрээ бүхий гравиметр | **Р:**Широко-диапазонный гравиметр **E:**Wide-range gravimeter | Багтаамжийг өөрчлөхгүйгээр хүндийн хүчний хурдатгалын зөрүүг 200 мГал-аас их үзүүлэлтээр тодорхойлох гравиметр |
| 269. | Гравиметрийн мэдрэмтгий систем | **Р:**Чувствительная система гравиметра **E:**Sensitive system gravitymeter | Хүндийн хүчний хурдатгалын өөрчлөлтийг мэдэрч түүнийг хүч, хүчдэл, давтамж гэх мэт болгон өөрчлөх төхөөрөмж |
| 270. | Гравиметрийн мэдрэмж | **Р:**Чувствительность гравиметра **E:**Gravity sensitivity | Гравиметрийн мэдрэмтгий системийн хөдөлгөөнт хэсгийн шугаман эсвэл өнцгийн хэмжүүрийн шилжилтийг хүндийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | хүчний хурдатгалын зохих өөрчлөлтөд харьцуулсан харьцаа |
| 271. | Гравиметрийн тооллын хуваарийн нэгж | **Р:**Цена деления отсчетной шкалы гравиметра **E:**Reference scale unit gravimeter | Гравиметрийн тооллын хуваарийн нэгжийн хоёр зураасанд тохирсон хүндийн хүчний хурдатгалын хэмжигдэхүүний зөрүү *Тайлбар: Гравиметрийн тооллын зураасны хуваарийн нэгжийг хүндийн хүчний хурдатгал нь тодорхой цэг дээр тодорхойлно*. |
| 272. | Гравиметрийн тэг-байрны шугаман бус шилжилт | **Р:**Нелинейность смещения нуль-пункта гравиметра **E:**Nonlinearity shift zero point gravimeter | Тодорхой цаг хугацааны хооронд гравиметрийн тэг байрны шугаман бус шилжилтийн хамаарал |
| 273. | Гравиметрийн тооллын хуваарийн шугаман бус байдал | **Р:**Нелинейность отсчетной шкалы гравиметра **E:**Nonlinearity reference scale gravimeter | Хүндийн хүчний хурдатгалын өөрчлөлтөөс хамаарах гравиметрийн тооллын хуваарийн нэгжийн өөрчлөлт |
| 274. | Гравиметрийн тэг- байр | **Р:**Нуль-пункт гравиметра **E:**Gravimeter zero point | Гравиметрийн рейс (явалт)-ын эхлэл цэг дээр авсан тоолол |
| 275. | Гравиметрийн тэг-байрны шилжилтийн засвар | **Р:**Поправка за смещение нуль-пункта **E:**Zero-point offset amendment | Багажийн тэгийн байрын шилжилтийг арилгах зориулалтаар гравиметрийн (соронзон) хэмжилтэд өгөх засвар |
| 276. | Гравиметрийн тогтмол | **Р:**Постоянная гравиметра **E:**Gravitational constant | Гравиметрийн бүтэц, хуваарийн нэгж, хэмжих хэрэгслийн хэмжүүрийн шугаман бус хуваарийн итгэлцүүр, хэмийн итгэлцүүр зэргээс хамаарах хэмжигдэхүүн |
| 277. | Дүүжмэгийн температурын итгэлцүүр | **Р:**Температурный коэффициент маятника **E:**Temperature coefficient pendulum | 1 хэмийн өөрчлөлтөд дүүжмэгийн агууригийн хэлбэлзлийн өөрчлөлтийг тодорхойлох үзүүлэлт |
| 278. | Гравиметрийн температурын итгэлцүүр | **Р:**Температурный коэффициент гравиметра **E:**Gravity temperature coefficient | Гравиметрийн хэмжүүрийн заалтын тухайн цагийн хэмжилт хоорондох хэмийн өөрчлөлтийн харьцаа |

## ГРАВИМЕТРИЙН СҮЛЖЭЭ
## ГРАВИМЕТРИЧЕСКАЯ СЕТЬ
## GRAVIMETRIC NETWORK

| | | | |
|---|---|---|---|
| 279. | Гравиметрийн суурь цэг тэмдэгт | **Р:**Фундаментальный гравиметрический пункт<br>**E:**Fundamental gravimetric station | Хөрсний усны түвшин, бичил доргио, чичирхийлэл, байрлуулалтын болон бусад үзүүлэлтийн онцгой шаардлагуудыг хангах тусгай тоноглогдсон байранд марктай, төмөр бетонон монолитоор бэхлэгдсэн гравиметрийн тулгуур тэмдэгт |
| 280. | Гравиметрийн цэг, тэмдэгт | **Р:**Гравиметрический пункт<br>**E:**Gravimetric station | Солбицол, өндөр, хүндийн хүчний хурдатгал зэрэг Дэлхийн татах хүчний бусад элементүүдийн үзүүлэлттэй Дэлхийн физик гадарга дээрх цэг,тэмдэгт |
| 281. | Гравиметрийн I ангийн цэг, тэмдэгт | **Р:**Основной гравиметрический пункт I класса<br>**E:**First degree gravimetric point | Гравиметрийн сүлжээний тулгуур цэгээс хүндийн хүчний хурдатгалыг тодорхойлсон газрын гравиметрийн I ангийн цэг, тэмдэгт |
| 282. | Гравиметрийн эхлэл цэг, тэмдэгт | **Р:**Исходный гравиметрический пункт<br>**E:**Initial gravimetric station | Нэн өндөр нарийвчлалтай хүндийн хүчний хурдатгалыг нь тодорхойлсон тулгуур цэгүүдээс гравиметрийн тодорхойлолтыг харьцуулан хэмждэг улсын гравиметрийн сүлжээний цэг, тэмдэгтүүд |
| 283. | Гравиметрийн тулгуур цэг, тэмдэгт | **Р:**Опорный гравиметрический пункт (ОГП)<br>**E:**Reference gravimetric station | Гравиметрийн зураглалын хэмжилтийн үр дүнг нэгдсэн тогтолцоонд оруулах, хэмжилтийн анхдагч өгөгдлийг агуулсан гравиметрийн тэг-байрны шилжилтийг тодорхойлох зэргийг хангадаг гравиметрийн цэг, тэмдэгт |
| 284. | Гравиметрийн дагуул цэг, тэмдэгт | **Р:**Пункт-спутник гравиметрического пункта<br>**E:**Gravimetric point | Гравиметрийн I ангийн эсвэл гравиметрийн суурь цэгээс 60 км-ын радиусын дотор (түүнчлэн нисэх буудлын талбайд) байрлаж, түүнтэй өндөр нарийвчлалтай харьцангуй хэмжилтээр холбогдсон, бусад цэгүүдтэйгээр холбогдоход тохиромжтой, хүндийн хүчний хурдатгалын бүсийн хэмжээний өөрчлөлтийг илрүүлэх зориулалттайгаар байгуулсан гравиметрийн тулгуур цэг устсан үед түүний хүндийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | хүчний утгыг хадгалах зориулалт бүхий гравиметрийн цэг, тэмдэгт |
| 285. | Геодинамикийн полигоны гравиметрийн цэг, тэмдэгт | **P:**Гравиметрический пункт геодинамического полигона<br>**E:**Gravimetric point of geodynamic polygon | Полигоны геодинамикийн үзэгдлийн шинж байдлаас хамааруулан цэгийг суулгах байршил, цэгийн хэлбэр, хүндийн хүчний хурдатгалын хэмжилтийн нарийвчлал, давтамж зэргийг нь тусгай программаар тодорхойлдог гравиметрийн газрын гадарга дээрх цэг |
| 286. | Гравиметрийн хэмжилтийн нэгж | **P:**Гравиметрические единицы<br>**E:**Gravimetric units | Хүндийн хүчний хурдатгалын өөрчлөлтийг хэмжих нэгж- Гал |
| 287. | Гравиметрийн сүлжээ | **P:**Гравиметрическая сеть<br>**E:**Gravimetric network | Гравиметрийн хэмжилтээр хүндийн хүчний хурдатгалын утгыг тодорхойлж, тэгшитгэн бодсон геодезийн байнгын цэг тэмдэгтийн олонлог |
| 288. | Монгол Улсын гравиметрийн сүлжээ | **P:**Государственная гравиметрическая сеть Монголии<br>**E:**State gravimetric network of Mongolia | Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулсан гравиметрийн суурь сүлжээ, гравиметрийн I, II, III ангийн өндөр нарийвчлалтай геодезийн сүлжээний цэг, тэмдэгтийн нэгдэл. Тайлбар:Тухайн ангийн гравиметрийн сүлжээ байгуулах, хэмжилтийн нарийвчлалыг зохих дүрэм, зааврaар тогтооно. |
| 289. | Монгол Улсын гравиметрийн суурь сүлжээ | **P:**Государственная фундаментальная гравиметрическая сеть Монголии (ГФГС)<br>**E:**State fundamental gravimetric network of Mongolia (FGN) | Хүндийн хүчний хурдатгалын үнэмлэхүй ба харьцангуй хэмжилтийг тогтмол гүйцэтгэдэг, олон улсын гравиметрийн сүлжээтэй холбогдсон, Дэлхийн хэлбэр хэмжээ, татах хүчний цаг хугацааны өөрчлөлтийг судлах, бусад ангийн гравиметрийн сүлжээнд өгөгдөл дамжуулах Монгол Улсын гравиметрийн сүлжээний дээд түвшин |
| 290. | Улсын гравиметрийн I ангийн сүлжээ | **P:**Государственная гравиметрическая сеть I класса (ГГС-1)<br>**E:**State first degree gravimetric network (SGN-1) | Гравиметрийн тулгуур сүлжээний цэгт тулгуурласан I ангийн үндсэн цэгээс бүрдсэн хүндийн хүчний хурдатгалыг цэг дээр 0.05 мГал дундаж квадрат алдаатай тодорхойлох нөхцөлийг бүрдүүлсэн нутаг дэвсгэрийн хэмжээнд ижил зайнд тархан байрласан геодезийн цэг, тэмдэгтийн нэгдэл |

| | | | |
|---|---|---|---|
| 291. | Гравиметрийн шигүүрлийн сүлжээ | **Р:**Гравиметрические сети сгущения **E:**Gravimetric control extension | Гравиметрийн зураглалд зориулсан улсын гравиметрийн сүлжээг өргөтгөх зориулалт бүхий геодезийн цэг, тэмдэгтийн нэгдэл |
| 292. | Олон улсын гравиметрийн сүлжээ | **Р:**Международная гравиметрическая сеть **E:**International gravity networks | Улс орнуудын гравиметрийн сүлжээний эхлэл цэгүүдийн нэгдэл бүхий өндөр нарийвчлалтай хэмжилтээр холбосон, тэгшитгэн бодогдсон гравиметрийн сүлжээний цэг, тэмдэгтийн олонлог |
| 293. | Гравиметрийн сүлжээний шигүүрэл | **Р:**Густота гравиметрической сети **E:**Density of gravimetric networks | Судалгаа явуулж буй талбай дахь зүсэлтийн шугамын нэг км урт эсвэл нэг км2 талбайд ногдох гравиметрийн цэгүүдийн тоо |
| 294. | Гравиметрийн зураглал | **Р:**Гравиметрическая съемка **E:**Gravimetric surveying | Тухайн дэвсгэр нутагт Дэлхийн хүндийн хүчний өөрчлөлтийн утгыг нарийвчлан судлахаар гүйцэтгэсэн гравиметрийн хэмжилт, бодолтын ажлуудын иж бүрдэл.Тайлбар:Газрын, тэнгисийн, мөсний, ба гүний гравиметрийн зураглал байна. |
| 295. | Талбайн (гравиметрийн) зураглал | **Р:**Площадная (гравиметрическая) съемка **E:**Areal gravity survey | Судалж буй талбайд тэгш өнцөгт торлол байгуулж гравиметрийн хэмжилтээр зураг зохиох гравиметрийн зураглал хийх үйл ажиллагаа |
| 296. | Газрын (гравиметрийн) зураглал | **Р:**Наземная (гравиметрическая) съемка **E:**Land gravity survey | Эх газрын гадарга дээр гравиметрийн хэмжилт, боловсруулалтын үр дүнгээр зураглал хийх ажиллагаа |
| 297. | Нарийвчилсан (гравиметрийн) зураглал | **Р:**Детальная (гравиметрическая) съемка **E:**Detailed gravity survey | Гравиметр (соронзон)-ийн аномали илрүүлэх зорилгоор өндөр нягтралтай сүлжээ байгуулж, том масштабын өндөр нарийвчлалтай зураглал хийх үйл ажиллагаа |
| 298. | Бүс нутгийн гравиметрийн зураглал | **Р:**Региональная гравиметрическая (магнитная) съемка **E:**Regional gravimetric (magnetic) survey | Орон нутгийн гравиметр (соронзон)-ийн аномали илрүүлэх зорилгоор бага нягтралтай сүлжээ байгуулж, жижиг масштабын зураглал хийх ажиллагаа |
| 299. | Шугамын (гравиметрийн) зураглал | **Р:**Профильная (гравиметрическая) съемка | Өгөгдсөн шугамын дагуу хүндийн хүчний өөрчлөлтийн үзүүлэлтийг |

| | | | |
|---|---|---|---|
| | | **E:**Profile gravity survey | тодорхойлох гравиметрийн зураглал хийх ажиллагаа |
| 300. | Гравиметрийн соронзон долгионы зураглал | **P:**Гравиметрическая (магнитный) сьёмка<br>**E:**Gravimetric (magnetic) survey | Байр зүйн зургийн масштаб, судалгааны болон хэмжилтийн нарийвчлалаас хамаарах зураглалын үзүүлэлт |
| 301. | Дэлхийн гравиметрийн зураглал | **P:**Мировая гравиметрическая съемка<br>**E:**World (global) gravity survey | Эх газар, арал, далайд даяарчлалын хэмжээнд Дэлхийн хэлбэр хэмжээ, хүндийн хүчний өөрчлөлтийг цаг хугацааны өөрчлөлттэй хамааруулан судлах, тодотгох, үр дүнд үнэлэлт өгөх гравиметрийн иж бүрдэл ажлууд |
| 302. | Гравиметрийн холболт | **P:**Гравиметрическая привяка пунктов Гравиметрическая привязка<br>**E:**Gravimetric binding | Цэгүүд хооронд хүндийн хүчний хурдатгалын өөрчлөлтийг тодорхойлох үйл ажиллагаа |
| 303. | Гравиметрийн жишилт | **P:**Эталонирование гравиметра<br>**E:**Gravitymeter calibration | Гравиметрийн хуваарийн хэмжилтийн нэгжийг үнэмлэхүй системийн (мГал-миллигал) нэгжид шилжүүлэх арга |
| 304. | Гравиметрийн жишиг талбай | **P:**Гравиметрический эталонный полигон<br>**E:**Gravimetric polygon | Хүндийн хүчний ялгаврууд нь нэг тийш дараалан өөрчлөгддөг 2 эсвэл 5-8 бүлэг геодезийн цэгүүдэд хэмжилт хийж, гравиметрийн хэмжилтийн багажийн тогтмол утгыг тодорхойлох зориулалт бүхий геодезийн талбай |
| 305. | Гравиметрийн хайгуул | **P:**Гравиразведка<br>**E:**Gravimetric exploration | Тухайн газарт геологийн бүтцийг судлах, ашигт малтмалын орд газрын хайгуул, судалгааны зориулалтаар хүндийн хүчний хурдатгал, түүний өөрчлөлтийг судлах геофизикийн арга |
| 306. | Гравиметрийн ажлын геодези, байр зүйн хангалт | **P:**Топографо-геодезические обеспечение гравиметрических работ<br>**E:**Topographic and geodetic support in gravimetric works | Гравиметрийн сүлжээний цэгийн солбицол, өндрийг өндөр нарийвчлалтай тодорхойлох иж бүрэн ажил |
| 307. | Гравиметрийн ажлын хэмжил зүйн хангалт | **P:**Метрологическое обеспечение | Гравиметрийн хэмжилтийн ажлын нэгдмэл байдлыг хангах хэмжилзүйн цогц ажил |

| | | | |
|---|---|---|---|
| | | гравиметрических работ<br>**E:**Metrological support in gravimetric works | |

**ГРАВИМЕТРИЙН ХЭМЖИЛТ, ҮР ДҮНГИЙН БОЛОВСРУУЛАЛТ**
**ГРАВИМЕТРИЧЕСКИЕ ОПРЕДЕЛЕНИЯ И ОБРАБОТКА РЕЗУЛЬТАТОВ**
**GRAVIMETRIC DETERMINATIONS AND PROCESSING OF RESULTS**

| | | | |
|---|---|---|---|
| 308. | Хүндийн хүчний хурдатгалын үнэмлэхүй утга | **Р:**Абсолютное определение ускорения силы тяжести<br>**E:**Absolute acceleration of gravity | Гравиметрийн цэг бүр дээр хүндийн хүчний хурдатгал тодорхойлох арга |
| 309. | Хүндийн хүчний хурдатгалын харьцангуй утга | **Р:**Относительное определение ускорения силы тяжести<br>**E:**Relative acceleration of gravity | Гравиметрийн хоёр цэгүүд хоорондын хүндийн хүчний хурдатгалын зөрүүг хэмжих арга |
| 310. | Гравиметрийн хэмжилтийн явалт | **Р:**Гравиметрический рейс<br>**E:**Gravimetric route | Өгөгдсөн замналын дагуу эхлэл (буюу тулгуур) болон тодорхойлж буй цэгүүд дээр дараалсан хэмжилт хийх үйл ажиллагааны нэгдэл |
| 311. | Гравиметрийн хэмжилтийн явалтын салаа шугам | **Р:**Звено (гравиметри-ческого) рейса<br>**E:**Link of a gravimetric route | Гравиметрийн тулгуур цэг хооронд дараалсан хэмжилт хийх хугацааны хооронд гравиметрийн тэг-байрны шилжилтийг шугаман гэж тооцох гравиметрийн рейсийн хэсэг |
| 312. | Гравиметрийн зүсэлт | **Р:**Гравиметрический профиль<br>**E:**Gravity profile | Хүндийн хүчний хэмжилт хийхээр татсан дурын шулуун |
| 313. | Гравиметрийн хэмжилтийн үргэлжлэх хугацаа | **Р:**Продолжительность гравиметрического рейса<br>**E:**Duration gravimetric route | Эхлэл цэг дээр хоёр удаагийн хэмжилт хийх гравиметрийн явалт хоорондын хугацаа |
| 314. | Дэлхийн хүндийн хүчний аномали | **Р:**Аномалия силы тяжести Земли (Аномалия сила тяжести)<br>**E:**Earth Gravity anomaly | Өгөгдсөн цэг дэх Дэлхийн хүндийн хүчний хэмжсэн утга ба түүний нормаль утга хоорондын ялгавар |
| 315. | Чөлөөт агаар дахь аномали | **Р:**Аномалия в свободном воздухе<br>**E:**Gravity anomaly in free-air | Хэмжилт хийж буй цэгийн өндрийг нормаль утгад шилжүүлэх засварыг тооцсон хүндийн хүчний хурдатгалын хэмжилтийн үр дүнгүүдээр |

| | | | |
|---|---|---|---|
| | | | бодсон хүндийн хүчний хурдатгалын аномали |
| 316. | Аномали өндөр | **Р:**Аномалия высоты<br>**E:**Height anomaly | Геодезийн өндөр ба нормаль өндрийн ялгавар нь референц-эллипсоид дээрх квазигеоидын өндөртэй тэнцүү байх хэмжигдэхүүн |
| 317. | Дэлхийн хүндийн хүчний хурдатгалын аномали | **Р:**Аномалия ускорения силы тяжести Земли Аномалия ускорения силы тяжести<br>**E:**Gravity acceleration anomaly | Тухайн цэг дээр засварыг нь тооцсон хүндийн хүчний хэмжилтийн утга ба түүний хэвийн утга хоорондын ялгавар |
| 318. | Гравиметрийн хуурмаг аномали | **Р:**Псевдограви-метрическая аномалия<br>**E:**Pseudogravimetric anomaly | Соронзон аномалийн хэмжилтийн үр дүнг өөрчлөх замаар гаргасан гравиметрийн аномали |
| 319. | Бугегийн аномали | **Р:**Аномалия Буге<br>**E:** Bouguer gravity anomaly | Хэмжилтийн цэг ба далайн түвшний хооронд байрлах өгөгдсөн нягтралтай зэрэгцээ давхаргын массын таталцлын нөлөөг арилгадаг засваруудыг тооцсон хүндийн хүчний хурдатгалын хэмжилтийн үр дүнгүүдээр бодсон хүндийн хүчний аномали |
| 320. | Фая аномали | **Р:**Аномалия Фая<br>**E:**Faye’s gravity anomaly | Газрын гадаргын хотгор гүдгэрийн засварыг тооцсон чөлөөт агаар дахь аномали |
| 321. | Үлдэгдэл аномали | **Р:**Остаточная аномалия<br>**E:**Residual anomaly | Бүс нутгийн ба хэмжилт хийж буй цэг хоорондын аномали утгын зөрүү |
| 322. | Газрын соронзон аномали | **Р:**Аномалия геомагнитная<br>**E:**Geomagnetic anomaly | Соронзон хэлбийлт нь огцом өөрчлөгддөг газар |
| 323. | Бугегийн засвар | **Р:**Поправка Буге<br>**E:**Bouguer gravity reduction | Гравиметрийн цэг, тэмдэгтийн өндөр ба тэнгисийн түвшин хооронд байрлах таталцлын талбарын давхаргын нөлөөллийг багасгах зорилгоор хүндийн хүчний хурдатгалд өгөх засвар |
| 324. | Фаягийн засвар | **Р:**Поправка Фая<br>**E:**Faye’s gravity reduction | Хүндийн хүчний нормаль утгад гравиметрийн цэг, тэмдэгтийн өндөрт шилжүүлэхэд өгөх засвар |
| 325. | Гравиметрийн сүлжээний | **Р:**Уравнивание результатов измерений в | Гравиметрийн полигонд хэмжилтийн жинг тооцсон зөрүүг тараахад хүндийн хүчний |

| | | | |
|---|---|---|---|
| | тэгшитгэн бодолт | гравиметрической сети<br>**E:**Adjustment of gravimetric network | хурдатгалд тооцох бодит магадлал бүхий засварыг тодорхойлох үйлдэл |
| 326. | Гравиметрийн тулгуур сүлжээг тэгшитгэн бодох | **P:**Уравновешивание опорной сети<br>**E:**Adjusting gravimetric network | Гравиметрийн хэмжилтийн нийт сүлжээнд гарсан алдааг сүлжээний зохих хэсэг бүрд тараах арга |
| 327. | Гравиметрийн цэг, тэмдэгтийн хувийн хэрэг | **P:**Паспорт гравиметрического пункта<br>**E:**Gravity station profile | Гравиметрийн суурь ба I ангийн сүлжээний цэг,тэмдэгт түүний дагуул цэг, тэмдэгтийн байрлал, цэгүүд суулгасан арга, гравиметрийн бүх үзүүлэлт зэргийг агуулсан баримт |
| 328. | Гравиметрийн цэг, тэмдэгтийн цэс /каталог/ | **P:**Каталог гравиметрических пунктов<br>**E:**Gravity stations catalog | Гравиметрийн цэг, тэмдэгтүүдийн хүндийн хүчний утга, солбицол, өндрийн тоот болон орчны газар орны байдлыг дүрслэн үзүүлсэн бичмэл эсвэл гэрэл зураг, цэг суулгасан арга зэргийг журамласан жагсаалт баримт |
| 329. | Гравиметрийн зураг | **P:**Гравиметрическая карта<br>**E:**Gravimetric (gravity) map | Хүндийн хүчний аномалийн хурдатгалыг харуулсан байр зүйн зургийн агуулгатай зураг |
| 330. | Гравиметрийн хэмжилтийн засвар | **P:**Редукция результатов гравиметрических определений<br>**E:**Gravity reduction | Төрөл бүрийн аномалийг бодох, ердийн утгатай нь харьцуулахын тулд хүндийн хүчний хурдатгалын хэмжилтийн үр дүнд өгөх засвар |

**ГЕОДЕЗИЙН ЦЭГ,ТЭМДЭГТ**
**ГЕОДЕЗИЧЕСКИЕ ПУНКТЫ**
**GEODETIC POINTS**

| | | | |
|---|---|---|---|
| 331. | Геодезийн байнгын цэг, тэмдэгт | **P:**Постоянный геодезический пункт<br>**E:**Permanent geodetic point/mark | Геодези, зураг зүйн үйл ажиллагааны үндэс болох байрлал, өндөр, хүндийн хүчний хурдатгал зэрэг орон зайн гурав болон түүнээс дээш хэмжээсээр утга нь тодорхойлогдсон, газрын гадарга, хэвлий, барилга байгууламж зэрэг хөдөлгөөнгүй биетэд бэхлэгдсэн төв цэг болон түүн дээрх байгууламж |
| 332. | Астрономи-геодезийн цэг, тэмдэгт | **P:**Астрономо-геодезический пункт<br>**E:**Astronomy-geodetic point | Астроном-геодезийн хэмжилтээр солбицол нь тодорхойлогдож газарт бэхэлсэн цэгүүд түүн дээрх байгууламжууд |
| 333. | Геодезийн тэмдэгт | **P:**Геодезический знак<br>**E:**Geodetic sign/mark | Газарт байгаа геодезийн цэгийн байрлалыг зааж тэмдэглэсэн байгууламж, бүтээц |

| | | | |
|---|---|---|---|
| 334. | Геодезийн төмөр цамхаг | **P:**Металический геодезический сигнал<br>**E:**Geodetic metal tower | Триангуляцийн цэг дээр байгуулах 16-55 м хүртэл өндөр геодезийн төмөр цамхаг |
| 335. | Дөрвөн талтай цамхаг | **P:**Четырехгранный сигнал<br>**E:**Four-sided tower | Триангуляцийн цэг дээр байгуулах дөрвөн талтай модон эсвэл төмөр цамхаг |
| 336. | Суварга-пирамид | **P:**Пирамид<br>**E:**Geodetic Pyramid | Триангуляцийн цэг дээр байгуулах гурав ба дөрвөн талтай пирамид хэлбэрийн суварга |
| 337. | Геодезийн цэгийн марк | **P:**Марка центра геодезического пункта<br>**E:**Mark of geodetic point center | Геодезийн цэгийн төвд тодорхой тэмдэглээс хийж байрлуулсан төмөр, ширмэн хэсэг бүхий солбицол тээгч бүтээц |
| 338. | Геодезийн тэмдэгт байгуулалт | **P:**Постройка геодезического знака<br>**E:**Construction of geodetic sign | Газарт байгаа геодезийн цэгийг зааж тэмдэглэх, хэмжилт хийх зориулалт бүхий байгууламж, бүтээц |
| 339. | Репер | **P:**Репер<br>**E:**Benchmark, reference mark | Барилга байгууламж, газрын хөрсөнд бэхлэх өндрийн сүлжээний тэмдэгт |
| 340. | Ханын репер | **P:**Репер стенной<br>**E:**Wall benchmark | Барилга байгууламжийн чулуун, бетон суурьнд бэхлэх өндрийн байрлалыг хадгалах геодезийн өндрийн сүлжээний тэмдэгт |
| 341. | Гүний репер | **P:**Репер глубинный<br>**E:**Depth benchmark | Барилга байгууламжийн хэв гажлыг ажиглахад зориулагдах барилгын талбайд хөлдөлтийн гүнээс доош гүнд ёроолыг нь суулгасан өндрийн сүлжээний суурь тэмдэгт |
| 342. | Суурь репер | **P:**Фундаментальный репер<br>**E:**Base benchmark | Газрын гадаргууд бэхлэгдсэн үнэмлэхүй өндөр бүхий геодезийн өндрийн сүлжээний тэмдэгт |
| 343. | Марк | **P:**Марка<br>**E:**Mark | Геодезийн байрлал, өндрийн сүлжээний цэгийг бэхлэхэд суулгасан цуллагийн дээд ба доод хэсэгт цэгийн төвийг заах ширмэн эсвэл төмөр цутгамал бүтээц |
| 344. | Гүний марк | **P:**Глубинная марка<br>**E:**Depth mark | Барилга байгууламжийн хэв гажлыг ажиглахад зориулсан барилгын талбайд суулгасан өндрийн сүлжээний цэгийн бүтээц |

| | | | |
|---|---|---|---|
| 345. | Хана, хадны марк | **P:**Марка скальная и стенная<br>**E:**Rock/wall mark | Геодезийн төв цэг ба нивелирийн реперийн оронд ургаа хаданд эсвэл барилгын хананд суулгадаг бүтээц |
| 346. | Хөрсний репер | **P:**Репер грунтовый<br>**E:**Soil benchmark | Хөрсний хөлдөлтийн гүнээс доош суулгах өндрийн сүлжээний тэмдэгт |
| 347. | Геодезийн эхлэл цэг, тэмдэгт | **P:**Исходный геодезический пункт<br>**E:**Reference point | Геодезийн доод ангийн сүлжээний цэгүүдийн байршлыг харьцангуйгаар тодорхойлох геодезийн тэмдэгт |
| 348. | Лапласын цэг, тэмдэгт | **P:**Пункт Лапласа<br>**E:**Laplace station | Астрономийн хэмжилтээр астрономийн уртраг, өргөрөг, зовхисыг нь тодорхойлсон геодезийн тэмдэгт |
| 349. | Геодезийн жишиг суурь | **P:**Базис эталонный<br>**E:**Reference base | Зай хэмжүүрийн багажуудыг шалгах эхлэл, дундаа, төгсгөл хүртэл тодорхой зайнд суулгасан баганууд бүхий нэг эсвэл хэд хэдэн шугамын уртыг шалгах геодезийн суурь |

**СОЛБИЦЛЫН ТОГТОЛЦОО**
**СИСТЕМА КООРДИНАТ**
**COORDINATE SYSTEM**

| | | | |
|---|---|---|---|
| 350. | Солбицлын тогтолцоо | **P:**Система координат<br>**E:**Coordinate system | Орон зайн цэгүүд ба тэдгээрийн солбицлын тоон утгыг эхлэлийн цэгээс харьцуулан тогтоосон дүрэм |
| 351. | Олон улсын солбицлын тогтолцоо | **P:**Международная координатная система<br>**E:**International coordinate system | Орон зайн цэгүүд ба тэдгээрийн солбицлын тоон утгыг олон улсын геодезийн сүлжээний эхлэлийн цэгээс харьцуулан тогтоосон дүрэм |
| 352. | Геодезийн солбицлууд | **P:**Геодезические координаты<br>**E:**Geodetic coordinates | Геодезийн өргөрөг, уртраг ба өндөр |
| 353. | Геодезийн солбицлын тогтолцоо | **P:**Геодезическая система координат<br>**E:**Geodetic coordinate system | Байрлал нь геодезийн уртраг, өргөрөг болон орон зайн орчинд эллипсиодын өндрөөр тодорхойлогдох 3 хэмжээст солбицлын тогтолцоо |
| 354. | Дэлхийн геодезийн солбицлын тогтолцоо | **P:**Глобальная геодезическая система координат<br>**E:**The Global Geodetic Reference System (GGRS) | Хуурай газрын ба огторгуйн солбицлын системүүдээс бүрдсэн Дэлхийн нийтийн солбицлын тогтолцоо |

| | | | |
|---|---|---|---|
| 355. | Солбицлын суурь тогтолцоо | **Р:**Опорная координатная сисема<br>**E:**Coordinate reference system | Объекттой эхлэл өгөгдлөөр холбогдох солбицлын тогтолцоо |
| 356. | Үнэмлэхүй солбицлууд | **Р:**Абсолютные координаты<br>**E:**Absolute coordinates | Дэлхий төвт тэгш өнцөгтийн эсвэл хиймэл дагуулын Дэлхийн эллипсоид дахь объектын орон зайн солбицол |
| 357. | Астрономийн солбицлууд | **Р:**Астрономические координаты<br>**E:**Astronomic (al) coordinates | Дэлхийн эргэх тэнхлэг ба анхны голдчийн хавтгайд перпендикуляр хавтгай харьцангуй орших орон зайн ямар нэгэн цэгийн эгц босоо шугамын чиглэлийн бүрэлдэхүүн хэсэг |
| 358. | Газар зүйн солбицол | **Р:**Географические координаты<br>**E:**Geographic (al) coordinates | Босоо шугамын хавтгайн хазайлтыг тооцоогүй астрономийн ба геодезийн солбицлын нэгдмэл ойлголт |
| 359. | Газар зүйн байрлал | **Р:**Географическое местоположение<br>**E:**Geographical position | Дэлхийн гадарга дээрх цэгийн байрлалыг тодорхойлох математик аргачлалын эллипсоидод тулгуурласан уртраг ба өргөргөөр тодорхойлох солбицол |
| 360. | Дэлхий төвт солбицлууд | **Р:**Геоцентрические координаты<br>**E:**Geocentric coordinates | Дэлхийн хүндийн төвтэй солбицлын тогтолцооны эхлэлтэй давхацсан тогтолцоогоор тухайн цэгийн байрлалыг тодорхойлох хэмжигдэхүүн |
| 361. | Дэлхий төвт уртраг | **Р:**Геоцентрическая долгота<br>**E:**Geocentric longitude | Тухайн цэгийн дэлхий төвт голдчийн хавтгай ба дэлхий төвт анхдагч голдчийн хооронд үүсэх хоёр ирмэгт өнцөг |
| 362. | Дэлхий төвт радиус-вектор | **Р:**Геоцентрический радиус-вектор<br>**E:**Geocentric radius-vector | Дэлхийн массын төвийг тухайн цэгтэй холбож буй шулуун |
| 363. | Референц тогтолцооны геодезийн солбицлууд | **Р:**Геодезические координаты референцной системы<br>**E:**Geodetic coordinates of reference system | Геодезийн солбицлын суурь тогтолцоо геодезийн эхлэл өгөгдөл дээр үндэслэгдсэн суурь солбицлын тогтолцоо |
| 364. | Декартын солбицлын тогтолцоо | **Р:**Декартовая система координат | Харилцан бие биедээ перпиндикуляр тэнхлэгтэй, харьцангуйгаар цэгийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | **E:**Cartesian coordinate system | байрлалыг тодорхойлдог солбицлын тогтолцоо |
| 365. | Бортгон солбицлын тогтолцоо | **Р:**Цилиндрическая система координат<br>**E:**Cylindrical coordinate system | Туйлын солбицлын тогтолцоонд хавтгай дээрх цэгийн өндрийг тодорхойлогч гуравдагч солбицлыг нэмж өргөтгөсөн гурван хэмжээст солбицлын тогтолцоо |
| 366. | Бөмбөрцгийн солбицлын тогтолцоо | **Р:**Сферическая координатная система<br>**E:**Sherical coordinate system | Эхлэл цэгээс хэмжигдсэн нэг зайны, хоёр өнцгийн солбицол бүхий геодезийн солбицлын суурь тогтолцоотой холбогдсон гурван хэмжээст солбицлын тогтолцоо |
| 367. | Босоо референц солбицлын тогтолцоо | **Р:**Вертикальная референцная система координат<br>**E:**Vertical coordinate reference system | Босоо эхлэл өгөгдөл дээр суурилсан нэг-хэмжээст солбицлын суурь тогтолцоо |
| 368. | Босоо солбицлын тогтолцоо | **Р:**Вертикальная система координат<br>**E:**Vertical coordinate system | Таталцлаас хамаарсан өндөр буюу гүний хэмжилтэд ашиглагдах нэг-хэмжээст солбицлын тогтолцоо |
| 369. | Солбицлын тэнхлэгүүд | **Р:**Оси координат<br>**E:**Coordinate axes | Хавтгайн тэгш өнцгийн солбицлын тогтолцоонд цэгийн байрлалыг тодорхойлох абцисс-$x$, ординат-$y$ солбицлууд |
| 370. | Солбицлын тогтолцоо-СК 42 | **Р:**Государственная система координат-СК42<br>**E:**Coordinate system SK 1942 | ЗХУ-ын 1942 оны солбицлын тогтолцоо |
| 371. | WGS-84 солбицлын тогтолцоо | **Р:**Система координат WGS- 84<br>**E:**WGS-84 coordinate system | Дэлхий массын төвт солбицлын тогтолцоо-WGS-84 |
| 372. | IERS-солбицлын тогтолцоо | **Р:**Общеземная геодезическая референцная система<br>**E:**Geodetic Reference System IERS | Ерөнхий Дэлхийн геодезийн референц тогтолцоо ба түүний дэд тогтолцоо болох европын холбооны ETRS, GRS-80 –ны нэгдэл |
| 373. | Олон улсын хуурай газрын солбицлын тогтолцоо | **Р:**Международная наземная координатная система<br>**E:**The International Terrestrial Reference system (ITRS) | Сансар огторгуйн орон зай дахь хөдөлгөөнийг Дэлхийн өөрийнх нь эргэлттэй хамтад нь авч үздэг солбицлын тогтолцоо |

| | | | |
|---|---|---|---|
| 374. | Геодезийн референц систем-80 | **Р:**Геодезическая референцная система **(**Общеземной эллипсоид GRS 80) **E:**Geodetic Reference System 80-GRS80 | Геодези, геофизикийн олон улсын холбооноос батлагдсан үзүүлэлтүүдийг нь бусад солбицлын системүүд байгуулахад ашигладаг дэлхий ерөнхий эллипсоид (их хагас тэнхлэг $a = 6378137.0$ м, шахалт $= 1/298.257222101$) |
| 375. | Бие даасан бүс нутгийн геодезийн солбицлын тогтолцоо | **Р:**Местная геодезическая система координат **E:**Local geodetic coordinate system | Солбицлын эхлэл цэг, чиглэл, харьцуулах гадаргыг дурын цэг, хэмжигдэхүүн, гадаргаар авсан солбицлын тогтолцоо |
| 376. | Солбицол, өндөр, гравиметрийн тогтолцооны эрин | **Р:**Эпохы системы координат, высот и гравиметрии **E:**Epochs of coordinate system, height and gravimetry | Геодезийн хэмжилт, ажиглалт, судалгаанд одот ертөнцийн таталцал, агаар мандлын соронзон идэвхжилт, Дэлхийн дотоод гадаад хүчний үйлчлэлийн нөлөөллийн хувьсах үйл явцын өөрчлөлтийг тооцоолсон цаг хугацааны утга |
| 377. | Туйлын солбицлын тогтолцоо | **Р:**Полярная система координат **E:**Polar coordinate system | Хавтгай дээрх цэг бүр туйлын өнцөг, туйлын радиусаар тодорхойлогдох хоёр хэмжээст солбицлын тогтолцоо |
| 378. | Туйлын бөмбөрцгийн солбицлууд | **Р:**Полярные сферические координаты **E:**Polar spherical coordinates | Солбицлын тогтолцоонд дурын цэгийг туйлаар сонгож, бөмбөрцгийн гадаргын голдчоос зохих цэгүүдийн байрлалыг тодорхойлох хоёр өнцгийн хэмжигдэхүүн |
| 379. | Туйлын бөмбөрцгийн ташуу солбицлын тогтолцоо | **Р:**Косая система полярных сферических координат Косая система координат **E:**Oblique system of Spherical polar coordinate | Туйл нь газар зүйн туйл ба экваторын хооронд байрлах туйлын бөмбөрцгийн солбицлын тогтолцоо |
| 380. | Туйлын бөмбөрцгийн нормаль солбицлын тогтолцоо | **Р:**Нормальная система полярных сферических координат **E:**Normal system of spherical polar coordinate | Туйл нь газар зүйн туйлтай давхцах туйлын бөмбөрцгийн солбицлын тогтолцоо |
| 381. | Туйлын бөмбөрцгийн хөндлөн | **Р:**Поперечная система полярных | Туйл нь экватор дээр байрлах туйлын бөмбөрцгийн тогтолцоо |

| | | | |
|---|---|---|---|
| | солбицлын тогтолцоо | сферических координат Поперечная система координат **E:**Transverse system of spherical polar coordinates Transverse coordinate system | |
| 382. | Бөмбөрцгийн тэгш өнцгийн солбицлууд | **P:**Прямоугольные сферические координаты **E:**Rectangular spherical coordinates | Бөмбөрцгийн том босоо дугуй ба түүнд перпендикуляр байрлалтай том дугуйнуудын огтлолоор үүсэх солбицлын тогтолцоо |
| 383. | Шугаман солбицлын тогтолцоо | **P:**Линейная система координат **E:**Linear coordinate system | Тэнхлэг нь шугаман биет байх нэг хэмжээст солбицлын тогтолцоо.*Тайлбар: Жишээ нь: шугам хоолойн дагуух зай, газрын тосны цооногийн гүний солбицол* |
| 384. | Шугаман байрлалын тогтолцоо | **P:**Система линейных позиционирований **E:**Linear positioning system | Замын сүлжээний дагуу тодорхой суурь цэгээс зайг эхлэн хэмжих байршлын тогтолцоо |
| 385. | Солбицлын бүс | **P:**Координатные зоны **E:**Grid zones/coordinate zones | Хоёр голдчоор хязгаарлагдсан Гаусс-Крюгерийн бүсчилсэн тэгш өнцгийн солбицлын тогтолцоонд 3 ба 6 градусын уртрагаар тодорхойлогдох Дэлхийн гадаргуугийн хэсэг |
| 386. | Солбицлын хэмжээс | **P:**Координатная мера **E:**Coordinate dimension | Солбицлын тогтолцоонд байршил тодорхойлоход шаардлагатай тэнхлэг ба түүний хэмжээс тоо |
| 387. | Солбицлын тор | **P:**Сетка координат **E:**Coordinate grid | Өөр хоорондоо босоо ба хэвтээ байдлаар харилцан огтлолцох тэгш өнцөгт солбицлын тэнхлэгтэй зэрэгцээ шулуунууд |
| 388. | Босоо хавтгай | **P:**Вертикальная плоскость **E:**Vertical plane | Тухайн цэгийг дайрч гарсан эгц босоо шугамын хавтгай |
| 389. | Геодезийн голдчийн хавтгай | **P:**Плоскость геодезического меридиана **E:**Geodetic meridian Plane | Тухайн цэгийн Дэлхийн эллипсоидын гадаргууд буулгасан нормалийг дайрах, түүний бага тэнхлэгтэй зэрэгцээ орших хавтгай |
| 390. | Дэлхий төвт голдчийн хавтгай | **P:**Плоскость геоцентрического меридиана | Дэлхийн эргэлтийн тэнхлэг ба тухайн цэгийг дайрсан хавтгай |

| | | | |
|---|---|---|---|
| | | **E:**Geocentric meridian | |
| 391. | Анхны голдчийн хавтгай | **Р:**Плоскость начального меридиана **E:**Prime meridian plane | Уртрагийн тооллыг эхлэх голдчийн хавтгай |
| 392. | Геодезийн өргөрөг | **Р:**Геодезическая широта **E:**Geodetic latitude | Тухайн цэгээс Дэлхийн эллипсоидын гадаргад буусан нормаль, экваторын хавтгай хоёрын хооронд үүссэн өнцөг |
| 393. | Газар зүйн өргөрөг | **Р:**Географическая широта **E:**Geographic latitude | Экватораас тухайн цэгийн эгц босоо шулуун хүртэл голдчийн нумын өнцгөөр хэмжигдэх градусаар илэрхийлэгдэх зай |
| 394. | Дэлхий төвт өргөрөг | **Р:**Геоцентрическая широта **E:**Geocentric latitude | Дэлхийн эргэлтийн тэнхлэгтэй перпендикуляр хавтгай ба Дэлхий төвт радиус-вектор хооронд үүссэн өнцөг |
| 395. | Дэлхий төвт уртраг | **Р:**Геоцентрическая долгота **E:**Geocentric longitude | Тухайн цэгийн Дэлхий төвт голдчийн хавтгай ба Дэлхий төвт анхны голдчийн хавтгай хооронд үүссэн өнцөг |
| 396. | Геодезийн тэгш өнцөгт, хавтгай солбицол | **Р:**Плоские прямоугольные геодезические координаты **E:**Plane coordinates | Дэлхийн эллипсоидын математикийн хуулиар дүрслэн харуулсан хавтгайн тэгш өнцгийн солбицол |
| 397. | Байр зүйн төвт солбицол | **Р:**Топоцентрические координаты **E:**Topocentric coordinates | Эхлэл нь газар дээрх цэг байх харин тэнхлэг нь Дэлхий төвт солбицлын тогтолцооны тэнхлэгтэй зэрэгцээ байх солбицол |
| 398. | Геодезийн оройн цэг | **Р:**Геодезический зенит **E:**Geodetic zenith | Дэлхийн эллипсоидод буулгасан нормаль шугам, тэнгэрийн бөмбөрцөгтэй огтлолцсон цэг |
| 399. | Оройн зай | **Р:**Зенитное расстояние **E:**Zenith distance | Тухайн цэгээс оройн цэг болон хоёр дахь цэг рүү харсан чиглэлийн хоорондох өнцөг |
| 400. | Геодезийн махиа | **Р:**Геодезическая кривизна **E:**Geodetic curvature | Гадаргуу дээрх шулууны геодезийн шулуунаас хазайлтын хэмжигдэхүүнийг илэрхийлэгч шулуун |
| 401. | Нумын махиа | **Р:**Кривизна дуги **E:**The curvature of a curve | Тойргийн радиусын урвуу хэмжигдэхүүнтэй тэнцүү нумын үзүүлэлт |
| 402. | Зайг хөрвүүлэх | **Р:**Редукция расстояния **E:**Distance reduction | Эллипсоидын гадарга дээрх хоёр цэгийн хоорондох зайг хавтгай дээр шилжүүлэхэд өгөх засвар |

| | | | |
|---|---|---|---|
| | | | Дэлхийн физик гадаргад хэмжсэн налуу зайг эхлээд хэвтээ тавилд, дараа нь квазигеоидын гадарга буюу референц эллипсоидын гадаргад улмаар хавтгайд дэс дараалуулан шилжүүлэх үйлдэл |
| 403. | Чиглэлийг хөрвүүлэх | **Р:**Редуцирование направлений<br>**E:**Direction reduction | Дэлхийн физик гадарга дээр хэмжсэн хэвтээ чиглэлийг референц эллипсоидын гадаргууд шилжүүлэх арга |

**ГЕОДЕЗИЙН СҮЛЖЭЭ**
**ГЕОДЕЗИЧЕСКАЯ СЕТЬ**
**GEODETIC NETWORK**

| | | | |
|---|---|---|---|
| 404 | Геодезийн сүлжээ | **Р:**Геодезическая сеть<br>**E:**Geodetic network | Орон зайн гурав ба түүнээс дээш хэмжээст утгыг тодорхойлж, тэгшитгэн бодсон геодезийн байнгын цэг, тэмдэгтийн олонлогийг ойлгох ба байрлалын, өндрийн, гравиметрийн гэж ангилагдана |
| 405 | Астрономи-геодезийн сүлжээ | **Р:**Астрономо-геодезическая сеть<br>**E:**Astro-geodetic network | Сүлжээний зарим цэгүүдийг астрономийн солбицол, зовхисоор тодорхойлсон геодезийн сүлжээ |
| 406 | Астроном-геодезийн суурь сүлжээ | **Р:**Фундаментальная астрономо-геодезическая сеть; ФАГС<br>**E:**Fundamental astronomic-geodetic network | Дэлхий орон зайн солбицлын тогтолцоонд солбицол нь астрономийн ба геодезийн солбицлуудаар тодорхойлогдож анхны тулгуур өгөгдлүүдийг үүсгэгч геодезийн сүлжээ |
| 407 | Байрлалын сүлжээ | **Р:**Плановая сеть<br>**E:**Position network | Солбицлыг тодорхойлж, тэгшитгэн бодсон геодезийн байнгын цэг тэмдэгтийн олонлог |
| 408 | Улсын геодезийн сүлжээ | **Р:**Государственная геодезическая сеть<br>**E:**State geodetic network | Тухайн орны нутаг дэвсгэрт солбицлыг тархаах, геодезийн бусад сүлжээ байгуулахад тулгуур болох геодезийн сүлжээ |
| 409 | Геодезийн шигүүрлийн сүлжээ | **Р:**Геодезическая сеть сгушения<br>**E:**Geodetic network densification | Геодезийн сүлжээг улам нягтруулах зорилгоор дээд ангиллын сүлжээнд тулгуурлан байгуулсан сүлжээ. |
| 410 | Зураглалын сүлжээ | **Р:**Съемочная геодезическая сеть<br>**E:**Surveying network | Том масштабын байр зүйн зураглалд зориулан байгуулах геодезийн шигүүрлэлтийн сүлжээ /өтгөрүүлэлтийн сүлжээ |

| | | | |
|---|---|---|---|
| 411 | Өндөр нарийвчлалтай геодезийн сүлжээ | **Р:**Высокоточная геодезическая сеть (ВГС)<br>**E:**High-precision Geodetic Network (HPGN) | Хиймэл дагуулын геодезийн хэмжилт, өндөр нарийвчлалын геометрийн нивелирдлэгийн өгөгдлөөр квазигеоидын өндрийг өндөр нарийвчлалтай тодорхойлсон геодезийн тулгуур сүлжээ |
| 412 | Хиймэл дагуулын геодезийн сүлжээ Дэлхийн Байрлал тогтоох хиймэл дагуулын тогтолцоо | **Р:**Спутниковая геодезическая сеть Глобальная навигационная спутниковая система-ГНСС<br>**E:**Satellite geodetic network, Global Navigation Satellite System-GNSS | Навигацийн хиймэл дагуулын мэдээг ашиглан геодезийн хэмжилтийн математик боловсруулалтаар солбицол тодорхойлсон геодезийн цэгүүд бүхий байгууламж |
| 413 | Геодезийн тулгуур сүлжээг шигүүрүүлэх /өтгөрүүлэх | **Р:**Сгущение опорных геодезических пунктов<br>**E:**Geodetic control densification | Астрономи-геодезийн дээд ангиллын сүлжээг нутаг дэвсгэрийг том масштабын байр зүйн зургаар зурагжуулахад шаардлагатай хэмжээнд нэмэлт сүлжээгээр шигүүрүүлэх үйлдэл |
| 414 | Триангуляци | **Р:**Триангуляция<br>**E:**Triangulation | Гурвалжин хэлбэрээр байгуулж түүний өнцөг, зарим талуудыг хэмжиж геодезийн сүлжээ байгуулах арга |
| 415 | | | |
| 416 | Шугаман триангуляци | **Р:**Линейная триангуляция<br>**E:**Delaunay triangulation | Тухайн гурвалжны оройг дайрч гарсан, өөр гурвалжны оройг дотор талдаа эс агуулсан гурвалжнуудаас үүсэх сүлжээ |
| 417 | Шугаман-өнцгийн триангуляци | **Р:**Линейно-угловая триангуляция<br>**E:**Linear-angle triangulation | Гурвалжны талууд ба өнцгийг нэгэн адил хэмжих, сүлжээг чиглүүлэхийн тулд талууд дээр Лапласын зовхисыг хэмжих триангуляцийн төрөл |
| 418 | Триангуляцийн гинжин хэлхээ | **Р:**Цепь триангуляции<br>**E:**Triangulation chain | Триангуляцийн сүлжээний эгнээний холбоос гурвалжнууд |
| 419 | Геодезийн сүлжээний эгнээ | **Р:**Ряд геодезической сети<br>**E:**Series of geodetic network | Геодезийн сүлжээг уртраг, өргөргийн дагуу байрлалаар гүйцэтгэсэн геометрийн гинжилсэн гурвалжны хэлбэр |
| 420 | Трилатераци | **Р:**Трилатерация<br>**E:**Trilateration | Гурвалжин заримдаа дөрвөн өнцөгт хэлбэрээр байгуулж түүний бүх талуудыг хэмжиж геодезийн сүлжээ байгуулах арга |

| | | | |
|---|---|---|---|
| 421 | Трилатерацийн дөрвөн өнцөгт | **P:**Геодезический четырехугольник трилатерации<br>**E:**Geodetic trilateration quadrilateral | Тэгш өнцөгт дөрвөлжнөөр трилатерацийн сүлжээ байгуулах арга |
| 422 | Өндрийн сүлжээ | **P:**Высотная сеть<br>**E:**Height network | Өндрийг нь тодорхойлж, тэгшитгэн бодсон геодезийн байнгын цэг тэмдэгтийн олонлог |
| 423 | Полигонометрийн сүлжээ | **P:**Полигонометрическая сеть. Полигонометрия<br>**E:**Traversing | Цэг, тэмдэгтийн хоорондох зай, өнцгийг хэмжиж геодезийн сүлжээ байгуулах арга |
| 424 | Полигонометрийн сүлжээг шигүүрүүлэх | **P:**Сгущение полигонометрической сети<br>**E:**Traversing densification | Ахисан зэрэглэлийн полигонометрийн сүлжээг нэмэлтээр шигүүрүүлж байгуулах геодезийн сүлжээний төрөл |
| 425 | Газар доорх геодезийн үндэслэл | **P:**Подземное геодезическое обоснование<br>**E:**Geodetic underground surveying control/network | Газар доогуурх хонгил, байгууламжийн тэнхлэг, овор хэмжээг барьж байгуулахад зориулсан газар доогуур байгуулах полигонометрийн үндсэн ба ажлын сүлжээ |
| 426 | Сансрын геодезийн солбицол тодорхойлох арга | **P:**Метод космической геодезии<br>**E:**Method of space geodesy | Дэлхий ба гаригийн таталцлын нэгдсэн тооллын системийг тогтоох, газрын гадарга дээрх цэгүүдийн солбицол тодорхойлох арга |
| 427 | Геодезийн сүлжээний холболт | **P:**Привязка геодезической сети<br>**E:**Geodetic network referencing | Дээд ангийн сүлжээтэй шинээр байгуулах сүлжээг холбох хэмжилт |
| 428 | Геодезийн огтлол | **P:**Геодезическая засечка<br>**E:**Geodetic intersection | Тодорхойлж байгаа эсвэл эхлэлийн цэг дээр хэмжилт хийх, эсвэл геодезийн байгууламжийн хэлбэрийг ашиглан цэгийн солбицол тодорхойлох арга |
| 429 | Шууд огтлол | **P:**Прямая засечка<br>**E:**(Position) Intersection | Эхлэлийн цэгээс хийсэн огтлолоор солбицол тодорхойлох арга |
| 430 | Урвуу огтлол | **P:**Обратная засечка<br>**E:**(Position) Resection | Тодорхойлж буй цэг дээр хийсэн огтлолоор цэгийн солбицол тодорхойлох арга |
| 431 | Хослуулсан огтлол | **P:**Комбинированная засечка<br>**E:**Combined intersection | Солбицол тодорхойлох зорилгоор шууд ба урвуу огтлолын аргуудыг хослуулсан үйлдэл |
| 432 | Орон зайн шугаман огтлол | **P:**Линейная засечка<br>**E:**Linear intersection | Эхлэл хоёр цэг хүртэлх зайг хэмжихэд суурилсан цэгийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | байрлалыг тодорхойлох үйлдэл |
| 433 | Гурван хэмжээст орон зайн огтлол | **P:**Пространственная засечка<br>**E:**Three-dimensional intersection | Гурав ба түүнээс олон тооны солбицолтой цэгүүд хүртэлх зайг хэмжиж объектын гурван хэмжээст орон зайн солбицол тодорхойлох арга |
| 434 | Өнцгийн огтлол | **P:**Угловая засечка<br>**E:**Angular section | Тулгуур хоёр цэгийн солбицол, түүн дээр хэмжсэн өнцгүүдээр гуравдагч цэгийн солбицол бодох өнцгийн шууд огтлол |
| 435 | Өнцгийн урвуу огтлол | **P:**Угловая обратная Засечка<br>**E:**Angular resection | Солбицлыг нь тодорхойлох цэг дээрээс солбицолтой гурван цэгүүд хоорондох хэвтээ хоёр өнцгийг хэмжиж, тодорхойлж буй цэгийн солбицол бодох арга |
| 436 | Өнцгийн шууд огтлол | **P:**Угловая прямая засечка<br>**E:**Angular intersection | Солбицолтой хоёр цэгээс тодорхойлж буй цэг хүртэлх хоёр хэвтээ өнцөг, мөн хоёр цэгийг холбосон шулууны уртыг хэмжиж цэгийн солбицол тодорхойлох арга |
| 437 | Дурневын огтлол | **P:**Засечка Дурнева<br>**E:**Durnev's intersection | Полигонометрийн сэлгэцийн цэгүүд дээрээс сэлгэцийн хоёр талд байгаа туслах цэгүүдийн солбицлыг олох арга |
| 438 | Геодезийн сүлжээний байгууламж | **P:**Геодезическое построение<br>**E:**Geodetic construction | Геодезийн байрлал, өндрийн сүлжээний цэг дээр босгосон геометрийн дүрс бүхий байгууламж |
| 439 | Геодезийн дөрвөн өнцөгт | **P:**Геодезический четырехугольник<br>**E:**Geodetic quadrangle | Геодезийн сүлжээ байгуулах дөрвөн өнцөгт хэлбэрийн байгууламж |
| 440 | Геодезийн сүлжээний эхлэл тал | **P:**Исходная сторона геодезической сети<br>Исходная сторон<br>**E:**Base-line | Өгөгдсөн чиглэл уртад харьцуулан бусад талын үзүүлэлтийг тодорхойлох геодезийн сүлжээний тал |
| 441 | Суурь талын сүлжээ | **P:**Базисная сеть<br>**E:**Base line network | Геодезийн сүлжээний суурь талын уртаас триангуляцийн сүлжээний талын уртыг тригонометрийн аргаар тодорхойлох гурвалжны систем |
| 442 | Суурь тал | **P:**Базисная сторона<br>**E:**Base line | Геодезийн сүлжээний талыг шууд хэмжиж уртыг тодорхойлсон, бусад талуудын уртыг тодорхойлоход ашиглах триангуляцийн гурвалжны нэг тал |

| | | | |
|---|---|---|---|
| 443 | Суурь талын хэмжилт | **Р:**Базисные измерения **E:**Base-line measurement | Уртын хэмжүүрийн жишиг эсвэл сүлжээний масштабыг хадгалах зорилгоор зайг шууд хэмжих технологийн үйлдэл |
| 444 | Триангуляцийн гурвалжны гарах тал | **Р:**Выходная сторона треугольника триангуляции Выходная сторона **E:**External baseline | Геодезийн суурь талын сүлжээнээс бусад талын уртыг тодорхойлсон триангуляцийн гурвалжны тулгуур тал |
| 445 | Улсын геодезийн сүлжээг нөхөн сэргээх (байрлалын өндрийн, гравиметрийн) | **Р:**Восстановление государственной (геодезической, нивелирной, гравиметрической) сети **E:**Restoration state (geodetic, leveling, gravimetric) networks | Улсын геодезийн сүлжээний суурь өгөгдлүүдийг хадгалах, тогтоосон нарийвчлал, сүлжээний нягтралыг хангахад чиглэгдсэн геодезийн байнгын цэг, тэмдэгт, тэмдэглээсийг сэргээх үйлдвэрлэлийн үйл ажиллагаа |

**ӨНДРИЙН СҮЛЖЭЭ**
**НИВЕЛИРОВАНИЕ**
**LEVELING**

| | | | |
|---|---|---|---|
| 446. | Далай, тэнгисийн дундаж түвшин | **Р:**Средний уровень моря **E:**Mean sea level | Далай тэнгисийн усны түвшний олон жилийн ажиглалтын үр дүнд гаргаж авсан бүх цаг үеийн дундаж үзүүлэлт |
| 447. | Өндөр | **Р:**Высота **E:**Elevation | Тооллын гадаргаас сонгосон цэг хүртэл энэ гадаргын нормалиар хэмжигдсэн зай. Цэгийн өндөр тооллын гадаргаас дээш хэмжигдсэн бол эерэг харин доош хэмжигдсэн бол сөрөг |
| 448. | Ортометрийн өндөр | **Р:**Ортометрическая высота **E:**Orthometric height | Газрын гадарга дээрх тухайн цэгээс геоид (тооллын эхлэлийн гадарга) хүртэл эгц босоо шугамын чиглэлээр хэмжигдсэн зай |
| 449. | Нормаль өндөр $H\gamma$ | **Р:**Нормальная высота $H\gamma$ **E:**Normal height $H\gamma$ | Газрын гадарга дээрх тухайн цэгээс квазигеоид (тооллын эхлэлийн гадарга) хүртэл нормаль шугамын чиглэлээр хэмжигдсэн зай |
| 450. | Динамик өндөр | **Р:**Динамическая высота **E:**Dynamic height | Тухайн цэг дэх геопотенциал хэмжигдэхүүнийг Дэлхийн хүндийн хүчний хурдатгалын зарим тогтмол утгад харьцуулсан тоон утга |
| 451. | Геодезийн өндөр | **Р:**Высота геодезическая **E:**Geodetic height | Газрын гадарга дээрх тухайн цэгээс референц эллипсоид хүртэлх нормаль шугамын чиглэлээр хэмжсэн зай |

| | | | |
|---|---|---|---|
| 452. | Ноёлох өндөр | **P:**Высота командная<br>**E:**Command height | Газрын эерэг хэлбэртэй гадарга дээрх хамгийн өндөр цэг |
| 453. | Үнэмлэхүй өндөр | **P:**Высота абсолютная<br>**E:**Absolute height | Тухайн өндрийн тогтолцоонд тооллын эхлэл болгон авсан түвшнээс газрын гадарга дээрх цэг хүртэлх хүндийн хүчний орны эгц босоо шугамын дагуух зай |
| 454. | Харьцангуй өндөр | **P:**Высота относительная<br>**E:**Relative height | Сонгон авсан буюу тооллын эхлэл болгон авсан түвшнээс гадаргаас газрын гадарга дээрх өгөгдсөн цэг хүртэлх хүндийн хүчний орны эгц босоо шугамын дагуух зай |
| 455. | Багажийн түвшний өндөр | **P:**Высота горизонта прибора<br>**E:**Height of instrument | Тодорхой өндөртэй репер дээр барьсан рейкнээс авсан тооллыг реперийн өндөр дээр нэмж тодорхойлж бодсон нивелирийн харах тэнхлэгийн өндөр |
| 456. | Багажийн өндөр | **P:**Высота прибора<br>**E:**Device height | Цэгийн оройгоос нивелирийн харах хэвтээ тэнхлэг буюу теодолит, тахеометрийн дурангийн эргэх тэнхлэг хүртэлх эгц босоо зай |
| 457. | Өндөржилт | **P:**Превышение<br>**E:**Height difference | Газрын гадарга дээрх цэгүүдийн өндрийн ялгавар |
| 458. | Өндрийн хэмжилт | **P:**Вериткальный измерений<br>**E:**Veritical measurement | Өгөгдсөн талбай дээр зөвхөн цэгүүдийн өндрийг тодорхойлох хэмжилт |
| 459. | Нивелирийн /өндрийн/ сүлжээ | **P:**Нивелирная сеть<br>**E:**Leveling network | Өндрийг нь тодорхойлж, тэгшитгэн бодсон геодезийн байнгын цэг тэмдэгтийн олонлог |
| 460. | Өндрийн сүлжээний хэмжилт | **P:**Измерения нивелирных сетей<br>**E:**Measurements of leveling networks | Геометрийн нивелирдлэгийн аргаар Монгол Улсын өндрийн сүлжээний байгуулах хэмжилт хийх үйл ажиллагаа |
| 461. | Нивелирдлэг | **P:**Нивелирование<br>**E:**Leveling | Газрын гадарга цэгүүдийн өндрийн зөрүүг эхлэл түвшний гадаргатай харьцангуй тодорхойлох арга |
| 462. | Геометрийн нивелирдлэг | **P:**Геометрическое нивелирование<br>**E:**Spirit levelling | Хэвтээгээр хараалах тэнхлэг бүхий геодезийн багажаар хийх нивелирдлэг |
| 463. | Тригонометрийн нивелирдлэг | **P:**Тригонометрическое нивелирование<br>**E:**Trigonometric leveling | Налуугаар хараалах тэнхлэг бүхий геодезийн багаж (теодолит, тахеометр)-аар нивелирдлэг хийх арга |

| | | | |
|---|---|---|---|
| 464. | Тригонометрийн шууд, урвуу нивелирдлэг | **P:**Двухсторонное тригонометрическое нивелирование<br>**E:**Direct/indirect trigonometrical leveling | Налуу харалтын тэнхлэг бүхий геодезийн багаж (теодолит, тахеометр)-аар шууд, урвуу нивелирдлэг хийж цэгүүдийн өндөр тодорхойлох арга |
| 465. | Тригонометрийн нэг талын нивелирдлэг | **P:**Одностороннее тригонометрическое нивелирование<br>**E:**Single-run trigonometrical leveling | Налуу харалтын тэнхлэг бүхий геодезийн багаж (теодолит, тахеометр)-аар нэг чиглэлд нивелирдлэг хийж цэгийн өндөр тодорхойлох арга |
| 466. | Барометрийн нивелирдлэг | **P:**Барометрическое нивелирование<br>**E:**Barometric leveling | Хоёр цэгийн өндрийн зөрүүг агаарын даралтын өөрчлөлтөөр тодорхойлох нивелирдлэг |
| 467. | Агаараас нивелирдлэг хийх | **P:**Аэронивелирование<br>**E:**Aeroleveling | Агаарын зураглалын явцад радио-өндөр хэмжүүр ба статоскопын тусламжтайгаар гадаргын цэгийн өндрийг тодорхойлох арга |
| 468. | Гидростатикийн нивелирдлэг | **P:**Гидростатическое нивелирование<br>**E:**Hydrostatic leveling | Хоорондоо хоолойгоор холбогдож шингэнээр дүүргэсэн хос савуудын даралтын шатлалын зөрүүгээр эхлэл цэгтэй харьцангуйгаар тухайн цэгүүдийн өндрийг тодорхойлох арга |
| 469. | Шууд, урвуу нивелирдлэг | **P:**Нивелирование прямо и обратно<br>**E:**Direct and indirect leveling | Өндрийн I, II ба III ангийн сүлжээ байгуулах арга |
| 470. | Богино цацрагаар нивелирдлэг хийх | **P:**Нивелирование коротким лучом<br>**E:**Shot signhting distance levelling | Барилга байгууламжийн бүтээц, тоног төхөөрөмжийн эд ангийг маш богино зайнд тэнхлэг тохируулагчтай эсвэл авцалдаат тэгшлүүртэй нивелирээр өндөр нарийвчлалтай байрлуулах нивелирдлэгийн төрөл |
| 471. | Квадратаар нивелирдлэг хийх | **P:**Нивелирование по квадратам<br>**E:**Levelling by squares | Барилга байгууламжийн талбай, нисэх буудлын тэгш гадаргыг тэгш өнцөгт дөрвөлжин хэлбэрээр байгуулсан сүлжээгээр цэгүүдийн өндөр тодорхойлох арга |
| 472. | Дундаас нивелирдлэг хийх арга | **P:**Метод нивелирования из середины<br>**E:**Leveling method from the middle | Нивелирийн зогсоолоос арын ба өврийн рейк хүртэлх зай тэнцүү байх үед өндөржилт тодорхойлох арга |
| 473. | Нивелирийн зогсоол | **P:**Нивелирная станция<br>**E:**Leveling station | Цэгүүдийн хоорондох өндөржилтийг тодорхойлох |

| | | | |
|---|---|---|---|
| | | | өндрийн сэлгэцэд өндөр хэмжих багаж байрлуулах цэг |
| 474. | Нивелирийн зогсоолын мөр | **P:**Плечо на нивелирной станции **E:**Leveling line | Нивелирдлэгийн явцад нивелирээс арын ба өврийн рейк хүртэлх зай |
| 475. | Мөрийн зөрүү | **P:**Разность плечо нивелирный станции **E:**Difference of leveling station line | Нивелирдлэгийн явцад нивелирээс арын ба өврийн рейк хүртэлх зайны зөрүү |
| 476. | Улны зөрүү | **P:**Неравенство высот нулей реек **E:**Levling rod difference | Хоёр рейкны улны өндрийн зөрүүг тодорхойлох арга |
| 477. | Геодезийн өндөр хэмжигч Өндөр хэмжигч | **P:**Геодезический высотомер Высотомер **E:**Geodetic altimeter | Өндөр эсвэл өндөржилт тодорхойлох зориулалтын геодезийн багаж |
| 478. | Эхлэл репер | **P:**Репер исходный **E:**Initial benchmark | Өндрийн тоотыг эхлэл болгон авсан репер |

**БАЙРЛАЛ ТОДОРХОЙЛОХ ДАЯАРЧЛАЛЫН ТОГТОЛЦОО**
**ГЛОБАЛЬНАЯ СИСТЕМА ОПРЕДЕЛЕНИЯ МЕСТОПОЛОЖЕНИЯ**
**GLOBAL POSITIONING SYSTEM**

| | | | |
|---|---|---|---|
| 479. | Байрлал тодорхойлох | **P:**Позиционирование **E:**Positioning, GPS measurement, GPS surveying | 1.Навигацийн хиймэл дагуулыг ашиглан навигацийн хүлээн авагчаар объектын орон зайн солбицлыг тодорхойлох<br>2.Хөдөлгөөнт биетийг шаардлагатай байрлалд шилжүүлэх зорилготой шилжилт хөдөлгөөнийг нь хянах үйл ажиллагаа.<br>*Тайлбар: Объект гэдэгт геодези, газар зохион байгуулалт, кадастрын зураглалд ашиглах улсын, орон нутгийн геодезийн сүлжээний цэгүүд хамаарна.* |
| 480. | Үнэмлэхүй байрлал тодорхойлох | **P:**Абсолютные (навигационные) определения местоположения **E:**Absolute positioning, single point positioning, point positioning) | Хиймэл дагуулуудын хэмжилтээр объектын байрлал ба цаг хугацааг бусад цэгүүд дээрх хэмжилтүүдээс хамаарахгүйгээр нэг хүлээн авагчаар тодорхойлох арга |
| 481. | Навигацийн хиймэл дагуулын тогтолцоо | **P:**Навигационная спутниковая система **E:**Navigation satellite system | Сансрын навигацийн хиймэл дагуул дээр байрлуулсан төхөөрөмжөөс радио долгионоор дамжуулж буй фаз, код, цагийн мэдээг хүлээн авч суурь талыг бодох замаар орон |

| | | | |
|---|---|---|---|
| | | | зайн солбицлыг заасан системд тодорхойлох тогтолцоо |
| 482. | Харьцангуй байрлал тодорхойлох | **P:**Относительное позиционирование<br>**E:**Relative positioning | Тулгуур цэг ба тодорхойлж буй цэгүүд дээр байрлуулсан навигацийн системийн хүлээн авагчдын боловсруулалтыг хамтатган хийж хоорондох векторыг бодох замаар байрлал тодорхойлох технологи |
| 483. | Дифференциал аргаар харьцангуй байрлал тодорхойлох | **P:**Относительные (дифференциальные) определения<br>**E:**Differential positioning, relative positioning | Тулгуур цэг дээрх хүлээн авагчийн хэмжилтийн үр дүнгээр байрлалыг нь тодорхойлох цэг дээрх хүлээн авагчдын хэмжилтийн үзүүлэлтүүдэд зохицсон засваруудыг тодорхойлох замаар хэмжилтийн боловсруулалтаа тус тусдаа хийж байрлал нарийвчлан тодорхойлох арга |
| 484. | Дифференциал аргаар байрлал тодорхойлох | **P:**Дифференциальное позиционирование<br>**E:**Differential positioning | Дөрөв ба түүнээс дээш навигацийн хиймэл дагуулуудаас дамжуулсан радио долгионыг навигацийн системийн хүлээн авагч хүлээн авч радио долгионуудын уртыг нь фазын аргаар бодож замаар тодорхойлсон суурь талуудын шууд огтлолоор тухайн агшинд байрлал тодорхойлох арга |
| 485. | Байрлал тодорхойлох глобал тогтолцоо | **P:**Глобальная система определения место положения<br>**E:**GPS-Global Positioning System | АНУ-ын байрлал тодорхойлох даяарчлалын хиймэл дагуулын тогтолцоо |
| 486. | Анхдагч байрлалыг тодорхойлох | **P:**Автономное позиционирование<br>**E:**Autonomous positioning | Дөрөв ба түүнээс дээш хиймэл дагуулаас навигацийн системийн хүлээн авагч хүртэлх суурь талыг кодын мэдээний тусламжтайгаар бодож шууд огтлолоор тухайн агшинд байрлал тодорхойлох арга |
| 487. | Байрлал тодорхойлох хиймэл дагуулын тогтолцоо | **P:**Спутниковая система позиционирования<br>**E:**Satellite positioning system | Хиймэл дагуулаас илгээж буй долгион хүлээн авч боловсруулалт хийх зарчим дээр үндэслэсэн байрлалын тогтолцоо |
| 488. | Навигаци; Чиглэл тодорхойлох ухаан | **P:**Навигация<br>**E:**Navigation | Нисэх хэрэгсэл болон онгоцны нислэгийн замналыг тодорхой утгаараа удирдан чиглүүлэг хийх онол, хэрэглээний аргыг |

| | | | |
|---|---|---|---|
| | | | багтаасан, улмаар түүний хөдөлгөөнийг чиглүүлэх тоноглол, багаж, хэрэгсэл, радио замналын систем зэргийн тусламжтайгаар байрлалыг тооцох, тодорхойлох аргыг судалдаг шинжлэх ухааны чиглэл |
| 489. | Байрлал тодорхойлох глобал тогтолцоо-NAVSTAR-GPS | **Р:**Американская Глобальная Навигационная Спутниковая Система-<br>**E:**Navigation System by Timing and Ranging-NAVSTAR<br>GPS-Global Positioning System | Дэлхийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хөдөлгөөнт ба хөдөлгөөнт бус объектуудын байрлал тодорхойлох АНУ-ын даяарчилсан хиймэл дагуулын тогтолцоо |
| 490. | Байрлал тодорхойлох глобал тогтолцоо-ГЛОНАСС | **Р:**Глобальная навигационная спутниковая система-<br>**E:**Global Navigation Satellite System-GLONASS | Дэлхийтэй харьцангуй солбицлын тогтолцоонд геодезийн сүлжээний байршил тодорхойлох зориулалттай ОХУ-ын хиймэл дагуулын тогтолцоо |
| 491. | GPS долоо хоног | **Р:**GPS неделя<br>**E:**GPS week | GPS нь 1980 оны 01 сарын 05-06 шилжих шөнийн 00 цаг (0 цаг)-ийг эхлэл болгон түүнтэй харьцангуйгаар дагуул бүрээс цагийн мэдээ хүлээн авдаг ба үүний 7 хоног бүрийг тоон утгаар тэмдэглэснийг GPS-ийн 7 хоног гэж нэрлэнэ. Жишээ нь:2021 оны 06 дугаар 09-ны өдөр нь 2161 дэх GPS-ийн 7 хоногийн 4 дэх өдөр юм. |
| 492. | Геодезийн сүлжээний цэгийн байрлал тодорхойлох | **Р:**Определение координат пункта спутниковой геодезической сети по навигационными спутниковыми измерениями<br>**E:**Determining coordinates of geodetic point by navigation satellite measurements | Навигацийн хүлээн авагчийг ашиглаж геодезийн сүлжээний цэгийн төвийн орон зайн солбицлыг тодорхойлох арга |
| 493. | Геодезийн сүлжээний цэгийн солбицол | **Р:**Абсолютный метод определения координат пункта спутниковой | Геодезийн сүлжээний цэгийн байрлалыг хиймэл дагуулуудын хэмжилтээр бусад цэгүүд дээрх хэмжилтүүдээс |

| | | | |
|---|---|---|---|
| | тодорхойлох үнэмлэхүй арга | геодезической сети по навигационным спутниковым измерением<br>**E:**Absolute method of Determining coordinates of geodetic point by navigation satellite measurements | хамааралгүйгээр гурван хэмжээсээр тодорхойлох арга |
| 494. | Геодезийн сүлжээний цэгийн солбицол тодорхойлох харьцангуй арга | **P:**Относительный метод определения координат пункта спутниковой геодезической сети по навигационным спутниковым измерениям<br>**E:**Relative method of Determining coordinates of geodetic point by navigation satellite measurements | Дэлхий төвт, дэлхийтэй харьцангуй буюу орон зайн солбицлын тогтолцоонд навигацийн хиймэл дагуулын геодезийн сүлжээний цэгийн солбицлыг навигацийн хүлээн авагчаар тулгуур цэгтэй харьцангуйгаар тодорхойлох арга |
| 495. | Навигацийн хиймэл дагуулын хэмжилтийн нарийвчлал | **P:**Точность навигационных определений ГНСС<br>**E:**The accuracy of navigation GNSS | Навигацийн хиймэл дагуулаас хүлээн авагч хүртэлх суурь талыг гадаад<br>(цагийн явалт, сансрын радиац, сансрын даралт) засварыг тооцож, орон зайн солбицлыг тодорхойлох нарийвчлал |
| 496. | Навигацийн тодорхойлолтын стандарт алдаа | **P:**Стандартная погрешность навигационных определений ГНСС<br>**E:**Standard error of navigation GNSS | Хиймэл дагуулын хөдөлгөөний вектор хурд, цагны заалтын засвар, орон зайн солбицлыг тодорхойлох өгөгдсөн түвшин |
| 497. | Хэрэглэгчдийн байршил тодорхойлох үнэмлэхүй нарийвчлал | **P:**Абсолютная точность определения местоположения потребителя ГНСС<br>**E:**Absolute accuracy of GNSS positioning | Навигацийн хиймэл дагуулаас хүлээн авагч хүртэлх суурь талыг гадаад болон дотоод (Дэлхийн эргэлт, туйлын шилжилт, туйлын долгисол, хүлээн авагчийн цагийн явалт) хүчин зүйлсийг тооцон дэлхий төвт орон зайн солбицлын тогтолцоонд хэрэглэгчдийн байршил тодорхойлох нарийвчлал |
| 498. | Хэрэглэгчдийн байршил тодорхойлох үнэлэхүй алдаа | **P:**Асолютная погрешность определения | Навигацийн хиймэл дагуул хэрэглэгчдийн байршлыг геотөвт орон зан солбицлын |

| | | | |
|---|---|---|---|
| | | местоположения потребителя ГНСС<br>**E:**Asolute error of GNSS positioning | тогтолцоонд тодорхойлох нарийвчлал |
| 499. | Нарийвчлал бууруулах геометр хүчин зүйл | **P:**Геометрический фактор понижения точности<br>**E:** Dilution of Precision | Хиймэл дагуулын геометр байрлалаас байршил ба цагийг тодорхойлох нарийвчлалыг бууруулах үзүүлэлтийг тодорхойлох хүчин зүйл |
| 500. | Навигацийн хиймэл дагуул хэрэглэгчдийн босоо байршил тодорхойлох нарийвчлалын геометр хүчин зүйл | **P:**Геометрический фактор точности определения местоположения потребителя ГНСС по вертикали<br>**E:**Vertical Dilution of Precision | $VDOP = \frac{\sigma_h}{\sigma_{\text{пд}}}$- Хэрэглэгчдийн өндрийн $\sigma_h$ байршлыг тодорхойлох дундаж квадрат алдаа ба навигацийн хиймэл дагуулын хуурамч $\sigma_{\text{пд}}$ алслал хүртэл зайг тодорхойлох дундаж квадрат алдаа хороондын пропорционал итгэлцүүр |
| 501. | Өндөр тодорхойлох нарийвчлалыг бууруулах геометр хүчин зүйл | **P:**Геометрический фактор понижения точности определения высоты<br>**E:** Geometric factor of Vertical Dilution of Precision | Хиймэл дагуулын геометр байрлалаас хамаарсан өндрийг тодорхойлох нарийвчлалыг бууруулах үзүүлэлтийг тодорхойлох хүчин зүйл |
| 502. | Навигацийн хиймэл дагуул хэрэглэгчдийн орон зайд байршил тодорхойлох нарийвчлалын геометр хүчин зүйл | **P:**Геометрический фактор точности определения местоположения потребителя ГНСС в пространстве<br>**E:**Geometric/Position Dilution of Precision | $PDOP = \sqrt{HDOP^2 + VDOP^2}$- Навигацийн хиймэл дагуул хэрэглэгчдийн орон зайн солбицол тодорхойлох нарийвчлалын итгэлцүүр |
| 503. | Орон зайд байршил тодорхойлох нарийвчлалыг бууруулах геометр хүчин зүйл | **P:**Геометрический фактор понижения точности определения местоположения в пространстве<br>**E:**Geometric factor of Geometric/Position Dilution of Precision | Хиймэл дагуулын геометр байрлалаас хамаарсан орон зайд байрлалыг тодорхойлох нарийвчлалыг бууруулах үзүүлэлтийг тодорхойлох хүчин зүйл |
| 504. | Хүлээн авагчийн цагны заалтыг тодорхойлох нарийвчлалыг бууруулах геометр хүчин зүйл | **P:**Геометрический фактор понижения точности определения показаний часов приемника<br>**E:**Geometric factor to reduce the accuracy of | Хиймэл дагуулын геометр байрлалаас хамаарсан цагийн заалтын тодорхойлох нарийвчлалыг бууруулах үзүүлэлтийг тодорхойлох хүчин зүйл |

| | | | |
|---|---|---|---|
| | | determining the receiver clock | |
| 505. | Навигацийн хиймэл дагуул хэрэглэгчдийн хэвтээ байршил тодорхойлох нарийвчлалын геометр хүчин зүйл | **Р:**Геометрический фактор точности определения местоположения потребителя ГНСС по горизонтали<br>**E:**Horizontal Dilution of Precision | $HDOP = \frac{\sqrt{\sigma_x^2+\sigma_y^2}}{\sigma_{\text{пд}}}$ Хэрэглэгчдийн хавтгайн солбицол $\sigma_x$ ба $\sigma_y$ тодорхойлох дундаж квадрат алдаа ба навигацийн хиймэл дагуулын хуурамч $\sigma_{\text{пд}}$ алслал хүртэл зайг тодорхойлох дундаж квадрат алдаа хороондын пропорцианал итгэлцүүр |
| 506. | Байрлалын солбицол тодорхойлох нарийвчлалыг бууруулах геометр хүчин зүйл | **Р:**Геометрический фактор понижения точности плановых координат<br>**E:**Geometric factor of Horizontal Dilution of Precision | Хиймэл дагуулын геометр байрлалаас хамаарсан байрлалын солбицлыг тодорхойлох нарийвчлалыг бууруулах үзүүлэлтийг тодорхойлох хүчин зүйл |
| 507. | Фазын хэмжилтийн нэг дэх (эхний) зөрүү | **Р:**Первичные разности (фазовых измерений в спутниковых наблюдениях)<br>**E:**Primary difference (phase measurements satellite observations) | Навигацийн нэг хиймэл дагуулаас хоёр хүлээн авагч дээр нэг агшинд хийх фазын хэмжилтийн зөрүү |
| 508. | Фазын хэмжилтийн хоёр дахь зөрүү | **Р:**Вторичные разности (фазовых измерений в спутниковых наблюдениях)<br>**E:**Second differences (phase measurements satellite observations) | Навигацийн хоёр хиймэл дагуулаас хоёр хүлээн авагч дээр нэг агшинд хийх хоёр фазын хэмжилтийн зөрүү |
| 509. | Фазын хэмжилтийн гурав дахь зөрүү | **Р:**Третья разность (фазовых измерений в спутниковых наблюдениях)<br>**E:**Third differences (phase measurements in satellite observations) | Хоёр өөр агшинд хэмжсэн хоёр фазын зөрүүний ялгавар |
| 510. | Хиймэл дагуулын хэмжилтийн математик боловсруулалт | **Р:**Постобработка навигационных спутниковых измерений | Орон зайн тэгш өнцөгт солбицлыг тодорхойлох зорилгоор хиймэл дагуулын геодезийн сүлжээний цэгүүдээс даяарчлалын хиймэл дагуулын хэрэглэгчдийн хүлээн авагчийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | **E:**Post-processing of navigation satellite measurements | тусламжтайгаар хиймэл дагуулын хэмжилтийн үр дүнг суурин аргаар математик боловсруулалт хийх арга |
| 511. | Навигацийн хиймэл дагуулын хэмжилт | **P:**Навигационное спутниковое измерение **E:**Navigation satellite measurement | Навигацийн хиймэл дагуулаас дамжуулж буй радио долгионоор илгээсэн мэдээг навигацийн хүлээн авагчаар хүлээн авч, боловсруулах үйлдэл |
| 512. | Навигацийн мэдээлэл | **P:**Навигационная информация **E:**Navigation information | Навигацийн хүлээн авагчийн цаг хугацаатай харьцангуй вектор өөрчлөлтийн өгөгдөл |
| 513. | P-код | **P:**Радио сигнал высокой точности-P код **E:**P-code precision code | Навигацийн хиймэл дагуулын радио дохионы дециметрийн нарийвчлалтай хэмжилтийн код |
| 514. | C/A-код | **P:**Радио сигнал стандартной точности **E:**Coarse acquisition code | Навигацийн хиймэл дагуулын радио дохионы метрийн нарийвчлалтай хэмжилтийн код |
| 515. | Гравиметрийн ажлын навигацийн хангалт | **P:**Навигационное обеспечение гравиметрических работ **E:**Navigation ensuring gravimetric works | Тэнгисийн гравиметрийн хүндийн хүчний хурдатгал тодорхойлсон цэгийн солбицол, усны гүн болон хөлгийн хурд, чиглэлийг тодорхойлох иж бүрэн ажил |
| 516. | Навигацийн хиймэл дагуулын дохио | **P:**Навигационный сигнал ГНСС **E:**Navigation signal of GNSS | Навигацийн хиймэл дагуулын навигацийн мэдээлэл, цагны заалтыг дамжуулж буй хэрэглэгчдэд зориулсан радио дохио |
| 517. | Радио навигацийн дохио | **P:**Радио-навигационный сигнал **E:**Radio navigational signal | Навигацийн мэдээллийг агуулж буй навигацийн хиймэл дагуулын дохио |
| 518. | Дифференциал засвар | **P:**Дифференциальная поправка **E:**Differential correction | Хэрэглэгчдийн орон зайн солбицлын нарийвчлалыг сайжруулах зорилгоор фазын үлдэгдлийг тооцох засвар |
| 519. | Дифференциал горим | **P:**Дифференциальный режим **E:**Differential mode | GNSS-ийн хоёр ба түүнээс дээш хиймэл дагуулаас тухайн агшинд хүлээн авсан хоёр ба түүнээс дээш долгионуудад дифференциал засварыг тооцож байрлал тодорхойлох ажлын горим |

| | | | |
|---|---|---|---|
| 520. | Статик горим | **P:**Статический режим<br>**E:**Static mode | Хугацааны тодорхой заагт тулгуур болон үл мэдэгдэх цэг дээр байрлуулсан хүлээн авагчаар зэрэг хэмжсэн GNSS-ийн хоёр ба түүнээс дээш хиймэл дагуулаас антен хүртэл хэмжсэн суурь талуудын дунджаар тулгуур цэгтэй харьцангуй векторыг тодорхойлох ажлын горим |
| 521. | Статик хэмжилт | **P:**Быстрый статический метод<br>**E:**Static measurement | Зөөврийн хүлээн авагчаар нэг цэг дээр 5-20 минутын нэг удаагийн хэмжилт хийх хиймэл дагуулын харьцангуй тодорхойлолт хийх арга |
| 522. | Кинематик хэмжилт | **P:**Кинематический способ<br>**E::**Kinematic measurement | Хугацааны тухайн агшинд тулгуур болон үл мэдэгдэх цэг дээр байрлуулсан хүлээн авагчаар зэрэг хэмжсэн GNSS-ийн хоёр ба түүнээс дээш хиймэл дагуулаас антен хүртэл хэмжсэн суурь талуудаар цэгүүдийн хоорондох солбицлын өсөлтийг тулгуур цэгтэй харьцангуйгаар тодорхойлох ажлын горим |
| 523. | Хэмжилтийн ээлж | **P:**Сеанс (спутниковых) наблюдений (сессия)<br>**E:**Session | Хиймэл дагуулуудын өгөгдлүүд, хэмжилт эхлэх хугацаа ба солбицлуудаас хамааран тогтоогддог хэмжилтийн өгөгдөл цуглуулах цаг хугацааны давталтын үе |
| 524. | “Зогс-яв” хэмжилт | **P:**Режим измерении «Стой-иди»<br>**E:**Stop and go, semi-kinematic measurement | Зөөврийн хүлээн авагчаар цэг дээр 1 минут хүртэл хугацаагаар хэмжилт хийх кинематик хэмжилтийн арга |
| 525. | Кинематик аргаар байршил тодорхойлох горим | **P:**Кинематический режим определения местоположения<br>**E:**Kinematic positioning mode | Хэрэглэгчдийн байршил орон зай, цаг хугацааны орчинд байнга өөрчлөгдөх үеийн хүлээн авагчийн байрлалыг тодорхойлох горим |
| 526. | Бодит агшны кинематик хэмжилтийн горим | **P:**Кинематический режим определения реальном масштабе времени<br>**E:**Real-time kinematic mode | Хиймэл дагуулын геодезийн сүлжээний тодорхойлж буй цэг дээр хийсэн хэмжилтийн мэдээллийг боловсруулахын тулд холбооны сүлжээгээр тулгуур сүлжээний цэг рүү дамжуулах кинематик горим |
| 527. | Хүлээн авагч | **P:**Геодезический спутниковый приемник | Геодезийн ажил гүйцэтгэх зориулалтаар хиймэл дагуулаас |

| | | | |
|---|---|---|---|
| | | **E:**Geodetic satellite receiver | дамжуулж буй кодын фазын мэдээллийг авах хүлээн авагч |
| 528. | Олон давтамжтай геодезийн хүлээн авагч | **P:**Многочастотная геодезическая навигационная аппаратура потребителя ГНСС **E:**Multi-frequency geodetic navigation receiver of GNSS | Навигацийн хиймэл дагуулын 2-оос дээш ($GPS\ L1, L2, L5, C\ Galileo\ E1, E2C, E2$) давтамж дээр үүсгэсэн дохио хүлээн авах хүлээн авагч |
| 529. | Нэг давтамжтай геодезийн хүлээн авагч | **P:**Одночастотная геодезическая навигационная аппаратура потребителя ГНСС **E:**Single-frequency geodetic navigation receiver of GNSS | Навигацийн хиймэл дагуулын 1 ($GPS\ L1, Galileo\ E1$ гэх мэт) давтамж дээр үүсгэсэн дохио хүлээн авах хүлээн авагч |
| 530. | Хоёр давтамжтай геодезийн хүлээн авагч | **P:**Двухчастотная геодезическая навигационная аппаратура потребителя ГНСС **E:**Dual-frequency geodetic navigation receiver of GNSS | Навигацийн хиймэл дагуулын 2 ($GPS\ L1, L2\ Galileo\ E1, E2$ гэх мэт) давтамж дээр үүсгэсэн дохио хүлээн авах хүлээн авагч |
| 531. | Автозамын навигацийн газрын зураг | **P:**Навигационная карта для автомобильных дорог **E:** Navigational Road Chart | Авто тээврийн навигацийн асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий газар орчны навигацийн мэдээллийг агуулсан төрийн болон хувийн хэвшлийн газрын зураг |
| 532. | Тэнгисийн навигацийн газрын зураг | **P:**Навигационная морская карта **E:** Navigational Nautical Chart | Усан тээврийн хөлөг онгоц жолоодоход ашиглах навигаци-ус зүйн элементийн мэдээлэл агуулсан газрын зураг |
| 533. | Олон улсын байнгын ажиллагаатай станцуудын сүлжээ | **P:**Сеть станций IGS **E:**IGS Network | Олон улсын геодезийн албанаас Дэлхийн эргэлт, гадаргуун өөрчлөлтийг судлах зорилгоор байгуулсан ГЛОНАСС (GPS)-ын байнгын ажиллагаатай станцуудын сүлжээ |
| 534. | ПЗ-90 солбицлын тоглолцоо | **P:**Система ПЗ-90 /Система позицирование/ **E:**Positioning system-90 | Дэлхийн хүндийн хүчний төвд солбицлын эхлэлтэй ОХУ-ын 1990 оны солбицлын тогтолцоо |
| 535. | Өгөгдлийн RINEX формат | **P:**Формат данных RINEX **E:**RINEX data | Навигацийн хүлээн авагчийн хэмжилтийн өгөгдлийг солилцох олон улсын нэгдсэн загвар |

| | | | |
|---|---|---|---|
| 536. | Суурь вектор | **Р:**Опорный вектор<br>**E:**Base vector | Навигацийн хүлээн авагчийн антен байрлуулсан хоёр цэгийн хоорондох суурь вектор |
| 537. | Вектор хурд | **Р:**Вектор скорости<br>**E:**Speed vector | Хоёр өөр эрин дэх хиймэл дагуулын хүлээн авагчийн солбицлын тэнхлэг бүр дээрх өөрчлөлт |
| 538. | Хиймэл дагуулын геодезийн хэмжилтийн байнгын ажиллагаатай станц/CORS/ | **Р:**Постоянная станция геодезических измерений_ГНСС<br>**E:** Continuously Operating Reference Stations of GNSS | Навигацийн хиймэл дагуулын дохио хүлээн авах, хадгалах, боловсруулах, өөрийн солбицол, өндрийг тухайн агшин бүрд тодорхойлох, мэдээллээ хэрэглэгчдэд түгээх байнгын тасралтгүй үйл ажиллагаатай иж бүрэн цахим төхөөрөмж бүхий байгууламж |
| 539. | Хуурмаг алслал | **Р:**Псевдодальность<br>**E:**Pseudorange | Навигацийн хиймэл дагуулаас хүлээн авагч хүртэлх гадаад засвар тооцоогүй зай |
| 540. | Хуурмаг хурд | **Р:**Псевдоскорость<br>**E:**Pseudospeed | Хэрэглэгчдийн хүлээн авагчийн хиймэл дагуул дээрх зохих цахим хэлбэлзлийн үелзлийг бодит утгыг харгалзахгүйгээр тодорхойлсон хүлээн авагч ба хиймэл дагуул хоорондох зайны өөрчлөлт |
| 541. | Антены өндөр | **Р:**Высота антенны навигационной аппаратуры потребителя ГНСС<br>**E:**Antenna height | Геодезийн цэгийн төвөөс босоо шулууны дагуух навигацийн хиймэл дагуулын хүлээн авагчийн антены харьцуулах цэг хүртэлх зай |
| 542. | Альманах | **Р:**Альманах<br>**E:**Almanac | Хиймэл дагуулын радионавигацийн системийн нэг ба хэд хэдэн хиймэл дагуулуудын цагны явалт ба тойрог замын хөдөлгөөнүүдийг нь үнэлэх боломжоор хангадаг үзүүлэлтүүдийн (мэдээллийн) багц |
| 543. | Модем | **Р:**Модем<br>**E:**Modem | Тоон дохиог аналоги хэлбэрт эсвэл эсрэгээрээ аналоги хэлбэрийг холбооны шугамаар дамжуулахад зориулж буцаан хувиргах зориулалттай хувиргагч төхөөрөмж |
| 544. | Цэнэгт мандал | **Р:**Ионосфера<br>**E:**Ionosphere | Дэлхийгээс дээшээ 50-1000 км өндөрт орших нарны радиацаар цэнэглэгдсэн Дэлхийн агаар мандлын давхарга |

| | | | |
|---|---|---|---|
| 545. | Цэнэгт мандлын саатал | **P:**Иносферная задержка<br>**E:**Ionospheric delay | Радио долгион нь агаар мандлын давхаргыг нэвтрэх үедээ зөөгч давтамж ба электрон нягтралаасаа хамааралтай хэмжээгээр саатах явц (үзэгдэл) |
| 546. | Шим мандал | **P:**Тропосфера<br>**E:**Troposphere | Дэлхийн туйл орчим газрын гадаргаас 8 км, экватор дээр 17 км орчим өндөрт орших Дэлхийн агаар мандлын дотоод хэсэг |
| 547. | Шим мандлын саатал | **P:**Тропосферная задержка<br>**E:**Tropospheric delay | Агаар мандлын дундын нөлөөллөөс болж хиймэл дагуул ба хүлээн авагч хоорондын геометр зайнаас хэмжсэн зай уртсах явц (үзэгдэл ) |
| 548. | Эфемерид | **P:**Эфемерид<br>**E:**Ephemeris | Тухайн радио долгион дамжуулсан хиймэл дагуулын өөрийн нь байрлал, байдлын тухай мэдээлэл |
| 549. | Навигацийн хиймэл дагуулын эфемерид мэдээлэл | **P:**Эфемеридная информация ГНСС<br>**E:**Ephemeris information of GNSS | Навигацийн хиймэл дагуулаас дамжуулж мэдээллээр хэрэглэгчид орон зайн солбицол, хөдөлгөөний вектор хурд, цагны заалтын засварыг тодорхойлох цогц өгөгдлүүд |
| 550. | Өндрийн хязгаарлалт | **P:**Маска высоты<br>**E:**Cut-off elevation, Elevation mask | Тэнгэрийн объектуудыг (хиймэл дагуулууд, квазарууд гэх мэт) хэмжилтэд оролцуулахгүй байх байршлын тэнгэрийн хаяанаас дээших өндрийн өнцгийн хязгаар |
| 551. | Доплерын үзэгдэл | **P:**Доплеровый эффект<br>**E:**Doppler effect | Долгион үүсгэгч ба хүлээн авагч хоёрын хөдөлгөөнөөс болж, хүлээн авагчийн бүртгэх долгионы давтамж өөрчлөгдөх үзэгдэлд тулгуурлан биетийн хөдөлгөөний хурдыг тодорхойлох сансрын геодезийн хэмжилтийн арга |

**ГЕОДЕЗИЙН ХЭМЖИЛТИЙН МАТЕМАТИК БОЛОВСРУУЛАЛТ**
**МАТЕМАТИЧЕСКАЯ ОБРАБОТКА ГЕОДЕЗИЧЕСКИХ ИЗМЕРЕНИЙ**
**MATHEMATICAL PROCESSING OF GEODETIC MEASUREMENTS**

| | | | |
|---|---|---|---|
| 552. | Арифметик | **P:**Арифметика<br>**E:**Arithmetic | Тооны энгийн шинж чанар ба тэдгээрийн үйлдлийг судлах ажлыг эрхлэх математикийн хэсэг |
| 553. | Арифметик дундаж | **P:**Арифметическое среднее<br>**E:**Arithmetical average | Аливаа хэмжигдэхүүнийг ижил нарийвчлалтайгаар хэмжиж гарсан утгуудын дундаж утга |

| | | | |
|---|---|---|---|
| 554. | Жингийн арифметик дундаж | **Р:**Среднее арифметическое весовое<br>**E:**Weighted arithmetic mean | Ижил бус нарийвчлалтай хэмжилтийн үр дүнд хэмжилтийн жинг тооцсон арифметикийн дундаж |
| 555. | Арифметик энгийн дундаж | **Р:**Среднее арифметическое простое<br>**E:**Simple arithmetic mean | Ижил бус нарийвчлалтай хэмжилтийн үр дүнгийн арифметикийн дундаж |
| 556. | Дундажлах /Интерполяц | **Р:**Интерполяция<br>**E:**Interpolation | Хэмжигдэхүүний мэдэгдэж буй холбогдлуудыг ашиглан тэдгээрийн хооронд орших холбогдлуудыг эрж олох үйлдэл |
| 557. | Геодезийн хэмжилтийн математик боловсруулалтын онол | **Р:**Теория математической обработки геодезических измерений (ТМОГИ)<br>**E:**Theory of mathematical processing of geodetic measurements | Хэмжилтийн хамгийн найдвартай эцсийн үр дүнг гаргах бодолтын арга, аргачлалын дүрэм, хэмжилтийн нарийвчлалын үнэлгээ, тооцоо хийх, геодезийн хэмжилтийн ажлын чанар, зайлшгүй гарах хамгийн бага алдаа үүсэх, нөлөөллийг судлах математик арга зүй |
| 558. | Хамгийн бага квадратын арга | **Р:**Метод наименьших квадратов<br>**E:**Least square method | Геодезийн хэмжилтийн үр дүнг алдаануудын квадратуудын нийлбэр хамгийн бага байх нөхцөлөөр тэгшитгэн бодох математик арга |
| 559. | Солбицлын хөрвүүлэлт | **Р:**Трансформирование координат<br>**E:**Coordinate transformation | Нэг ижил эхлэл өгөгдөл дээр суурилсан хоёр солбицлын суурь тогтолцооны хооронд хийгдэх солбицлын хөрвүүлэлтийн үйлдэл |
| 560. | Солбицлын хувиргалт | **Р:**Переообразования координат<br>**E:**Coordinate conversion | Өөр тусгагт тулгуурласан хоёр солбицлын тогтолцоо дээр хийгдэх солбицлын үйлдэл.<br>*Тайлбар:Солбицлын хувиргалтыг хийхэд хоёр солбицлын тогтолцоонд солбицол нь мэдэгдэж буй цэгүүдийн багцаар эмпирик аргаар тогтоосон үзүүлэлтийг ашиглана.* |
| 561. | Солбицол хөрвүүлэлтийн нарийвчлал | **Р:**Точность трансфор-мирования координат<br>**E:**Transformation accuracy | Хөрвүүлэлт хийсэн солбицлын утга солбицлын тооллын тогтолцоонд тогтоосон жинхэнэ утгатай ойролцоо болох үйлдэл |

| | | | |
|---|---|---|---|
| 562. | Сансрын геодезийн геометр аргууд | **Р:**Геометрические методы космической геодезии<br>**Е:**Geometric methods of space geodesy | Эрж буй үл мэдэгдэгчийн хэмжилтийн геометрийн холбоосон дээр үндэслэгдсэн цэгийн байрлал тодорхойлох аргууд |
| 563. | Геодезийн шууд бодлого | **Р:**Прямая геодезическая задача<br>**Е:**Direct geodetic problem | Шулууны эхлэл цэгийн солбицол болон тухайн өгөгдсөн чиглэлийн зүглэлийн өнцөг, зайн уртыг ашиглан шулууны төгсгөл цэгийн солбицлыг тодорхойлох бодлого |
| 564. | Геодезийн урвуу бодлого | **Р:**Обратная геодезическая задача<br>**Е:**Indirect geodetic problem | Шулууны эхлэл ба төгсгөл цэгийн солбицлуудаар тэдгээрийн хоорондын зайн урт, чиглэлийн зүглэлийн өнцгийг тодорхойлох бодлого |
| 565. | Ганзены бодлого | **Р:**Задача Ганзена<br>**Е:**Hansen᾽s problem | Өгөгдсөн хоёр цэгийн тусламжтайгаар шинээр хоёр цэгийн солбицлыг тодорхойлох бодлого |
| 566. | Потенотын бодлого | **Р:**Задача Потенота<br>**Е:**Pothenot surveying problem | Тулгуур гурваас доошгүй цэгийн тусламжтайгаар хэвтээ өнцөг хэмжих замаар зогсож байгаа цэгийн байрлалыг тодорхойлох геодезийн урвуу бодлогын нэг хэлбэр |
| 567. | Болотовын арга | **Р:**Способ Болотова<br>**Е:**Bolotova method | Газрын зураг дээр байгаа гурван цэгийн байрлалаас дөрөв дэх цэгийн байрлалыг тодорхойлох график арга |
| 568. | Петерсийн томьёо | **Р:**Формула Петерса<br>**Е:**Peters's formula | Хэсэг ижил нарийвчлалын хэмжигдэхүүний үнэмлэхүй магадлалын алдааны нийлбэрээр хэмжилтийн дундаж квадрат алдааг бодох томьёо |
| 569. | Ферреро томьёо | **Р:**Формула ферреро<br>**Е:**Ferrero’s formula | Ижил нарийвчлалын хэмжилтийн гурвалжны өнцгийн алдааны нийлбэрээр, хэмжсэн өнцгийн дундаж квадрат алдааг бодох томьёо |
| 570. | Гаусс алгоритм | **Р:**Гаусса алгоритм<br>**Е:**Gaussian algorithm | Үл мэдэгдэгчийг дараалан хасах аргаар тодорхой шугаман тэгшитгэлийн системийг бодох цогц арга |
| 571. | Урьдчилсан бодолтууд | **Р:**Предварительные вычисления<br>**Е:**Preliminary calculations | Хээрийн хэмжилтийн материалыг дахин шалгах, хэмжилтийн зөрүү болон зөвшөөрөгдөх утгыг бодох тэгшитгэн бодолтын өмнөх бодолт |

| | | | |
|---|---|---|---|
| 572. | Бодолтын шалгалт | **Р:**Контроль вычислений<br>**E:**Geodetic control measurements | Тооны нэг утгыг дахин нэг удаа шалгалт хийх байдлаар олох бодолтын үйл ажиллагаа |
| 573. | Тэгшитгэн бодолт | **Р:**Уравнивание<br>**E:**Adjustment | Хэмжилтийн үр дүн ба эсвэл эдгээр үр дүнгийн функцийн хоорондын зохицолдоогүй байдлыг арилгах хамгийн бодит үнэлэлтийг олох, хэмжсэн хэмжигдэхүүн ба түүний функцийн нарийвчлалын үнэлгээ хийх бодолт боловсруулалтын үйлдэл |
| 574. | Тэгшитгэн бодолтын корреляцийн арга | **Р:**Корреляционный метод уравнивания<br>**E:** Correlation method of adjustment | Геодезийн сүлжээг тодорхой бус үржигчийн тусламжтайгаар хэд хэдэн үл мэдэгдэгч бүхий систем тэгшитгэлийг бие биед нь орлуулах замаар тэгшитгэн бодох хамгийн бага квадратын арга |
| 575. | Нөхцөлт тэгшитгэл зохиох | **Р:**Составление условных уравнений<br>**E:**Conditional equations formation | Тэгшитгэлийн зарим үл мэдэгдэгчийг тохиолдлын алдааны агуулгатай хэмжилтийн өгөгдөхүүнээр орлуулсан тэгшитгэл |
| 576. | Өндрийн сүлжээг тэгшитгэн бодох | **Р:**Уравнивание высотных сетей<br>**E:**Adjustment of leveling network | Хамгийн бага квадратын, корреляцийн, дараалуулан ойртуулах, олон өнцөгтийн, параметрийн аргаар өндрийн сүлжээг тэгшитгэн бодох үйлдэл |
| 577. | Байрлалын сүлжээг тэгшитгэн бодох | **Р:**Уравнивание плановой сети<br>**E:**Adjustment of positioning network | Геодезийн байрлалын сүлжээний цэгүүдийн солбицлын эцсийн утгыг тодорхойлох магадлалын онолд тулгуурласан хамгийн бага квадратын аргуудаар тэгшитгэн бодох үйлдэл |
| 578. | Тэгшитгэн бодсон сүлжээ | **Р:**Уравненная сеть<br>**E:**Adjusted network | Геодезийн сүлжээний тэгшитгэн бодолтоос гарсан засварыг хэмжилтийн үр дүнд жигд тооцож эцсийн өгөгдөхүүн гаргасан үйлдэл |
| 579. | Параметрийн аргаар тэгшитгэн бодох арга | **Р:**Параметрический способ уравнивания<br>**E:**Parametrical adjustment method | Хэмжсэн болон тодорхойлох хэмжигдэхүүний хоорондын холбоо тогтоох зарчимд суурилсан геодезийн байрлалын ба өндрийн сүлжээг тэгшитгэн бодох арга |
| 580. | Зангилаа цэгүүдийг | **Р:**Уравнивание сети с узловыми точками | Өндрийн сүлжээний нэг ба олон зангилаа цэгүүдтэй |

| | | | |
|---|---|---|---|
| | тэгшитгэн бодох арга | **E:**Bundle adjustment method | сэлгэцүүдийн өндрийн бодит утгыг дунджилж ойртуулах зарчмаар тэгшитгэн бодох арга |
| 581. | Нөхцөлт аргаар тэгшитгэн бодох арга | **P:**Уравнивание методом условных уравнений,<br>**E:**Condition adjustment method | Геодезийн сүлжээ тэгшитгэн бодох хамгийн бага квадратын аргын нэг |
| 582. | Тэгшитгэн бодолтын дараалуулан ойртуулах арга | **P:**Уравнивание методом последовательных приближений<br>**E:**Phased adjustment | Хэмжигдэхүүнийг бодит утгаар илэрхийлэх боломжгүй тохиолдолд тэгшитгэл эсвэл тэгшитгэлийн системийг бодох арга |
| 583. | Тэгшитгэн бодолтын бүлэглэлийн арга | **P:**Метод группового уравнивание<br>**E:**Group adjustment | Тэгшитгэн бодох үйлдлийн хэмжээг багасгахын тулд тэгшитгэлийг хоёр бүлэгт хувааж, эхний бүлгээр анхдагч засварыг олж, хоёрдугаар тэгшитгэлийг хувиргаж эцсийн засварыг олж тэгшитгэн бодолтыг нэгтгэх арга |
| 584. | Триангуляцийн тэгшитгэн бодолт | **P:**Уравнивание триангуляционных сетей<br>**E:**Triagulation adjustment | Хамгийн бага квадратын, коррелатын, параметрийн аргаар триангуляцийн сүлжээг тэгшитгэн бодох арга |
| 585. | Хэмжигдэхүүн | **P:**Величина<br>**E:**Value | Математикийн үндсэн ойлголтын нэг |
| 586. | Геодезийн хэмжигдэхүүн | **P:**Геодезическая величина<br>**E:**Geodetic value | Геодезид хэмжигдэж байгаа физик хэмжигдэхүүнүүд |
| 587. | Нарийвчлал | **P:**Точность<br>**E:**Accuracy | Тооцоологдсон, эсвэл хэмжигдсэн утгыг бодит утгатай нийцүүлсэн хэмжээ |
| 588. | Хэмжилтийн нарийвчлал | **P:**Точность измерения<br>**E:**Measurement accuracy | Хэмжиж буй хэмжигдэхүүний жинхэнэ утгад геодезийн хэмжилтийн үр дүн ойртох зэрэглэл |
| 589. | Геодезийн хэмжилтийн нарийвчлал | **P:**Точность геодезических измерений<br>**E:**Geodetic measurement accuracy | Хэмжиж буй хэмжигдэхүүний утга аль болох жинхэнэ утгад ойртох шатлалыг хэмжиж буй нэгжээр илэрхийлэх хэмжээ |
| 590. | Үнэмлэхүй нарийвчлал | **P:**Абсолютная точность<br>**E:**Absolute accuracy | Геодезийн хэмжилтийн боловсруулалтын ажлын нарийвчлал бодолтын алдааг үнэлэх тооцоо |
| 591. | Хэмжилтийн итгэл үнэмшил | **P:**Достоверность измерений | Хэмжилтийн үр дүнгийн итгэлийн зэрэглэлээр тодорхойлогдох, үр дүн нь |

| | | | |
|---|---|---|---|
| | | Надежность измерений<br>**E:**Validity and reliability of the measurement result | хэмжиж байгаа хэмжигдэхүүний жинхэнэ утга заасан хязгаарт байх магадлалаар тодорхойлогдох хэмжээ |
| 592. | Хэмжилтийн үр дүнгийн нийлэлт | **P:**Сводка результатов измерений<br>**E:**Result summary of measurements | Нэг ижил нөхцөлд, нэг ижил багаж хэрэгслээр, нэг аргаар хэд хэдэн удаа гүйцэтгэсэн нэг хэмжигдэхүүний хэмжилтийн үр дүнгүүд өөр хоорондоо ойр утга байх хэмжээ |
| 593. | Зөрүү | **P:**Невязка<br>**E:**Residual | Хэмжсэн хэмжигдэхүүний бодолтын функцийн утга түүний онолын утгаас гажих тохиолдол |
| 594. | Зөвшөөрөгдөх хэмжээ | **P:**Допуск<br>**E:**Tolerane | Хэмжилтийн алдаа, хэмжилтийн үр дүнгүүдийн хоорондын зөрүүнүүдийн зөвшөөрөгдөхөөр тогтоогдсон хамгийн их хязгаар хэмжээ |
| 595. | Зөвшөөрөгдөх зөрүү | **P:**Допустимая невязка<br>**E:**Residual tolerance | Геодези, байр зүйн ажилд зориулан гаргасан техникийн дүрэм, зааврааар тогтоогдсон зөрүүгийн хязгаар хэмжигдэхүүн |
| 596. | Өндөр тодорхойлох нарийвчлалын үнэлгээ | **P:**Оценка точности определения высот<br>**E:**Altitude accuracy evaluation | Нивелирийн нэг зогсолт болон сэлгэцийн цэгүүдийн өндөр, өндөржилтийн зөрүүг хамгийн бага квадратын аргын томьёогоор бодох үнэлгээ |
| 597. | Хэмжилтийн нарийвчлалын ойролцоо үнэлгээ | **P:**Приближенная оценка точности<br>**E:**Approximated accuracy evaluation | Геодезийн байрлалын ба өндрийн сүлжээг тэгшитгэн бодохын өмнөх хамгийн бага квадратын аргын томьёогоор бодох нарийвчлалын үнэлгээ |
| 598. | Хэмжилтийн нарийвчлалын үнэлгээ | **P:**Оценка точности результатов измерении<br>**E:** Evaluation of the accuracy of measurement results | Геодезийн байрлал, өндрийн сүлжээний хээрийн хэмжилтийг хамгийн бага квадратын аргын томьёогоор бодох нарийвчлалын үнэлгээ |
| 599. | Засвар | **P:**Поправка<br>**E:**Correction | Өгөгдсөн нөхцөлд хамгийн бодит үр дүн гаргахын тулд хэмжилтийн засагдаагүй үр дүнд өгөх алгебрын нийлбэрийн хамгийн бага утга |
| 600. | Тэгшитгэн бодолтоос гарсан засвар | **P:**Поправка из уравнивания<br>**E:**Adjustment correction | Хэмжилтийн хэмжсэн үр дүнгийн утга ба тэгшитгэн бодолтын утга хоорондын зөрүү |
| 601. | Зай хэмжүүрийн байнгын засвар | **P:**Поправка постоянная дальномера | Зай хэмжилтийн утгыг багажийн босоо тэнхлэгтэй давхцуулж |

| | | | |
|---|---|---|---|
| | | **E:**Distance meter constant correction | хөрвүүлэхэд өгөгдөх багажийн засвар |
| 602. | Геодезийн хэмжигдэхүүний жингийн нэгж | **P:**Единица весов геодезических величин<br>**E:**Weighted unit of geodetic values | Ижил бус нарийвчлалын хэмжилт хийсний дараа тэгшитгэн бодолтоор жигнэгдсэн дундаж утгыг тодорхойлохын тулд авсан тогтмол тоо |
| 603. | Урвуу жин | **P:**Вес обратный<br>**E:**Reverse weight | Урвуу хэмжилтийн нарийвчлалд өгөх жингийн харьцангуй үзүүлэлт |
| 604. | Жингийн дундаж (ерөнхий тоон дундаж) | **P:**Весовое среднее (общая арифметическая средина)<br>**E:**Weighted mean | Ижил бус нарийвчлалтай геодезийн олон давталтай харилцан хамааралгүй хэмжилтийн үнэлгээний жингийн дундаж утга |
| 605. | Хэмжилтийн жин | **P:**Вес измерения<br>**E:**Measurement weight | Ижил бус нарийвчлалтай хэмжилтийн үр дүнгийн математик бодолтод ашиглах үр дүнгийн найдвартай байдлын зэргийг илтгэсэн туслах тоо |
| 606. | Өндрийн жингийн дундаж утга | **P:**Среднее весовое значение отметки<br>**E:**Weighted elevation mean | Ижил бус нарийвчлалтай геодезийн олон давталтай харилцан хамааралгүй хэмжилтийн томьёогоор бодсон өндрийн тоотын жингийн дундаж утга |
| 607. | Хэмжилтийн алдааны онол | **P:**Теория ошибок измерений<br>**E:**Theory of measurement errors | Хэмжилтийн алдаанууд үүсэх шалтгаан тэдгээрийн хэмжээ, шинж чанарууд, багасгах асуудлыг шийдвэрлэх арга замыг судалдаг магадлалын онолын салбар |
| 608. | Хэмжилтийн алдаа | **P:**Ошибка измерения<br>**E:**Errors of measurements | Хэмжилтийн үр дүн ба түүний жинхэнэ утга хоорондын зөрүү |
| 609. | Бүдүүлэг буюу санамсаргүй алдаа | **P:**Погрешности грубые<br>**E:**Accidental errors | Хэмжилт, бодолтын явцад санамсаргүй байдлаар гарч дахин хэмжих эсвэл бодоход илэрдэг алдаа |
| 610. | Багажийн алдаа | **P:**Погрешности инструментальные<br>**E:**Instrumental errors | Геодезийн хэмжилтийн багажийн өөрийн тогтоосон нарийвчлалаас гажсан хэмжилтийн алдаа |
| 611. | Битүүрүүлэлтийн алдаа | **P:**Ошибка замыкания, угловая невязка<br>**E:**Angle-closure error, error of closure | Тойргийн аргаар өнцөг хэмжих үед эхний чиглэл рүү харж хэмжсэн эхний ба төгсгөлийн тооллуудын үл давхцал |

| | | | |
|---|---|---|---|
| 612. | Нэгж жингийн алдаа | **P:**Ошибка единицы веса<br>**E:**Error of unit weight | Жин нь нэгтэй тэнцүү байх хэмжилтийн үр дүнгийн дундаж квадрат алдаа |
| 613. | Тоог тоймлох алдаа | **P:**Ошибка округления<br>**E:**Round-off error | Хэмжилтийн болон бодолтын явцад тооны зэрэг дэвшүүлэхээс үүсэх санамсаргүй алдаа |
| 614. | Харьцангуй алдаа | **P:**Относительная ошибка<br>**E:**Relative error | Ямар нэгэн хэмжигдэхүүний үнэмлэхүй алдааг энэ хэмжигдэхүүнд харьцуулсан харьцаа |
| 615. | Алдааны хязгаар | **P:**Предельная ошибка<br>**E:**Error limit | Тогтоосон ижил нарийвчлалын хэмжилтийн үед санамсаргүй алдааны утга хамгийн их байх тохиолдол |
| 616. | Дундын алдаа | **P:**Срединная ошибка<br>**E:**Median error | Үнэмлэхүй алдааны утгыг эгнээгээр өгсүүлэн жагсааж гаргасан магадлалын алдааны утга |
| 617. | Дундаж алдаа | **P:**Средняя ошибка<br>**E:**Average error | Ижил нарийвчлалтай хэмжилтийн тохиолдлын алдааны үнэмлэхүй арифметик дундаж утга |
| 618. | Дундаж квадрат алдаа | **P:**Средняя квадратическая ошибка<br>**E:**Mean square error | Тодорхойлж буй хэмжигдэхүүний хэмжсэн ба бодсон утгуудын нарийвчлалын үндсэн хэмжүүр |
| 619. | Байнгын алдаа | **P:**Погрешности систематические<br>**E:**Systematic errors/constant error | Хэмжилтийн багаж, хэмжилтийн арга, хэмжилтийн гадны нөлөө, хэмжилт хийж буй хүний хувийн алдаа зэргээс үүсэх хэмжилтийн алдаа |
| 620. | Тохиолдлын алдаа | **P:**Погрешности случайные<br>**E:**Random error | Бүх төрлийн хэмжилтийн үед нэг нь нөгөөгөөс хамааралгүй шалтгаанаар үүсэх алдаа |
| 621. | Хэмжилтийн аргын байнгын алдаа | **P:**Систематическая погрешность метода измерений<br>**E:**Systematic error of measurement method | Тухайн хэмжилтийн аргыг хэрэглэж лабораторийн нөхцөлд хийсэн хэмжилтийн үр дүнгийн математик хүлээгдэл ба хэмжигдэх жинхэнэ үр дүнгийн үзүүлэлт хоорондын зөрүү |
| 622. | Үнэмлэхүй алдаа | **P:**Абсолютная ошибка<br>**E:**Absolute error | Ямар нэгэн хэмжигдэхүүний хэмжсэн ба жинхэнэ утга хоорондын алгебрын зөрүү |
| 623. | Магадлалын алдаа | **P:**Вероятная ошибка<br>**E:**Probable error | Аливаа алдаа үнэмлэхүй хэмжээгээрээ түүнээс харьцангуй бага байх ёстой тохиолдлын алдааны утга |
| 624. | Байх боломжийн алдаа | **P:**Вероятнейшая ошибка<br>**E:**Actual error | Хэмжилтийн эцсийн үр дүнгийн байвал зохих боломжит утга, хэмжсэн үр дүн хоёрын зөрүү |

| | | | |
|---|---|---|---|
| 625. | Алдааны гурвалжин | **P:**Треугольник погрешностей<br>**E:**Triangle of errors | Шууд огтлолын аргаар цэгийн байрлалыг тодорхойлох үед үүсэх гурвалжин |

**БАЙР ЗҮЙ**
**ТОПОГРАФИЯ**
**TOPOGRAPHY**

| | | | |
|---|---|---|---|
| 626. | Байр зүй | **P:**Топография<br>**E:**Topography | Газрын гадаргыг геометр талаас нь нарийн судалж түүнийг байр зүйн газрын зураг, дэвсгэр зургийн хэлбэрээр дүрслэх аргыг боловсруулан хэрэгжүүлдэг геодезийн шинжлэх ухааны техникийн ба үйлдвэрлэлийн салбар |
| 627. | Байрзүйч | **P:**Топограф<br>**E:**Topographer | Геодези, байр зүйн салбарт байр зүйн зураглал хийх, шинэчлэх, газрын кадастрын геодезийн хангалт хийх г.м ажлуудыг хийхээр мэргэшсэн мэргэжилтэн |
| 628. | Байр зүйн зураг | **P:**Топографическая карта<br>**E:**Topographic map | Газрын гадарга, түүний дээрх болон доорх объектыг тусгагт оруулан, тодорхой масштабаар жижгэрүүлэн буулгаж, таних тэмдгээр дүрсэлж, үзүүлэлт, шинж чанарыг нь илэрхийлсэн газрын зураг |
| 629. | Топономик, топоном | **P:**Топонимика, топонимия<br>**E:**Toponymics, toponymy | Тусгайлсан газар нутгийн газар зүйн нэрийн бүрдэл |
| 630. | Дэвсгэр зураг | **P:**Топографический план<br>**E:**Plan**,** plot, planimetry | Газрын гадарга, барилга болон инженерийн байгууламжийн бодит байршлыг газрын гадаргын махиаг тооцолгүй батлагдсан түвшинд хэмжиж, эгц босоо тусгагаар дүрсэлсэн зураг |
| 631. | Тойм зураг | **P:**Абрис<br>**E:**Outline, Field sketch | Газрын гадаргын бүдүүвч зураг |
| 632. | Байр зүйн зураглал | **P:**Топографическая съемка<br>**E:**Topographic survey | Байр зүйн зураг эсвэл дэвсгэр зураг гаргах, мөн мэдээллийг бусад хэлбэрээр гаргаж авах зорилгоор хийх иж бүрэн ажил |
| 633. | Тахеометрийн зураглал | **P:**Тахеометрическая съемка<br>**E:**Tacheometric survey | Тахеометр багажаар хийх газрын зураглал |

| | | | |
|---|---|---|---|
| 634. | Мензулын зураглал | **Р:**Мензульная съемка **E:**Plan table survey | Газрын гадаргын тухай анхдагч мэдээллийг авах мензул ба кипрегелээр хийх газрын зураглал |
| 635. | Гүйцэтгэлийн зураглал | **Р:**Исполнительная съемка **E:**Engineering survey | Шинээр болон өөрчлөн барьж байгуулсан зам, инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн бодит байршлыг газрын гадаргуугийн өөрчлөлттэй нь харуулан зураглах |
| 636. | Газар доорх инженерийн шугам сүлжээний зураглал | **Р:**Сьёмка подземных инженерных коммуникации **E:**Utility survey | Газар доорх инженерийн холбоо мэдээллийн сүлжээ, эрчим хүч, ус, дулаан дамжуулах сүлжээний солбицол, гүнийг тодорхойлж, үзүүлэлтийн хамт байр зүйн зураг, дэвсгэр зураг дээр дүрслэх үйл ажиллагаа |
| 637. | Усны ёроолын зураглал | **Р:**Гидролокационная съемка **E:**Underwater survey | Усан доорх газрын гадаргын тухай анхдагч мэдээллийг авах ус зүйн хэмжилтийн багаж, онгоц, завь ашиглан хийх зураглал |
| 638. | Теодолитын зураглал | **Р:**Теодолитная съемка **E:**Theodolite survey | Теодолит, хэмжүүрийн тууз, уртын хэмжүүр зэргийн тусламжтайгаар хийх байр зүйн зураглалын арга |
| 639. | Маршейдерийн зураглал | **Р:**Маркшейдерская съёмка **E:**Mine surveys | Газар доорх барилга байгууламж, ашигт малтмалын орд газрын бодит зураглалын арга |
| 640. | Зургийн хуваалга | **Р:**Разграфка топографических карт и планов **E** Sheet/map indexing | Олон тооны хуудастай байр зүйн зураг, дэвсгэр зургуудыг хуудсаар хуваах дугаарлах нэгдсэн тогтолцоо |
| 641. | Зургийн нэрэлбэр | **Р:**Номенклатура топографических карт, планов **E:**Nomenclature, index, sheet number | Хуваалгаар үүссэн төрөл бүрийн масштабын байр зүйн зураг, дэвсгэр зургуудыг системчлэн дугаарлах арга |
| 642. | Зураглалын үндэслэл | **Р:**Съемочное обоснование **E:**Geodetic survey control | Байр зүйн зураглалын хангалт болох геодезийн сүлжээ |
| 643. | Зураглалын цэг | **Р:**Съемочная точка **E:**Survey point | Тухайн газрын хэсгийг зураглах цэг |
| 644. | Пикет | **Р:**Съемочный пикет **E:**Surveying peg, piket | Тухайн газрын зураглалын үндэслэлийн цэгтэй харьцуулан байрлалыг нь тодорхойлох цэг |
| 645. | Зураглалын самбар | **Р:**Съемочный планшет Планшет **E:**Survey sheet | Байр зүйн зураглал хийх зориулалттай хатуу эх дээр цаас эсвэл гэрэл зургийн цаас наасан самбар |

| | | | |
|---|---|---|---|
| 646. | Гадарга | **Р:**Поверхность<br>**E:**Surface, relief | Хоёр хэмжээст солбицлын функцийн утгаар өөрийн хязгаарын доор үүссэн орон зайн хоёр хэмжээст объект |
| 647. | Үеийн өндөр | **Р:**Высота сечения рельефа<br>**E:**Contour interval | Газрын гадаргыг зэргэлдээ түвшний гадаргаар огтлоход үүсэх хаялбарууд хоорондын өндрийн зөрүү |
| 648. | Аэродромын өндөр | **Р:**Высота аэродрома<br>**E:**Aerodrome elevation | Хөөрч, буух зурвасын тэнхлэгийн дагуух далайн түвшнээс дээш хэмжигдэх хамгийн өндөр цэг |
| 649. | Хаялбар | **Р:**Горизонталь<br>**E:**Contour( line) | Газрын зураг дээр ижил өндөртэй цэгүүдийг холбосон муруй шугам |
| 650. | Нэмэлт хаялбар | **Р:**Дополнительный горизонталь<br>**E:**Additional contour | Үндсэн хаялбар (index contour)-ын дундуур татах хаялбар |
| 651. | Туслах хаялбар | **Р:**Вспомогательный горизонталь<br>**E:**Auxiliary contour | Гадаргуун хэлбэрийг нарийвчлан үзүүлэх зорилгоор өндрийг тодорхой үеийн өндрөөр татах хаялбар |
| 652. | Хаялбар зурах | **Р:**Рисовка горизонталей<br>**E:**Countour plotting, line plotting | Газрын зурагт масштабын дагуу өгөгдсөн гадаргын үеийн өндрийг гараар эсвэл цахим программаар зурах арга |
| 653. | Хаялбар дундажлах арга | **Р:**Интерполирование горизонталей<br>**E:**Interpolating of contours | Байр зүйн зургийн сонгон авсан үеийн өндрийн хэмжээгээр өгөгдлүүд нь өсөж харагдах хаялбар татахад туслах цэгүүдийн байрлалыг тодорхойлох арга |
| 654. | Ижил гүний хаялбар | **Р:**Изобаты<br>**E:**Isobaths | Газрын зураг дээр далайн ёроолын ижил гүнтэй цэгүүдийг холбосон хаялбар |
| 655. | Ижил даралтын хаялбар | **Р:**Изобары<br>**E:**Isobar | Газрын гадарга дээр байгаа ижил агаарын даралттай цэгүүдийг газрын зураг дээр холбосон хаялбар |
| 656. | Ижил температурын хаялбар | **Р:**Изотермы<br>**E:**Isotherms | Газрын зураг дээр агаар, ус, хөрсний хувьд ижил хэмтэй цэгүүдийг холбосон хаялбар |
| 657. | Ижил соронзон хазайлтын хаялбар | **Р:**Изогоны<br>**E:**Isogonic lines | Газрын зураг дээр соронзон хазайлт нь ижил цэгүүдийг холбосон хаялбар |
| 658. | Ижил хэвийлттэй шулуун | **Р:**Изоклины<br>**E:**Isoclinic curve | Газрын зураг дээр соронзон зүүний хазайлт нь ижил цэгүүдийг холбосон шулуун |
| 659. | Ижил гажилтын шулуун | **Р:**Изоколы<br>**E:**Line of equal distortion | Зураг зүйн тусгагийн ижил гажилтыг холбосон шулуун |

| | | | |
|---|---|---|---|
| 660. | Налууг илтгэх зураас | **Р:**Бергштрих<br>**E:**Hachure | Хаялбарт перпендикуляраар зурагддаг газрын налуугийн чиглэлийг заагч богино зураас |
| 661. | Тавил | **Р:**Заложение<br>**E:**Pledging, Laying | Зураг дээрх өгөгдсөн чиглэлийн дагуух дараалсан хоёр хаялбарын хоорондох зай |
| 662. | Налуугийн тавил | **Р:**Заложение ската<br>**E:**Laying of a slope | Газрын зурагт зурагдсан дараалсан хоёр үндсэн хаялбарууд хоорондын хамгийн ойрын чиглэлээр авсан зай |
| 663. | Налуугийн эгц | **Р:**Крутизна ската<br>**E:**Gradient angle | Тухайн цэгийн хэвтээ хавтгай, налуу чиглэлийн хооронд үүссэн өнцөг |
| 664. | Хэвтээ зай | **Р:**Горизонтальное проложение<br>**E:**Horizontal distance | Налуу шугамыг тусгагаар хэвтээ хавтгайд буулгасан уртын хэмжээ |
| 665. | Тавилын хуваарь | **Р:**График заложений<br>**E:**scale unit of laying | Налуугийн эгцийг тодорхойлох тахирмаг |
| 666. | Хэвгий | **Р:**Уклон<br>**E:**Gradient | Шугамын налууг тодорхойлох өнцгийн хэмжээ |
| 667. | Газрын хэвгий | **Р:**Уклон местности Уклон<br>**E:**Slope | Газрын налуу шугамын дагуух тухайн цэг дэх хэвтээ хавтгайд үүсгэх тангенс өнцөг |
| 668. | Гадаргын зүсэлт | **Р:**Профиль местности Профиль<br>**E:**Profile | Газар дээрх хоёр цэгийг босоо хавтгайгаар дайруулан зүсэхэд энэ хавтгай дээр гарах зүсэлтийн тусгаг |

# ХЭРЭГЛЭЭНИЙ ГЕОДЕЗИ
# ПРИКЛАДНАЯ ГЕОДЕЗИЯ
# APPLIED GEODESY

| | | | |
|---|---|---|---|
| 669. | Геодезийн чиг шугам тавих | **P:**Трассирование **E:**Laying out Setting-out | Автозам, төмөр зам, инженерийн шугаман байгууламжийн чиг гаргахад хийгдэх геодезийн иж бүрэн ажил |
| 670. | Трасс (чиглэл шулуун)-ын тэнхлэг | **P:**Ось трассы проектируемого сооружения.Ось трассы **E:**Trace axis | Газрын гадаргад тэмдэглэсэн эсвэл төслийн баримт бичигт буулгасан төлөвлөж буй шугаман байгууламжийн тэнхлэг |
| 671. | Трассын тойргон муруй | **P:**Круговая кривая трассы **E:**Circular curve | Төлөвлөж байгаа байгууламжийн тойрог хэлбэртэй трассын тэнхлэгийн дугуй хэсэг |
| 672. | Трассын шилжих муруй | **P:**Переходная кривая трассы Переходная кривая **E:**Spiral transition curve | Төлөвлөж буй байгууламжийн трассын хувьсах радиустай тэнхлэгийн муруй |
| 673. | Трассын шууд оруулга | **P:**Прямая вставка трассы Прямая вставка **E:**Direct insert route Direct insert | Зэргэлдээ буюу шилжилтийн муруй хооронд байрласан төлөвлөж буй байгууламжийн трассын тэнхлэгийн шулуун хэсэг |
| 674. | Трассын босоо муруй | **P:**Вертикальная кривая трасс **E:**Vertical curve | Төлөвлөж буй байгууламжийн трассын тэнхлэгийн босоо хавтгайд байгаа хэсэг |
| 675. | Трассын дагуу зүсэлт | **P:**Продольный профиль трассы Продольный профиль **E:**Longitudinal section | Төлөвлөж буй байгууламжийн тэнхлэгийн дагуух газрын гадаргын зүсэлт |
| 676. | Трассын хөндлөн зүсэлт | **P:**Поперечный профиль трассы Поперечныи профиль **E:**Cross-section | Төлөвлөж буй байгууламжийн трассын тэнхлэгт перпендикуляр шугамын дагуу хийсэн газрын гадаргын зүсэлт |
| 677. | Муруйг нарийвчлан байгуулах | **P:**Детальная разбивка кривой **E:**Detailed breakdown of curve | Муруйн цэгүүдийг өгөгдсөн зайд хувааж, газарт шилжүүлэн буулгаж, тэмдэглэн бэхлэх арга |
| 678. | Муруйн гол цэгүүд | **P:**Главные точки кривой **E:**Principal curve points d'un courbe de raccordement | Трассын муруй хэсгийн эхлэл, дунд, төгсгөлийн цэгүүд |

| | | | |
|---|---|---|---|
| 679. | Муруйн тангенс | **Р:**Тангенс кривой<br>**E:**Tangent | Трассын эргэлтийн өнцгийн оройгоос муруйн эхлэл, төгсгөл хүртэлх зай буюу хэрчим |
| 680. | Муруйн биссектрис | **Р:**Биссектриса кривой **E:**Curve bisector | Трассын эргэлтийн өнцгийн оройг муруй шугамын дунд холбосон шулуун шугам |
| 681. | Гүйцээлт-домер | **Р:**Домер<br>**E:**Domer | Замын эргэлтийн элементүүд болох хоёр тангенсийн нийлбэр ба муруй хоёрын зөрүү |
| 682. | Автозамын трасс | **Р:**Трассирование автомобильных дорог<br>Трассирование дорог<br>**E:**Toad tracing | Трассын чиглэлд байгаа байрлал, өндрийн улсын сүлжээтэй, трассын эхлэл, төгсгөлийг холбох, трассын тэнхлэгийн дагуух цэгүүдийн солбицол, өндрийг 100 м тутамд тодорхойлох, дагуугийн ба хөндлөнгийн огтлол байгуулах, зурвас зураглах хийх, трассын хөндлөн огтлолын зураг зохиох зэрэг технологи үйлдэл |
| 683. | Төмөр замын трассын төлөвлөлт | **Р:**Трассирование железных дорог, съёмка железнодорожных путей<br>**E:**Railway tracing | Байр зүйн зураг болон дэвсгэр зураг дээр замын трассыг төлөвлөж трассын дагуу нивелирдлэг хийх, үүний дагуу огтлолын зураг зохиох, огтлолын зураг дээр газрын түвшин, ул шороонь төслийн түвшин, хэвгий болон зай хэмжээ, километрийн дугаарыг зурж харуулах зэрэг асуудлыг төлөвлөх технологи үйлдэл |
| 684. | Трассыг гадаслах | **Р:**Пикетаж трассы<br>Пикетаж<br>**E:**Peg interval layout | Трассын тэнхлэгийн дагууд цэгүүдийг нь тодорхой хэрчмүүдээр гадсаар тэмдэглэн бэхлэх арга |
| 685. | Босоо төлөвлөлтийн төсөл/өндөржилтийн зураг/ | **Р:**Проект вертикальной планировки<br>**E:**Vertical planning project /elevation map/ | Хот суурин газар, барилга байгууламж барих зорилгоор газрын гадаргын өндрийг зохиомлоор өөрчлөх инженерчлэлийн арга хэмжээ |
| 686. | Угсралтын түвшинд өндөр дамжуулах | **Р:**Перенос отметок по вертикали<br>**E:**Vertical point transfer | Барилга байгууламжийн угсралтын дээд давхарт босоо чиглүүлгийн багажаар өндөр дамжуулах арга |
| 687. | Төслийн өндөр | **Р:**Проектная отметка<br>Красная отметка<br>**E:**Grade level | Эхлэл өндрийн түвшинтэй харьцуулсан зураг төсөлд өгөгдсөн өндөр |

| | | | |
|---|---|---|---|
| 688. | Хар тоот | **P:**Черная отметка **E:**Ground level | Барилга байгууламжийн төлөвлөлт хийх талбайн газрын гадаргын өндөр |
| 689. | Тэг ажлын цэг | **P:**Точка нулевых работ **E:**Point of zero works | Төслийн ба бодит өндөр нь ижил цэг |
| 690. | Байрлуулалтын зураг | **P:**Разбивочный чертёж **E:**Layout sketch | Байгууламжийн зарим элементийг газарт байрлуулах төслийн өгөгдлийг үзүүлсэн зураг |
| 691. | Байрлуулалтын сүлжээ | **P:**Разбивочная сеть **E:**Layout grid | Төслийг байрлалыг газарт байрлуулахад зориулсан геодезийн цэгийн олонлог |
| 692. | Байрлуулалтын ажил | **P:**Разбивка, разбивочные работы **E:**Stakeout, Stakeout survey | Барилга байгууламжийн бүтээц, тоног төхөөрөмжийн эд ангийг батлагдсан зураг төслийн дагуу байрлуулах геодезийн хэмжилт |
| 693. | Гүүрийн байрлуулалт | **P:**Разбивка моста **E:**Bridge setting-out | Гүүрийн байгууламжийн тулгуур, дам нуруун байрлал, өндрийг зураг төслийн дагуу байрлуулах геодезийн хэмжилт |
| 694. | Гүүрэн өргүүрийн зураглал | **P:**Измерение подкрановых путей **E:**Crane track measurement | Гүүрэн өргүүрийн зам төмөр хоорондын зай, тулгуур бүрийн өндрийн түвшин зэргийг батлагдсан зураг төслийн дагуу байрлуулах геодезийн хэмжилт |
| 695. | Барилгын геодезийн торон сүлжээ | **P:**Строительная геодезическая сетка Строительная сетка **E:**Construction geodetic Grid, Construction grid | Байгууламжийн тэнхлэгт зэрэгцээгээр байгуулан чиглүүлсэн дөрвөн өнцөгт буюу тэгш өнцөгтөөс тогтсон систем бүхий геодезийн сүлжээ |
| 696. | Барилгын геодезийн ажил | **P:**Строительные геодезические работы **E:**Construction surveys | Барилга байгууламжийн тэнхлэг, өндөр, гүйцэтгэлийн зураглал үйлдэхэд зориулсан геодезийн өндөр нарийвчлалтай тулгуур сүлжээ байгуулах, хэмжилт хийх үйлдвэрлэлийн ажил |
| 697. | Барилгын торыг газарт буулгах | **P:**Редуцирование строительной сетки **E:**Grid reduction | Барилга байгууламжийн зураг төсөлд заасан байрлалд барилгын геодезийн торыг газарт байгуулах арга |
| 698. | Байрлуулалтын тэнхлэг | **P:**Разбивочная ось **E:**Layout axis, line strake | Байгууламж, түүний зарим хэсгийг газарт шилжүүлэх өгөгдлийг үзүүлсэн байгууламжийн тэнхлэг |

| | | | |
|---|---|---|---|
| 699. | Тэг тэнхлэг | **Р:**Нулевая ось<br>**E:**Zero axis | Инженерийн шугам сүлжээ, инженерийн дэд бүтэц, барилга байгууламжийн үндсэн хэмжээ, түвшнийг улсын геодезийн сүлжээнд холбосон газар дээрх тэмдэглэгээ |
| 700. | Улаан шугам | **Р:**Красные линии<br>**E:**Red line | Нийтийн ашиглалтын талбайн хил, цахилгаан дамжуулах шугам, яндант дамжуулгын сүлжээ, автозам, төмөр зам шугаман байгууламжийг байрлуулсан, эсвэл төлөвлөсөн газрын хил хязгаарыг тогтоосон шугам |
| 701. | Төслийн шулуун | **Р:**Линия проектная<br>**E:**Grade line | Байгууламжийн хэвтээ, босоо байрлалыг тодорхойлогч шулуун |
| 702. | Угсралтын шугам | **Р:**Монтажная линия<br>**E:**Assembly line | Хийц, суурь машин, механизм ба технологийн бусад тоног төхөөрөмжийн төслийн байрлалыг шилжүүлэхэд зориулан газарт бэхэлсэн шугам |
| 703. | Угсралтын геодезийн тор | **Р:**Монтажная геодезическая сетка<br>Монтажная сетка<br>**E:**Assembly geodetic grid<br>Assembly grid | Тоног төхөөрөмж, агрегатын тэнхлэгийг газарт байрлуулах болон шалгалтын хэмжилт хийхэд байгуулсан зөв дөрвөлжин буюу тэгш өнцөгт хэлбэртэй геодезийн сүлжээ |
| 704. | Нэг чигийн шулуун тавилт | **Р:**Створ<br>**E:**Alignment | Өгөгдсөн хоёр цэгийг дайран гарах босоо хавтгай |
| 705. | Чиг байрлуулалтыг хянах цэг | **Р:**Контрольный пункт створа<br>Контрольный пункт<br>**E:**Check alignment peg | Ажиглалтын цэгийн шилжилтийн шугамыг перпендикуляр чиглэлд тодорхойлоход ашиглах цэг |
| 706. | Нэг чигийн тавилтаар хэмжих | **Р:**Створные наблюдения<br>**E:**Alignment observation | Шулуун байрлуулалтын шалгалтын цэгээс хазайх хазайлтаар хэвтээ шилжилтийг тодорхойлох арга |
| 707. | Геодинамикийн полигон | **Р:**Геодинамический полигон<br>**E:**Geodynamic polygon | Газрын царцдас давхаргын босоо хөдөлгөөнийг судлах, газар хөдлөлтийн урьдчилсан таамаглалыг хайх, хөрсний гүний хагарал, гадаргын ан цавын идэвхжил, газар хөдлөлтийн хамгийн идэвхтэй бүс нутаг, хэсгийг илрүүлэх геофизикийн шинжлэх ухааны |

| | | | |
|---|---|---|---|
| | | | иж бүрэн судалгааны геодези, гравиметрийн хэмжилтийн сүлжээ |
| 708. | Геодезийн геодинамикийн хэмжилт | **Р:**Геодезические геодинамические измерения<br>**E:**Geodetic geodynamic measurements | Геодинамикийн полигонд байгуулсан тулгуур цэг тэмдэгтийн өөрчлөлтийг тодорхойлох геодезийн ба грхавиметрийн ажлын үйлдвэрлэлийн явц |
| 709. | Техногенийн талбай | **Р:**Техногенный полигон<br>**E:**Technogenic polygon | Хүний ахуйн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүссэн газрын гадаргын хэв гажилтыг судлах хэмжилтийн геодезийн сүлжээ |
| 710. | Хэв гажилт | **Р:**Деформация<br>**E:**Deformation | Геодезийн хувьд хэв гажилт нь барилга байгууламжийн бүтээц, суурийн хөрс анхдагч байрлалаасаа орон зайн шилжилтээр тодорхойлогдох хэмжигдэхүүний илэрхийлэл |
| 711. | Хэв гажилт тодорхойлох марк | **Р:**Деформационный знак (деформационная марка)<br>**E:**Deformation sign (deformation mark) | Барилга байгууламжийн суурийн суулт өргөгдөлт, цөмрөлт, шилжилт болон хазайлт зэрэг хэв гажилтаас өөрийн байрлалаа өөрчилж байдаг үзэгдлийг ажиглах барилга байгууламжийн хийц бүтээцэд бэхэлсэн геодезийн тэмдэгт |
| 712. | Хэв гажилтийн хэмжилт, судалгаа | **Р:**Наблюдение за деформациями<br>**E:**Monitoring of deformations | Барилга байгууламж, түүний тодорхой хэсгийн хэв гажилт (шилжилт)-ыг тодорхойлох зориулалтаар байрлал, өндрийн сүлжээний цэгүүд байгуулах, давтагдах хэмжилт хийх, хэмжилтийн үр дүнг боловсруулж хэв гажилтын явцыг урьдчилан мэдээлэх үйлдвэрлэлийн технологийн үйл явц |
| 713. | Барилга байгууламжийн хэв гажилт | **Р:**Деформация инженерных сооружений<br>**E:**Deformation of engineering constructions | Газрын гадаргын бүтэц, геотектоник хүч, гидрогеологийн нөхцөл, геологийн олон хэвшлүүдээс шалтгаалан, хөрсний механик үйлчлэлийн нөлөөлөл нь барилга байгууламжийн тогтворжилтод сөргөөр нөлөөлөх физик үзэгдэл |

| | | | |
|---|---|---|---|
| 714. | Үнэмлэхүй суулт | **Р:**Абсолютный осадок<br>**E:**Absolute sediment | Геодезийн өндрийн тулгуур сүлжээний цэгтэй харьцуулан тодорхойлсон барилга байгууламжийн суултын хэмжигдэхүүн |
| 715. | Харьцангуй суулт | **Р:**Относительный осадок<br>**E:**Relative sediment | Барилга байгууламжийн нэг цэгтэй харьцуулан тодорхойлсон суултын хэмжигдэхүүн |
| 716. | Суурийн гажилт | **Р:**Деформация фундамента<br>**E:**Offset base | Хоёр цэгийн босоо шилжилтийн ялгавраар тодорхойлох өргөгдөл, цөмрөлтийн дүнд үүссэн суурийн хэв гажилт |
| 717. | Суурийн хэвтээ шилжилт | **Р:**Горизонтальный сдвиг<br>**E:**Horizontal offset | Буурийн даацат чанар алдагдсанаас буюу шилжилтийн хүчний үйлчлэлээр барилга, байгууламж нийтдээ эсвэл түүний суурь шилжих үзэгдэл |
| 718. | Нумралт | **Р:**Прогиб<br>**E:**Deflection | Хотойлтын нумын уртыг, суурийн хотойж буй хэсгийн уртад харьцуулсан харьцаа |
| 719. | Нумрах хэмжээ | **Р:**Стрела прогиба<br>**E:**Deflection value | Барилга байгууламжийн дам нуруу, татанга зэрэг бүтээцийн тэнхлэгтэй перпендикуляр үйлчлэх гадны нөлөөллөөр үүсэх нумралтын хамгийн их хэмжээ |
| 720. | Тэнхлэг ба өндрийн тоотыг угсралтын түвшинд буулгах | **Р:**Перенос осей, отметок (на монтажные горизонты)<br>**E:**Transfer of axes, elevations (to mounting horizons) | Босоо төлөвлөлтийн технологийн үйлдэл хийх эсвэл өндөржилт хэмжилтийн технологийн үйлдэл |
| 721. | Цахилгаан дамжуулах шугамын зураглал | **Р:**Сьёмка линии электро передач-ЛЭП<br>**E:**Transmission line survey | Цахилгаан дамжуулах шугамын чиг гаргаж, тэнхлэгийн дагуу пикет байгуулах, газрын гадаргын онцлог цэгүүд дээр байрлал, өндрийг тодорхойлох хэмжилт хийх, зурвас зураглал үйлдэх арга |
| 722. | Төслийн байрлалыг газарт шилжүүлэн буулгах | **Р:**Перенос проекта в натуру<br>**E:**Setout | Барилга байгууламжийн төслийн тэнхлэг, цэгүүдийн байрлалыг өгөгдсөн нарийвчлал, төслийн дагуу газарт тэмдэглэх геодезийн хэмжилт |

| | | | |
|---|---|---|---|
| 723. | Инженер геодезийн хайгуул судалгаа | **Р:**Инженерно-геодезическое изыскание<br>**E:**Engineering geodetic surveying | Инженерийн барилга байгууламжийг төлөвлөх, төслийг газарт шилжүүлэхэд шаардлагатай геодези, байр зүйн мэдээллийг цуглуулах, боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа |
| 724. | Байр зүй-геодезийн хайгуул | **Р:**Топографо-геодезическое изыскание<br>**E:**Topo-Surveying exploration | Газрын гадаргын хэлбэр дүрс, газар доорх барилга байгууламжийн тоон болон дүрсийн цогц мэдээлэл, материалыг гарган авах зориулалт бүхий инженерийн хайгуулын төрөл |
| 725. | Ус зүйн хайгуул | **Р:**Гидрографические изыскания<br>**E:**Hydrographic surveying | Эх газрын ус судлалын шинжлэх ухааны нэг салбар бөгөөд ус, усны сан, усны объектын үзүүлэлт, хэмжилтийн арга, хэрэгслийн тухай ус зүйн инженерийн хэмжилтийг гүйцэтгэх арга |
| 726. | Ус зүйн зурагжуулалт | **Р:**Гидрографическое картографирование<br>**E:**Hydrographic surveying | Газрын зураг дээр усан сан, гол горхи, булаг шанд, худаг, рашаан ус, усны барилга байгууламж, объектыг дүрслэн үзүүлэх цогц ажиллагаа |

## ГЕОДЕЗИЙН ХЭМЖИЛТИЙН ҮНДСЭН БАГАЖУУД
## ОСНОВНЫЕ ПРИБОРЫ ГЕОДЕЗИЧЕСКИХ ИЗМЕРЕНИИ
## BASIC INSTRUMENTS OF GEODESIC MEASUREMENT

| | | | |
|---|---|---|---|
| 727. | Геодезийн хэмжилтийн багаж | **Р:**Геодезический прибор<br>**E:**Geodetic instrument | Өнцөг, өндөр, зай, хүндийн хүчний хурдатгал болон цэгийн байрлалыг орон зайн гурав болон түүнээс дээш хэмжээсээр тодорхойлох багаж |
| 728. | Теодолит | **Р:**Теодолит<br>**E:**Theodolite | Хэвтээ ба босоо өнцөг хэмжих зориулалттай геодезийн хэмжилтийн багаж |
| 729. | Гиротеодолит | **Р:**Гиротеодолит<br>**E:**Gyrotheodolite | Теодолит ба гирокомпас хавсарсан бүтээцтэй астрономийн жинхэнэ зовхис тодорхойлох оптик механикийн багаж |
| 730. | Кодон теодолит | **Р:**Кодовый теодолит<br>**E:**Digital read-out theodolite | Хэмжилтийг кодлох теодолит |
| 731. | Кодон тахеометр | **Р:**Кодовый тахеометр<br>**E:**Digital read-out tachymeter | Хэмжилтийг кодлох тахеометр |

| | | | |
|---|---|---|---|
| 732. | Давталтын теодолит | **Р:**Повторительный теодолит<br>**E:**Repeating theodolite | Алидадыг лимбээс тусад нь эсвэл хамтад нь эргүүлэх бүтээцтэй теодолит |
| 733. | Астрономийн теодолит | **Р:**Астрономический теодолит<br>**E:**Astronomical theodolite | Астрономийн хэмжилтээр өргөрөг, уртраг, зовхис тодорхойлох зориулалтын теодолит |
| 734. | Тахеометр | **Р:**Тахеометр<br>**E:**Tacheometer | Хэвтээ, босоо өнцөг, шугамын урт, өндөржилт хэмжих геодезийн багаж. *Тайлбар: Тахеометрт суулгасан зай хэмжүүрээр нь ангилна.* |
| 735. | Цахим тахеометр | **Р:**Электронный тахеометр<br>**E:**Digital tacheometer | Хэмжилтийн үр дүнг автоматаар бүртгэх цахим тоолууртай багаж |
| 736. | Квадрант | **Р:**Квадрант<br>**E:**Quadrant | Босоо өнцөг хэмжих багаж |
| 737. | Газар доорх шугам сүлжээ хайгч багаж | **Р:**Искатель подземных коммуникационных сетей<br>**E:**Geodetic finder | Газар доорх инженерийн шугам сүлжээг хайх, байрлал, гүнийг тодорхойлох багаж |
| 738. | Нивелир | **Р:**Нивелир<br>**E:**Level | Хэвтээ чиглэлд харах өндөржилтийг тодорхойлох геодезийн өндөр хэмжүүрийн багаж. *Тайлбар:Тэгшлүүртэй эсвэл тэнхлэг тохируулгатай нивелир байна* |
| 739. | Лазер нивелир | **Р:**Нивелир лазерный<br>**E:**Laser level | Хэмжилтийн цэгт лазерын гэрлийн мэдрэмжтэй, тусгай толгойтой рейк ашиглаж нивелирдлэг хийх нивелир |
| 740. | Автомат нивелир | **Р:**Автоматический лазерный нивелир<br>**E:**Automatic laser level | Тооллын автомат бүртгүүртэй лазер нивелир |
| 741. | Тоон нивелир | **Р:**Цифровой нивелир<br>**E:**Digital level | Автомат тооллын систем бүхий хэмжилтийн үр дүнг дэлгэцээр бүрэн илэрхийлэх өндөр нарийвчлалтай цахим нивелир |
| 742. | Оптик нивелир | **Р:**Нивелир оптический<br>**E:**Optical level | Дурангийн харах тэнхлэг хэвтээ байрлалд байх үеийн хэмжилт хийх нивелир |
| 743. | Компенсатортай нивелир | **Р:**Нивелир с компенсатором<br>**E:**Level with compensator | Нивелирийн эргэлтийн тэнхлэгийг дугуй тэгшлүүрээр урьдчилан босоо байрлалд оруулсны дараа харах тэнхлэгийг автоматаар хэвтээ байдалд оруулж өндөржилт тодорхойлох оптик нивелир |

| | | | |
|---|---|---|---|
| 744. | Рейк | **Р:**Нивелирная рейка<br>**E:**Leveling rod | Өндөржилт тодорхойлох төхөөрөмж |
| 745. | Дүүжилдэг рейк | **Р:**Рейки нивелирные подвесные<br>**E:**Pendulum leveling rod | Нивелирийн сэлгэцийн хэмжилтийг ханын тэмдэгтэд холбоход зориулагдсан дүүжилдэг төхөөрөмж |
| 746. | Дүүжилдэг инвар рейк | **Р:**Подвесная инварная рейка<br>**E:**Invar pendulum rod | Нивелирийн сэлгэцийн хэмжилтийг ханын тэмдэгтэд холбоход зориулагдсан дүүжилдэг инвар утастай төхөөрөмж |
| 747. | Шаталсан хуваарьтай рейк | **Р:**Рейки нивелирные шашечные<br>**E:**E-division leveling rod | Нэг талдаа хар цагаан, нөгөө талдаа улаан цагаан өнгийн шаталсан хуваарьтай нивелирдлэг хийх төхөөрөмж |
| 748. | Инвар рейк | **Р:**Рейки нивелирные штриховые<br>**E:**Invar rod | Хоёр эгнээгээр хөндлөн зураастай хуваарьтай, инвар утас татсан өндөр нарийвчлалын нивелирдлэг хийх төхөөрөмж |
| 749. | Зай хэмжилтийн рейк | **Р:**Дальномерная рейка<br>**E:**Stadia rod | Зай хэмжихэд зориулагдсан тусгай төхөөрөмж |
| 750. | Нивелирийн суулгавч | **Р:**Нивелирная насадка<br>**E:**Level attachment | Геодезийн бусад багажтай хоршин ажиллах зориулалттай нивелирийн харах дуран дээр нэмэлтээр суулгасан өндөр хэмжүүрийн хэрэгсэл |
| 751. | Дурангийн хаалт | **Р:**Бленда<br>**E:**Blend | Харах дурангийн объективыг нарны шууд гэрлээс хамгаалах таглаа |
| 752. | Геодезийн зай хэмжигч | **Р:**Геодезический дальномер<br>**E:**Geodetic distance meter | Хэмжиж буй шугамын уртыг шууд хэмжин тодорхойлох геодезийн багаж |
| 753. | Цахим-соронзон зай хэмжигч | **Р:**Электромагнитный дальномер<br>**E:**Electromagnetic field meter / EDM | Цахилгаан соронзон долгион тархах хугацааны хэмжилтэнд суурилсан геодезийн зай хэмжүүрийн багаж |
| 754. | Хоёрлосон дүрсийн зай хэмжигч | **Р:**Дальномер двойного изображения<br>**E:**Double-image distance meter | Харах байг хоёр дүрсээр үүсгэх, тэдгээрийн харилцан шилжилтийг хэмжих оптик зай хэмжүүрийн багаж |
| 755. | Зай хэмжигчийн суурь | **Р:**База дальномера<br>**E:**Base of distance meter | Оптик зай хэмжүүрийн параллактик өнцгийн эсрэг байрлах гурвалжны тал |
| 756. | Дотроо суурь (базис)-тай зай хэмжигч | **Р:**Внутрибазисный дальномер<br>**E:**Inner-base distance meter | Дотроо суурьтай хоёр дүрсийн зай хэмжүүрийн багаж |

| | | | |
|---|---|---|---|
| 757. | Тогтмол суурьтай оптик зай хэмжигч | **Р:**Оптический дальномер с постоянной базой<br>**E:**Optical distance meter with constant base. Subtense system | Хоёр объективтой, нэг окуляртай оптикийн зай хэмжүүрийн багаж |
| 758. | Тогтмол өнцөгтэй оптик зай хэмжигч | **Р:**Оптический дальномер с постоянным углом<br>**E:**Optical distance meter with constant stadia angle | Геодезийн хэмжилтийн багажийн харах дурангийн объективын арын зангилаа цэг ба зай хэмжүүрийн утсан торны хоёр зураасны үүсгэж байгаа цацрагийн үүсгэж байгаа байнгын өнцөг бүхий утсан зай хэмжүүрийн багаж |
| 759. | Геометрийн зай хэмжигч | **Р:**Геометрический дальномер<br>**E:**Geometrical distance meter | Гурвалжны бодолтонд тулгуурласан геодезийн зай хэмжүүрийн багаж |
| 760. | Оптик зай хэмжигч | **Р:**Оптический дальномер<br>**E:**Optical distance meter | Тэнцүү талтай параллактик өнцөгтэй гурвалжны бодолтоор хэмжилтийн зайг тодорхойлох оптик зай хэмжүүрийн багаж |
| 761. | Радио зай хэмжигч | **Р:**Радиодальномер<br>**E:**Microwave distance meter | Радио цахилгаан соронзон долгионы багтаамж (диапазон)-ийг ашигласан цахилгаан соронзон зай хэмжүүрийн багаж |
| 762. | Онгоцны радио зай хэмжигч | **Р:**Самолетный радиодальномер<br>**E:**Air-borne micro-wave distance meter | Онгоц ба газрын хүлээн авагч хоорондох алслагдсан налуу зайг хэмжих зай хэмжүүрийн багаж |
| 763. | Радио зай хэмжигчийн станц | **Р:**Станция радиодальномера<br>**E:**Microwave distance meter station | Хэмжилт хийж буй шугамын аль нэг төгсгөл дээр байрлуулсан радио-зай хэмжүүрийн бүтцийн нэг хэсэг |
| 764. | Лазер зай хэмжигч | **Р:**Дальномеры лазерные<br>**E:**Laser distance meter | Лазерын гэрлийн мэдрэмжтэй геодезийн лазерын зай хэжүүр |
| 765. | Дифференциал зай хэмжигч | **Р:**Дифференциальный дальномер<br>**E:**Differential range-finder | Дифференциал бичил хэмжүүртэй хоёр дүрсийн зай хэмжүүрийн багаж |
| 766. | Фазаар зайг хэмжих багаж | **Р:**Фазовый дальномер<br>**E:**Phase distance meter | Долгион тархах хугацааг тодорхойлохын тулд тасралтгүй цацруулж буй долгионы фазын зөрүүг хэмжихэд суурилсан цахим-соронзон зай хэмжүүрийн багаж |

| | | | |
|---|---|---|---|
| 767. | Гэрлэн зай хэмжигч | **Р:**Светодальномер<br>**Е:**Electro-optical distance meter | Гэрлийн багтаамжийн цахилгаан соронзон долгионыг ашиглах цахилгаан соронзон зай хэмжүүрийн багаж |
| 768. | Гэрэл ойлгогч | **Р:**Отражатель (светодальномера)<br>**Е:**Reflector | Гэрэл хүлээн авах, дамжуулагчаас гаргаж буй гэрлийн цацрагийг ойлгох гэрлэн зай хэмжүүрийн багажийн хэсэг |
| 769. | Лазер гэрэл ойлгогч | **Р:**Лазерный отражатель<br>**Е:**Laser reflector | Лазерын гэрэл хүлээн авах, дамжуулагчаас гаргаж буй лазерын гэрлийг ойлгох зай хэмжүүрийн хэсэг |
| 770. | Гэрлэн зай хэмжигчийн хүлээн авах-түгээх багаж | **Р:**Приемо-передатчик светодальномера<br>**Е:**Receiver-transmitter | Хэмжиж буй шугамын дагуу гэрлийн долгионыг цацруулах, хүлээн авах, түгээж буй хугацааг хэмжих багаж |
| 771. | Импульсийн зай хэмжигч | **Р:**Импульсный дальномер<br>**Е:**Pulse distance meter | Цахилгаан соронзон долгионы эх үүсвэрээсээ гарсан хугацаа болон ойлгогчоос ойгоод буцаж бүртгэгчид ирсэн хугацаа хоорондын зөрүүгээр зай хэмжигч цахилгаан соронзон зай хэмжүүрийн багаж |
| 772. | Утсан зай хэмжигч | **Р:**Нитяной дальномер<br>**Е:**Stadia system | Харах дурангийн объективын зангилаа цэг ба утсан торны зай хэмжүүрийн зураасыг дайрах цацрагийн үүсгэсэн тогтмол өнцөгтэй оптик зай хэмжүүрийн багаж |
| 773. | Редукцийн зай хэмжигч | **Р:**Редукционный дальномер<br>**Е:**Reduction distance meter | Хэмжиж буй шугамын хэвтээ тавилыг шууд унших теодолит |
| 774. | Зай хэмжигчийн суулгавч | **Р:**Дальномерная насадка<br>**Е:**Tacheometric prism attachment | Геодезийн зай хэмжих багажийн окулярт суулгадаг геодезийн бусад багажтай хоршин ажиллах тусгай багаж |
| 775. | Лазер сканер | **Р:**Лазерный сканер<br>**Е:**Laser scanner | Газрын гадарга ба аливаа биетийн гадаргуу дээрх цэгийн солбицлыг, орон зайн солбицлын тогтолцоонд тодорхойлох багаж |
| 776. | Геодезийн сансрын төхөөрөмж | **Р:**Геодезический космический комплекс (ГКК)<br>**Е:**Geodetic space complex | Геодезийн сүлжээ байгуулах, Дэлхийн эллипсоидын болон татах хүчний талбайн үндсэн үзүүлэлтүүдийг тодотгоход зориулагдсан газрын болон |

| | | | |
|---|---|---|---|
| | | | сансрын техник хэрэгслийн иж бүрдэл |
| 777. | Хуйлмал метр | **Р:**Рулетки<br>**E:**Tape | Богино зай хэмжих шугаман хэмжүүрийн энгийн багаж |
| 778. | Сүлбэрэг | **Р:**Шпильки<br>**E:**Chaining pins | Хуйлмал метр, ган туузаар зай хэмжих үед хэмжих хэрэгслийн төгсгөлийн хуваарийг газарт тэмдэглэх шор төмөр |
| 779. | Шалгах шугам | **Р:**Линейка контрольная<br>**E:**Control ruler | Гурвалжин огтлолтой ган, гууль эсвэл инвараар хийсэн ирмэг нь 0,2-0,5 мм хуваарийн нэгжтэй, дээд ирмэгийн дээд хэсэгт термометр суулгасан, 1 метрээс бага зэрэг урт шугам |
| 780. | Дробышевийн шугам | **Р:**Линейка Дробышева<br>**E:**Drobysheva line | Зураглалын самбар дээр тэгш өнцөгт солбицлын тор байгуулах зориулалтын нарийн хуваарьтай төмөр шугам |
| 781. | Төвлөрүүлэгч | **Р:**Геодезический центрир Центрир<br>**E:**Geodetic plummet | Нэг хавтгай дээрх цэгийг нөгөө хавтгай дээр эгц тусгагаар буулгах геодезийн төвлөрүүлэгч багаж |
| 782. | Механик төвлөрүүлэгч | **Р:**Механический центрир<br>**E:** Mechanical plummet | Механик элементээр босоо шулууны байрлалыг чиглүүлэх геодезийн төвлөрүүлэгч багаж |
| 783. | Оптик төвлөрүүлэгч Лотоаппарат | **Р:**Оптический центрир Лотоаппарат<br>**E:**Zenith plummet | Багажийн босоо тэнхлэгийг эгц доош ба дээш нь хараалах оптик багаж |
| 784. | Тэгшлүүр | **Р:**Уровень<br>**E:**Level | Геодезийн багажийн геометрийн нөхцөлүүдийг бүрдүүлэхэд ашиглагддаг шингэнээр дүүргэгдсэн цэврүү бүхий хэрэгсэл (тэгш ус) |
| 785. | Бортгон тэгшлүүр | **Р:**Цилиндричесеий уровень<br>**E:**Cylindrical level | Теодолитын хэвтээ дугуйн лимбийн хавтгайг хэвтээ байрлалд оруулах зориулалт (теодолитын эргэлтийн тэнхлэгийг босоо байрлалд оруулах) бүхий бортгон хэлбэртэй тэгшлүүр |
| 786. | Геодезийн тэгшлүүр | **Р:**Геодезический уровень<br>**E:**Geodetic level | Геодезийн багаж, түүний зарим зангилаа эд ангийг босоо шулуунтай харьцангуй байрлуулах тэгшлүүр |
| 787. | Дугуй тэгшлүүр | **Р:**Круглый уровень<br>**E:**Round level | Дугуй шилний дотоод гадарга дээд хэсэг нь бөмбөлөг |

| | | | |
|---|---|---|---|
| | | | хэлбэртэй шингэнтэй тэгшлүүр |
| 788. | Тохсон тэгшлүүр | **P:**Накладной уровень<br>**E:**Striding level | Багажийн зарим эд ангийг тогтоох, ажлын гадаргатай гэр бүхий авч сольж болох тэгшлүүр |
| 789. | Тогтворжуулагчтай тэгшлүүр | **P:**Компенсированный уровень<br>**E:**Compensating level | Агаарын хэмийн өөрчлөлттэй үед цэврүүний уртыг тогтворжуулах бортгон тэгшлүүр |
| 790. | Авцалдаат тэгшлүүр | **P:**Контактный уровень<br>**E:**Coincidence bubble;Spiit-beam level | Тэгшлүүрийн цэврүүний төгсгөлийн дүрсний давхцалыг харах олон талст бүхий зууван тэгшлүүр |
| 791. | Талькоттын тэгшлүүр | **P:**Уровень Талькотта<br>**E:**Talcott-level<br>Horrebow level | Астрономийн теодолитын харах дурангийн хамгийн бага хазайлтыг мэдрэх тохируулагч эрэгтэй зууван тэгшлүүр |
| 792. | Хорготой тэгшлүүр | **P:**Камерный уровень<br>**E:**Chamber level | Цэврүүний уртыг тохируулагч хорготой шоовон шилтэй бортгон тэгшлүүр |
| 793. | Багаж төвлөрүүлэгч | **P:**Отвес<br>**E:**Plummet. Plumb bob | Дүүжмэг хэлбэрийн механик төвлөрүүлэгч хэрэгсэл |
| 794. | Нэг талтай оптик төвлөрүүлэгч | **P:**Односторонний оптический центрир<br>Односторонний центрир<br>**E:**Optical plummet | Харах тэнхлэгийг зөвхөн дээшээ эсвэл зөвхөн доошоо чиглүүлж болох оптик төвлөрүүлэгч багаж |
| 795. | Хоёр талтай оптик төвлөрүүлэгч | **P:**Двухсторонний оптический центрир<br>Двухсторонний центрир<br>**E:**Zenith-nadir optical plummet | Харах тэнхлэгийг дээшээ эсвэл доошоо чиглүүлж болох оптик төвлөрүүлэгч багаж |
| 796. | Геодезийн багажийн хөл | **P:**Штатив для геодезического прибора<br>**E:**Tripod | Геодезийн багажийг суурилуулж ажлын байрлалд оруулах, газрын хөрсөнд бэхлэх төмөр эсвэл модон гурван хөлтэй тулгуур |
| 797. | Багажан хөлний дээд тавиур | **P:**Головка штатива для геодезического прибора<br>**E:**Tripod head | Геодезийн багаж суурилуулах гурван хөлтэй тулгуурын дээд тавиур |
| 798. | Мензул | **P:**Мензула<br>**E:**Plane-table | Мензулын самбар, түүнийг тохируулах тавиуртай байр зүйн зураглалд зориулсан бүрэлдэхүүн хэсгүүд |
| 799. | Кипрегел | **P:**Кипрегель<br>**E:**Telescopic alidade | Байр зүйн зураглалаар босоо өнцөг, зай, өндөржилт хэмжих, чиглэлийн зурмаг (график) байгуулах геодезийн багаж |

| | | | |
|---|---|---|---|
| 800. | Номограмын кипрегел | **P:**Номограмный кипрегель<br>**E:**Nomogram alidade | Дурангийн харах талбайд зай ба өндөржилт хэмжих муруйнуудтай кипрегел |
| 801. | Кипрегелийн шугам | **P:**Линейка кипрегеля<br>**E:**Ruler of alidade | Зургийн суурь дээр чиглэл зурах кипрегелийн тулгуур шугам |
| 802. | Мензулын самбар | **P:**Мензульная доска<br>**E:**Plane table drawing board | Байр зүйн зураглал хийх зориулалттай хатуу эх дээр цаас эсвэл гэрэл зургийн цаас нааж байрлуулах боломжтой самбар |
| 803. | Геодезийн рефракторметр | **P:**Геодезический рефрактометр<br>**E:**Geodetic refractometer | Орчинд гэрлийн хугарлыг хэмжих геодезийн хэмжилтийн багаж |
| 804. | Гирокомпас | **P:**Гирокомпас<br>**E:**Gyrocompass | Дэлхийн хоногийн эргэлт ба чөлөөт эргэх чанарыг (гироскоп) ашиглан өгөгдсөн чиглэлийн зовхисыг тодорхойлох зорилгоор бүтээгдсэн жинхэнэ голдчийг тодорхойлох багаж |
| 805. | Гироскоп | **P:**Гироскоп<br>**E:**Gyroscope | Өөрийн хурдан эргэлтийн явцад эргэлтийн тэнхлэгийн чиглэлийг өөрчилдөггүй хатуу биет |
| 806. | Пантограф | **P:**Пантограф<br>**E:**Pantograph | Нэг хавтгайгаас нөгөө хавтгайд дүрсний хэлбэрийг хадгалан механик аргаар шилжүүлэх багаж |
| 807. | Экзаменатор | **P:**Экзаменатор<br>**E:**Examiner | Хязгаарлагдсан хэмжээнд налуу бага өнцгийг үйлдэх, эсвэл өндөр нарийвчлалын хэмжилтийн хяналт-хэмжилтийн хэрэгсэл |
| 808. | Тэгшлүүрийн экзаменатор | **P:**Экзаменатор уровней<br>**E:**Level examiner | Тэгшлүүрийн хуваарийн нэгжийг тодорхойлох экзаменатор |
| 809. | Коллиматор | **P:**Коллиматор<br>**E:**Collimator | Зайнаас ирж буй цахим соронзон гэрлийн зэрэгцээ нарийн цацрагуудыг хүлээн авах зориулалтын оптикийн төхөөрөмж |
| 810. | Автоколлиматор | **P:**Автоколлиматор<br>**E:**Autocollimator | Автоколлимацийн зарчимд суурилсан өнцөг хэмжих, шулуун ба хавтгай байдлыг шалгах оптик багаж |
| 811. | Адилтгуур буюу жишигч төхөөрөмж | **P:**Компаратор<br>**E:**Comparator | Өгөгдсөн хэмийн нөхцөлд уртын хэмжүүрийг эх хэмжүүртэй жиших замаар геодезийн уртын хэмжүүрийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | нэгжийг тодорхойлох геодезийн шалгалтын тоноглол |
| 812. | Интерференцийн адилтгуур | **Р:**Компаратор интерференционный<br>**E:**Interferential comparator | Гэрлийн цацрагийн хүчдэлийг орон зайд жигд тараах оптикийн чанарт суурилсан гэрлийн цацрагтай харьцуулан уртыг жиших оптик багаж |
| 813. | Оптик-механикийн адилтгуур | **Р:**Компаратор оптико-механический<br>**E:**Optical-mechanical comparator | Тэргэнцэр дээр байрлуулсан жишилтийн очир/жезл/-ын дагуу хөдлөх компаратор бөгөөд захын хоёр окулярын бичил хэмжүүрийн тэнхлэг хоорондын урттай, зай хэмжүүрийн багажийн уртыг тодорхойлох багаж |
| 814. | Хээрийн адилтгуур | **Р:**Компаратор полевой<br>**E:**Field comparator | Хээрийн ажлын хэмжилтийн нөхцөлд зай хэмжүүрийн уртыг жиших зориулалтаар байгуулсан адилтгуур |
| 815. | Нивелирийн гадас | **Р:**Костыль нивелирный<br>**E:**Leveling crutch | Нивелирийн хэмжилтийн явцад рейк босгож байрлуулах газарт түр бэхлэх төмөр гадас |
| 816. | Ивүүр | **Р:**Башмак<br>**E:**Rod foot | Нивелирийн рейк босгож барих зорилгоор бэлтгэсэн дугуй, дөрвөлжин хэлбэрийн метал цуулаг хавтан |
| 817. | Инвар утас | **Р:**Инварная проволока<br>**E:**Invar wire | Шугаман хэмжүүрт зориулсан инвараар хийсэн зай хэмжүүрийн ган утас |
| 818. | Ватерпас | **Р:**Ватерпас<br>**E:**Water-level | Хэвтээ шулуун шалгах, налуугийн өнцөг хэмжих энгийн багаж |
| 819. | Луужин | **Р:**Компас<br>**E:**Compass (Magnetic) | Газрын гадарга дээр голдчийн чиглэлд харьцангуйгаар зүг чигийг тодорхойлох зориулалтын багаж |
| 820. | Геодезийн луужин | **Р:**Геодезический компас<br>**E:**Geodetic Compass | Соронзон зовхис хэмжих геодезийн багаж |
| 821. | Геодезийн дугуй луужин | **Р:**Круглый компас<br>**E:**Ring compass | Ажлын хэмжүүр нь битүү тойрог хэлбэртэй геодезийн луужин |
| 822. | Буссоль | **Р:**Буссоль<br>**E:**Compass | Газар дээр соронзон зовхис ба румбийг хэмжих зориулалтын багаж |
| 823. | Экер | **Р:**Экер<br>**E:**Right-angle, Optical square | Газар дээр тэгш өнцөг байгуулах геодезийн энгийн багаж |

| | | | |
|---|---|---|---|
| 824. | Хоёр тольт экер | **P:**Двухзеркальный экер<br>**E:**Two-mirror ecker | Нэг нь нөгөөдөө 45 градусын өнцгөөр хоёр хавтгай толь байрлуулсан багаж |
| 825. | Эклиметр | **P:**Эклиметр<br>**E:**Abney level, Clinometer | Шугамын өнцөг ба хэвгийг хэмжих геодезийн гар багаж |
| 826. | Эклиметр-өндөр хэмжигч | **P:**Эклиметр-высотомер<br>**E:**Abney level Clinometer | Өндөржилт хэмжих хэмжүүрийг суурилуулсан геодезийн багаж |
| 827. | Нислэгийн өндөр хэмжигч | **P:**Альтиметр<br>**E:**Altimeter | Нисэх төхөөрөмжүүдийн нислэгийн өндөр тодорхойлогч багаж |
| 828. | Геодезийн төмөр жишиг шугам | **P:**Жезл геодезический<br>**E:**Geodesic Wand | 3м хүртэл урттай шугамын уртын хэмжүүрийг жишигч эх хэмжүүр буюу шалгах хэмжүүр |
| 829. | Транспортир | **P:**Транспортир геодезический<br>**E:**Geodetic protractor | Зураг ба цаасан дээр өнцөг байгуулах, хэмжих багаж |
| 830. | Тооны машин-арифмометр | **P:**Арифмометр<br>**E:**Arithmometer/calculator | Арифметикийн тоо нэмэх, хасах, үржүүлэх, хуваах үйлдэлтэй механик хэрэгсэл |
| 831. | Байр зүйн шугам | **P:**Топографическая линейка<br>**E:**Topographic rule Tacheometric rule | Байр зүйн болон дэвсгэр зураг дээр тэгш өнцөгт тор байгуулах ажлын хэмжүүртэй шугам |
| 832. | Гортиг | **P:**Циркуль<br>**E:**Compass (circle) | Тойрог зурах ба зураг дээр зай хэмжих зориулалттай хоёр хөлийг дэлгэж холдуулж, ойртуулж болдог зургийн хэрэгсэл |
| 833. | Харах бай | **P:**Визирная цель<br>**E:** Sighting target | Хэмжилт хийх зориулалтаар цэг дээр байрлуулсан тэмдэг буюу биет |
| 834. | Хараа, чиглүүр | **P:**Визир<br>**E:**Sight, Viseur | Дурангийн хараалах тэнхлэгийг байтай давхцуулахад туслах овоо, хараа |
| 835. | Харах марк | **P:**Визирная марка<br>**E:**Sighting target mark | Эргэх тэнхлэг нь тэгш хэмээр зурсан дүрс бүхий ялтас хэлбэрийн харах бай |
| 836. | Курвиметр-Муруй хэмжүүр | **P:**Курвиметр<br>**E:**Curvimeter | Газрын зураг дээр муруй шугамын уртыг хэмжигч зураг хэмжилзүйн багаж |

**ГЕОДЕЗИЙН БАГАЖИЙН ЭД АНГИУД**
**ДЕТАЛИ ГЕОДЕЗИЧЕСКИХ ИНСТРУМЕНТОВ**
**DETAILS OF GEODESIC INSTRUMENTS**

| | | | |
|---|---|---|---|
| 837. | Верньер | **P:**Верньер, нониус<br>**E:**Vernier, nonius | Тэнцүү хуваагдсан шатлалаар хэмжилтийн хувийг тоолох зураас |
| 838. | Геодезийн багажийн дугуй | **P:**Круг<br>**E:**Circle | Геодезийн багажийн лимбийг тээгч эд анги |

| | | | |
|---|---|---|---|
| 839. | Геодезийн багажийн дугуйн байрлал | **P:**Положение круга **E:**Cirle position | Теодолитоор хэмжилт хийх үеийн босоо дугуйн байрлал |
| 840. | Дугуй баруун, дугуй зүүн | **P:**Круг право; Круг лево **E:**Circle right; Left Circle | Хэмжилт хийх үед багажийн босоо дугуй, дурангийн баруун, зүүн талд байрлалтай байх үеүд |
| 841. | Өнцөг хэмжих дугуй | **P:**Круг угломерный **E:**Goniometric circle | Шил эсвэл металлаар хийсэн теодолитын гол бүтээцийн (лимб ба алидад) хэвтээ,босоо өнцөг хэмжих төхөөрөмж |
| 842. | Өнцөг хэмжих босоо дугуй | **P:**Круг угломерный вертикальный **E:**Circle goniometric vertical | Багажийн босоо хавтгайд байрлуулан өнцөг хэмжилт хийх төхөөрөмж |
| 843. | Хэвтээ өнцөг хэмжих дугуй | **P:**Круг угломерный горизонтальный **E:**Horizontal goniometer circle | Багажийн хэвтээ хавтгайд байрлуулан өнцөг хэмжилт хийх төхөөрөмж |
| 844. | Тооллын дуран бай | **P:**Отсчетный микроскоп **E:**Reading microscope | Хэд хэдэн линзнээс бүрдэх объектив, окулярын оптикийн систем |
| 845. | Утсан торны биссектор | **P:**Биссектор сетки нитей зрительной трубы **E:**Bisector | Дурангийн утсан торны босоо хос зураадас |
| 846. | Утсан тор | **P:**Сетка нитей зрительной трубы геодезического прибора **E:**Cross-hair | Геодезийн хэмжилтийн дуран дотор байрлуулсан харилцан перпендикуляр, параллель босоо ба хэвтээ зураас |
| 847. | Утсан торны үндсэн зурааснууд | **P:**Основные штрихи сетки нитей зрительной трубы геодезического прибора **E:**Cross-hairs | Харах дуранг хэвтээ ба босоо байдалд чиглүүлэх утсан торны зурааснууд Геодезийн багажийн дурангийн төвийг буюу харах тэнхлэгийг дайрсан утсан торны зурааснууд |
| 848. | Утсан торны зай хэмжигч зурааснууд | **P:**Дальномерные штрихи сетки нитей зрительной трубы геодезического прибора **E:**Stadia hairs | Геодезийн багажийн дурангийн утсан тороор рейкээс зай хэмжихэд ашиглагддаг зурааснууд |
| 849. | Утсан торны огтлолцол | **P:**Перекрестие сетки нитей зрительной трубы **E:**Cross hairs intersection | Дурангаар хэмжилт хийхэд зориулагдсан торны босоо ба хэвтээгээр харилцан перпендикуляраар татсан үндсэн зурааснуудын огтлолцол цэг |
| 850. | Алидад | **P:**Алидада **E:**Alidade | Лимбийн төвийг дайрах тэнхлэгийн дагуу эргэлдэх, |

| | | | |
|---|---|---|---|
| | | | тоолол авах хэрэгсэл бүхий геодези, астрономийн багажийн хэсэг |
| 851. | Лимб | **Р:**Лимб<br>**E:**Limb | Теодолитын эргэх тэнхлэг дээр бэхлэгдсэн тодорхой заагаар 0-360$^0$ хүртэл хуваарьтай шилэн дугуй |
| 852. | Багажийн тавцан | **Р:**Подставка геодезического прибора **E:**Footplate | Багаж байрлуулах, хэвтээ хавтгайд тэгшлэх зориулалттай геодезийн багажийн хэсэг |
| 853. | Засварын эргүүд | **Р:**Винты исправительные<br>**E:**Corrective screws | Багажийн тохиргоо хийх, засах эрэг |
| 854. | Чиглүүлэх эргүүд | **Р:**Винты наводящие<br>**E:**Directing screws | Хэмжилтийн багажийн эд ангийн хэсгийг аажмаар, удаан эргүүлж чиглүүлэг хийх эрэг |
| 855. | Өргөх эргүүд | **Р:**Винты подъемные<br>**E:**Lifting screws | Геодезийн багажийн эргэлтийн тэнхлэгийг босоо байрлалд тавих геодезийн багаж тэгшлэх гурван эрэг |
| 856. | Тогтоогч буюу бэхлэх эрэг | **Р:**Становой винт<br>**E:**Tripod clamp | Багажийг хөл дээр нь бэхлэх эрэг |
| 857. | Нарийн тохируулах эрэг /элевацион эрэг/ | **Р:**Винт элевационный<br>**E:**Tilting screw | Харах дурангийн налууг бага хэмжээгээр өөрчлөх, түүнтэй холбоо бүхий тэгшлүүрийн тэнхлэгийг хазайлгах хэрэгсэл бүхий эрэг |
| 858. | Дурангийн түгжигч эрэг | **Р:**Закрепительное винты<br>**E:**Clamp | Өгөгдсөн байрлалд геодезийн багажийн хөдөлгөөнт эд ангийг тогтоон бэхлэх хавчаар |
| 859. | Багаж бэхлэгч эрэг | **Р:**Арретир<br>**E:**Arresting device | Хэмжилтийн багаж хэрэгслийн хөдөлгөөнт хэсгийг бэхлэх механик хэрэгсэл |
| 860. | Авцалдаат бичил хэмжигч | **Р:**Контактный микрометр<br>**E:**Contact micrometer | Харах дурангийн талбайд харагдах хөдөлгөөнт объект, утсан торыг дайрах үеийг тэмдэглэх геодезийн багажийн цахилгаан окулярын авцалдаат бичил хэмжүүр |
| 861. | Бичил хэмжигч Микрометр | **Р:**Микрометр<br>**E:**Micrometer | Бага хэмжээний шугаман хэмжээс болон бага өнцгийг нарийн хэмжих хэрэгсэл |
| 862. | Оптик бичил хэмжигч | **Р:**Оптический микрометр<br>**E:**Oprical micrometer | Өнцөг хэмжүүрийн багажийн лимбын хуваарийг нарийвчлан хэмжих зорилгоор тэдгээрийн дүрсийг шилжүүлэн байрлуулах байдлаар хэмжих хэрэгсэл |
| 863. | Окулярын бичил хэмжигч | **Р:**Окулярный микрометр | Окуляр хэсэгт байрлах дуранбай микроскопоор тоолол авах хэрэгсэл |

| | | | |
|---|---|---|---|
| | | **E:**Reading eyepiece micrometer | |
| 864. | Тооллын өгсгөгч дуран | **Р:**Микроскоп отсчетный **E:**Reading microscope | Хэмжилтийн ажлын хэмжүүрээр тоолол авах оптик тоноглол |
| 865. | Геодезийн багажийн нумарсан харах дуран | **Р:**Ломаная зрительная труба геодезического прибора **E:**Curve telescope | Геодезийн багажийн оптик тэнхлэг нь нугарсан хэлбэртэй харах дуран |
| 866. | Рейкны ул | **Р:**Пятка рейки **E:**Heel rod | Репер, ивүүр, гадсан дээр рейк байрлуулахад зориулсан рейкны ул хэсгийг бөгжилсөн төмөр |

## ГЕОДЕЗИЙН БАГАЖИЙН ЭД АНГИУДЫН ЗОХИЦОЛ
## СООТНОШЕНИИ ДЕТАЛИ ГЕОДЕЗИЧЕСКИХ ИНСТРУМЕНТОВ
## HARMONIZATION PARTS OF GEODETIC INSTRUMENTS

| | | | |
|---|---|---|---|
| 867. | Багаж тэгшлэх | **Р:**Горизонтирование прибора **E:**Leveling instrument | Геодезийн багажийн босоо тэнхлэгийг эгц босоо шулуунтай давхцуулах ба түүний хэвтээ тэнхлэгийг хэвтээ байрлалд шилжүүлэх үйлдэл |
| 868. | Багажийн түвшин | **Р:**Горизонт инструмента **E:**Tool level | Багажийн харах тэнхлэгийн түвшний гадарга эсвэл тогтоосон түвшин дээрх өндөр |
| 869. | Тэгийн байр | **Р:**Место нуля **E:**Zero level | Теодолитын дурангийн харах тэнхлэг хэвтээ байрлалтай, босоо дугуйн алидад дээр байрлуулсан тэгшлүүрийн цэврүү дундаа байх үед нь босоо дугуйгаар авсан тоолол |
| 870. | Багаж төвлөрүүлэх | **Р:**Центрирование прибора **E:**Instrument centering | Геодезийн багажийн босоо тэнхлэгийг геодезийн цэгийн төвийг дайрч буй эгц босоо шулуунтай давхцуулах үйлдэл |
| 871. | Суурь хэмжилтийн багаж | **Р:**Базисный прибор **E:**The basic instrument | Хэмжилтийн инвар утсаар шугамын уртыг шууд хэмжих геодезийн багаж |
| 872. | Эксцентриситет | **Р:**Эксцентриситет **E:**Eccentricity | Давхцаж байх ёстой хоёр төвүүдийн үл давхцал |
| 873. | Алидадын эксцентриситет | **Р:**Эксцентриситет алидады **E:**Alidade eccentricity | Лимба ба алидадын төвүүдийн үл давхцал |
| 874. | Лимба төв | **Р:**Центр лимба **E:**Limb center | Хэвтээ ба босоо өнцөг хэмжихэд зориулагдсан тойргон |

| | | | |
|---|---|---|---|
| | | | хуваагдалтай дугуйн диаметрүүдийн огтлолцох цэг |
| 875. | Лимбийн эксцентриситет | **Р:**Эксцентриситет лимба **E:**Eccentricity of limb | Лимбийн эргэх тэнхлэг, түүний хуваарийн дугуйн төв хоёрын үл давхцал |
| 876. | Харах шулуун | **Р:**Визирная линия **E:**Sight line | Дурангийн хараалах тэнхлэг |
| 877. | Дурангийн харах тэнхлэг | **Р:**Ось визирная **E:**Axis of sight | Хараалах дурангийн доторх линзүүдийн ба утсан торны төвүүдийг дайрсан шулуун |
| 878. | Зай хэмжүүрийн муруйнууд | **Р:**Номограмма расстояний геодезического прибора Диаграмма расстояний **E:**Nomogram of distances geodetic device Distance chart | Хэвтээ тавилтыг хэмжих зориулалттай геодезийн багажийн дурангийн харах талбайд байрлах муруйнууд |
| 879. | Өндөржилт хэмжүүрийн муруйнууд | **Р:**Номограмма превышений геодезического прибора **E:**Nomogram of excesses of the geodetic instrument | Геодезийн багажийн дурангийн харах талбайд байрлах өндөржилт хэмжих зориулалттай муруйнууд |
| 880. | Багажийн тохируулга | **Р:**Юстировка прибора **E:**Device adjustment | Геодезийн багажийн геометрийн нөхцөлүүдийн үл зохицолдоог засах үйлдэл |
| 881. | Тэнхлэг | **Р:**Ось **E:**Axis | Дурангийн дотор байрлах линзүүдийн ба утсан торны төвүүдийг дайрсан шулуун |
| 882. | Багажийн хэвтээ тэнхлэг | **Р:**Горизонтальная ось геодезического прибора **E:**Horizontal axis | Геодезийн багажийн харах дурангийн эргэх тэнхлэгийг босоо хавтгайгаар эргүүлэх |
| 883. | Багажийн босоо тэнхлэг | **Р:**Вертикальная ось геодезического прибора **E:**Vertical axis | Геодезийн багажийн хэвтээ дугуйн алидадын эргэх тэнхлэг |
| 884. | Дурангийн өсгөлт | **Р:**Увеличение зрительной трубы **E:**Telescope increment | Объективын харах дуранд харагдах өнцгийг энгийн нүдээр харах өнцөгт харьцуулсан харьцаа |
| 885. | Дурангийн голлол, дурангийн фокус | **Р:**Фокус **E:**Focus | Биетээс ойсон гэрлийн цацрагууд оптик шилийг дайрч өнгөрөхдөө хугарч нэг цэг дээр цугларч бөөгнөрөх ба түүнийг томруулан харах үйл явц |

| | | | |
|---|---|---|---|
| 886. | Дурангийн голлол тохируулах, фокус тохируулах | **P:**Фокусировка изображения **E:**Focusing the image | Хэмжилтийн объектын дүрсийг тод харахын тулд оптик системийн зарим эд ангийг хөдөлгөх үйлдэл |
| 887. | Дүрсийн голлол тохиргоо, дүрсийн фокус тохиргоо | **P:**Фокусировка внешнего изображения **E:**External Image focus | Геодезийн хэмжилтийн багажийн харах дурангийн окулярын хэсгийг хөдөлгөж утсан торны хавтгайг дуранд харагдаж буй объектын дүрсийн хавтгайтай давхцуулах хүртэл голлол тохируулах үйлдэл |
| 888. | Дурангийн голлолын ( фокусын) хавтгай | **P:**Фокальная плоскость **E:**Focal plane | Геодезийн багажийн дурангийн оптикийн фокусын геометр байр |
| 889. | Тэгшлүүрийн цэврүү | **P:**Пузырёк уровня **E:**Level bubble | Тэгшлүүрийн дугуй ба бортгон хэлбэрийн шилийг спирт эсвэл эфирээр халаасан шингэнээр дүүргэсний дараа нэг үзүүрийг нь хайлуулж битүүмжлээд шилэн савны дотор оруулсан агаартай орон зай |
| 890. | Тэгшлүүрийн тэг байр | **P:**Нуль-пункт уровня **E:**Zero point level | Хуруу шилний шингэний дээд хэсгийн цэврүүний түвшний төв цэг |
| 891. | Тэгшлүүрийн хуруу шил | **P:**Ампула уровня **E:**Level ampoule | Дээд талын дотор ханыг тодорхой радиустай нумын хэсгээр хийж, шингэнээр дүүргэж битүүмжилсэн тунгалаг шилэн сав |
| 892. | Дугуй тэгшлүүрийн тэнхлэг | **P:**Ось круглого уровня **E:**Axis of round level | Дугуй тэгшлүүрийн шилэн савны бөмбөлөг гадаргууд эгц байрлалтай, тэг байрыг дайрч өнгөрөх шулуун |
| 893. | Дугуй тэгшлүүрийн тэгийн байр | **P:**Нуль-пункт круглого уровня **E:**Zero point round level | Тэгшлүүрийн тусламжтайгаар хазайлтыг тодорхойлох зураас эсвэл тэгшлүүрийн гэрний цэг |
| 894. | Бортгон тэгшлүүрийн тэнхлэг | **P:**Ось цилиндрического уровня **E:**Axis of cylindrical level | Тэгшлүүрийн тэг байр ба хуруу шилний дагуу огтлолын нумд шүргэх шулуун |
| 895. | Тэгшлүүрийн хуваарийн нэгж | **P:**Цена деления уровня **E:**Price of division of level | Бортгон тэгшлүүрийн цэврүүг нэг хуваариар хазайлгахад түүний тэнхлэгийн байрлал шилжих налуу өнцөг |

| | | | |
|---|---|---|---|
| 896. | Хуваарийн нэгж | **Р:**Цена деления **E:**Division scale unit | Хэмжүүрийн багажийн хуваарийн нэг шатлалд тохирох өнцгийн ба уртын хэмжигдэхүүн |
| 897. | Рейкний хуваарийн нэгж | **Р:**Цена деления рейки **E:**Price of division lath | Рейкний шугаман хуваарийн нэгж |
| 898. | Өнцөг хэмжилтийн хуваарийн нэгж | **Р:**Цена деления угломерного круга **E:**Angle-measuring circle scale unit | Тооллын зэрэгцээ зураасыг дайрах өнцөг хэмжилтийн дугуйн радиус хоорондын төвийн өнцгөөр илэрхийлэгдэх хуваарийн нэгж |
| 899. | Рейкний шинжилгээ | **Р:**Исследование рейки **E:**Rod inverstigation /examination/ | Рейкний будгийн чанар, хуваарийн хэмжээ, инвар утасны таталтын хэмжээ, нэг метрийн ба дециметрийн урт, улны зөрүү зэргийг тодорхойлох хэмжилт, шалгалтууд |
| 900. | Нивелирийн шалгалт | **Р:**Поверки нивелира **E:**Leveling chek | Нивелирийн харах чиглэлийг хэвтээ чиглэлд шилжүүлэх үйлдлийг байнга хадгалах геометрийн ба зохион бүтээцийн шаардлагыг хэрхэн хангаж байгааг шинжлэх, шалгах, тохируулах ажиллагаа. |
| 901. | Теодолитын шалгалт | **Р:**Поверки теодолита **E:**Chek theodolite | Геометрийн болон бүтээцийн хувьд хэвтээ, босоо өнцөг хэмжих шаардлагыг хэрхэн хангаж байгааг шинжлэх, шалгах, тохируулах ажиллагаа |
| 902. | Коллимацийн хавтгай | **Р:**Плоскость коллимационная **E:**Collimation plane | Багажийн дурангийн хараалах тэнхлэг нь эргэлтийнхээ тэнхлэгтэй перпендикуляр байх үед дуранг зенит эргүүлэхэд босоо торны дагуу үүсэх хавтгай. |
| 903. | Геодезийн багажийн харах дуран | **Р:**Зрительная труба геодезического прибора Зрительная труба **E:**Telescope | Объектив, окуляр, утсан тортой геодезийн багажийн харах дуран |
| 904. | Зай хэмжигчийн параллактик өнцөг | **Р:**Параллактический угол дальномера **E:**Parallactic angle of distance meter/stadia | Шугамын уртыг тодорхойлох үед геометрийн зай хэмжүүрээр хэмжиж буй эсвэл тастаж байгаа гурвалжны өнцөг |
| 905. | Оптик тусгагуур | **Р:**Оптический проектор **E:**Optical projector | Оптикийн аргаар нэг хавтгай дээрх дүрсийг нөгөө хавтгайд шилжүүлэх багаж |
| 906. | Геодезийн багажийн хэвтээ тэнхлэгийг тээгч тулаас | **Р:**Колонка геодезического прибора **E:**Pillar | Геодезийн багажийн хэвтээ тэнхлэгийг тээгч тулаас |

| | | | |
|---|---|---|---|
| 907. | Компенсатор-тэнхлэг тохируулагч | **Р:**Компенсатор углов наклона<br>**E:**Compensator | Босоо дугуйн тооллын систем эсвэл хараалах тэнхлэгийг ажлын байрлалд автоматаар шилжүүлэх хэрэгсэл |
| 908. | | | |
| 909. | Адилтгах (жишилт хийх) | **Р:**Компарирование<br>**E:**Comparison | Ажлын уртыг жишиг хэмжүүрийн багажийн урттай харьцуулах үйлдэл |
| 910. | Оптик зай хэмжигчийг адилтгах | **Р:**Компарирование оптических дальномеров<br>**E:**Compression of optical stadia | Хээрийн адилтгуур дээр зай хэмжүүрийн итгэлцүүрийн хэмжигдэхүүнийг, ажил эхлэлийн өмнө ба төгсгөлд харьцуулан тодорхойлох адилтгах үйлдэл |
| 911. | Инвар утсыг адилтгах | **Р:**Компарирование инварной проволоки<br>**E:**Invar wire calibration | Инвар утасны ажлын уртыг суурин жишиг урттай харьцуулах арга |
| 912. | Геодезийн багажийн тэнхлэгийн давталтын систем | **Р:**Повторительная система осей геодезического прибора<br>**E:**Repeating system of axes of geodetic instrument | Геодезийн хэмжилтийн багажийн хөдөлгөөнгүй хэсэгтэй харьцангуй эргэлдэх нөхцөлийг хангах алидадын тэнхлэг ба дугуйн систем |

**ГЕОДЕЗИЙН ХЭМЖИЛТИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ БУСАД БАГАЖУУД**
**ПРИКЛАДНЫЕ ГЕОДЕЗИЧЕСКИЕ ПРИБОРЫ**
**APPLIED SURVEYING INSTRUMENTS**

| | | | |
|---|---|---|---|
| 913. | Чийгшил хэмжигч | **Р:**Психрометр<br>**E:**Psychrometer | Агаарын чийгшил хэмжүүрийн багаж |
| 914. | Усны гүний хэмжигч | **Р:**Глубомер<br>**E:**Tathometer/depth gauge | Усны гүний даралтын функц дээр суурилсан усны гүний хэмжүүрийн багаж |
| 915. | Гониометр | **Р:**Гониометр<br>**E:**Goniometer | Хатуу биетийн ирмэг хоорондын өнцөг хэмжүүрийн багаж |
| 916. | Гониометрийн ухаан | **Р:**Гониометрия<br>**E:**Goniometry | Хэмжилтийн аргыг судлах тригонометрийн ухааны хэсэг |
| 917. | Дигитайзер | **Р:**Дигитайзер<br>**E:**Digitizer | Дүрсийг тулган хуулж дараагийн шатны тоон хэлбэрт хөрвүүлэх багаж |
| 918. | Дигитайзлах /давхарлаж зуран тоон хэлбэрт оруулах | **Р:**Дигитализация<br>**E:**Digitize | Зурган мэдээллийг компьютерт тоон хэлбэрт хөрвүүлэх үйлдэл |
| 919. | Компенсатор | **Р:**Компенсатор<br>**E:**Compensator | Нивелирийн харах тэнхлэгийг автоматаар хэвтээ байрлалд оруулж байлгах зориулалтын хэрэгсэл |

| | | | |
|---|---|---|---|
| 920. | Реперийн бархаг | **Р:**Якорь репера<br>**E:**Benchmark anchor | Реперийн газарт байгаа бетон цутгамал болон яндангийн доод төгсгөл хэсэгт нь бэхэлсэн чагт |
| 921. | Инвар | **Р:**Инвар<br>**E:**Invar | -30$^0$-аас +100$^0$С хэмийн хязгаарт шугаман тэлэлтийн итгэлцүүр бараг өөрчлөгддөггүй төмөр (64%), цайр (36%)-ын хольцтой хайлш |
| 922. | Барометр | **Р:**Барометр<br>**E:**Barometer | Агаарын даралт хэмжүүрийн багаж |
| 923. | Агаарын даралт хэмжүүр-анероид | **Р:**Барометр-анероид<br>**E:**Aneroid barometer | Шингэнгүйгээр агаарын даралт хэмжүүрийн багаж |
| 924. | Агаарын хэм хэмжигч-пращ | **Р:**Термометр-пращ<br>**E:**Termometer-prash | Хээрийн нөхцөлд агаарын хэм хэмжих мөнгөн усны термометр |
| 925. | Мөнгөн усны барометр | **Р:**Барометр ртутный<br>**E:**Mercury barometer | Мөнгөн усны баганын өндрөөр агаарын даралт хэмжүүрийн багаж |
| 926. | Талбай хэмжүүр-Планиметр | **Р:**Планиметр<br>**E:**Planimeter | Газрын зураг, дэвсгэр зураг дээр хавтгай биетийн талбайн хэмжүүр |
| 927. | Дифференциал барометр | **Р:**Дифференциальный барометр<br>**E:**Differential barometer | Хоёр цэгийн агаарын даралтын зөрүүг тодорхойлох багаж |
| 928. | Анероид | **Р:**Анероид<br>**E:**Aneroid | Агаарын даралт хэмжүүрийн багажийн нэг төрлийн багаж |
| 929. | Статоскоп | **Р:**Статоскоп<br>**E:**Statoscope | Дифференциал барометрийн ажиллах зарчимд тулгуурлаж агаарын даралтын өөрчлөлтийг заах багаж |
| 930. | Анемометр | **Р:**Анемометр<br>**E:**Anemometer | Салхины хурд хэмжих багаж |
| 931. | Мөнгөн усны баганат барометр | **Р:**Чашечный барометр<br>**E:**Cistern-mercurial barometer | Дээд төгсгөл нь битүүмжлэгдсэн доод төгсгөл нь задгай шилэн гуурсыг мөнгөн устай аяган дотор босоогоор нь байрлуулсан барометр |
| 932. | Хронометр | **Р:**Хронометр<br>**E:**Chronometer | Хоногийн явалт нь нэн өндөр нарийвчлалтай цаг |

## ФОТОГРАММЕТР БА АГААРЫН ЗУРАГЛАЛ
## ФОТОГРАММЕТРИЯ И АЭРОФОТОСЬЁМКА
## PHOTOGRAMMETRY AND AERIAL SURVEY
### ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ
### ОБЩИЕ ПОНЯТИЯ
### GENERAL CONCEPTS

| | | | |
|---|---|---|---|
| 933. | Фотограмметр | **Р:**Фотограмметрия<br>**E:**Photogrammetry | Газрын гадарга, төрөл бүрийн объект биетүүдийн орон зайн байрлал хэмжээ хэлбэр дүрсийг тэдгээрийн гэрэл |

| | | | |
|---|---|---|---|
| | | | зургаар нь тодорхойлох үйл ажиллагаа |
| 934. | Аналитик фотограмметр | **Р:**Аналитическая фотограмметрия<br>**E:**Analytical photogrammetry, numerical photogrammetry | Аналог агаарын зургийг аналитик аргаар боловсруулах фотограмметрийн салбар |
| 935. | Аналог фотограмметр | **Р:**Аналоговая фотограмметрия<br>**E:**Analog photogrammetry | Аналог фотограмметрийн зургийг оптик-механикийн багажаар хэмжин боловсруулах фотограмметрийн салбар |
| 936. | Агаарын фотограмметр | **Р:**Аэрофотограмметрия<br>**E:**Aerial photogrammetry | Агаараас авсан фотограмметрийн зургийг хэмжин боловсруулах фотограмметрийн салбар |
| 937. | Хэрэглээний фотограмметр | **Р:**Прикладная фотограмметрия<br>**E:**Applied photogrammetry | Шинжлэх ухааны болон инженерийн зориулалтаар объектын тухай геометрийн болон утга зүйн мэдээллийг гарган авах фотограмметрийн салбар |
| 938. | Газрын фотограмметр | **Р:**Наземная фотограмметрия<br>**E:**Terrestrial photogrammetry | Газрын фотограмметрийн зургаар боловсруулалт хийх фотограмметрийн салбар |
| 939. | Сансрын фотограмметр | **Р:**Космическая фотограмметрия<br>**E:**Space photogrammetry | Сансрын нисэх төхөөрөмжөөр авсан фотограмметрийн зургаар боловсруулалт хийх фотограмметрийн салбар |
| 940. | Тоон фотограмметр | **Р:**Цифровая фотограмметрия<br>**E:**Digital photogrammetry | Тоон фотограмметрийн зургийг аналитик аргаар боловсруулах фотограмметрийн салбар |
| 941. | Стереофото-грамметр | **Р:**Стерео-фотограмметрия<br>**E:**Stereophotogrammetry | Объектын хоёр ба түүнээс олон байрлалаас авсан гэрэл зургуудыг нэгэн зэрэг боловсруулах фотограмметрийн салбар |
| 942. | Стерео байр зүйн зураглал | **Р:**Стереотопо-графическая съемка<br>**E:**Stereotopographic mapping | Байр зүйн зураг, дэвсгэр зургийн хүрээвч (контур)-ийн хэсгийн гадаргын дүрсийг агаарын байр зүйн зургаас гарган авах агаарын байр зүйн зураглал |
| 943. | Фото байр зүй | **Р:**Фототопография<br>**E:**Phototopography | Гэрэл зураглалын материалаар байр зүйн зураг, дэвсгэр зураг зохиох техникийн салбар |

| | | | |
|---|---|---|---|
| 944. | Фототриангуляц | **Р:**Фототриангуляция<br>**E:**Aerotriangulation | Тусгагийн цацрагийн гэрлийн зохих огтлолцол дээр суурилагдсан фотограмметрийн өтгөрүүлэлтийн арга |
| 945. | Фотограмметрийн зураглалын суурь | **Р:**Базис фотограмметрии (фотограмметрической съемки)<br>**E:**Base (photogrammetric survey) | Стерео хос зургийн оптик тусгагийн төвүүдийг холбож буй шулууны урт |
| 946. | Фотограмметрийн багаж | **Р:**Фотограмметрический прибор<br>**E:**Photogrammetric instrument | Гэрэл зургийн хэмжилтээр объектыг танин мэдэх, түүний хэмжээ, байрлалыг тодорхойлох багаж |
| 947. | Дүрс тэмдэглүүр, Стереограф | **Р:**Стереограф<br>**E:**Stereograph | Агаарын зургаар байр зүйн зургийн эх бэлтгэх, орон зайн фотограмметрийн сүлжээ байгуулах өндөр нарийвчлалын фотограмметрийн багаж |
| 948. | Дүрс адилтгуур, Стереокомпаратор | **Р:**Стереокомпаратор<br>**E:**Stereocomparator | Стерео хос зургаар зурагласан гадаргын орон зайн загвар үйлдэх, үүгээр гурван солбицлыг хэмжих, зураглалын үеийн агаарын зургийн харилцан чиглүүлгийн элементүүдийг бодох стереофотограмметрийн багаж |
| 949. | Дүрс хэмжигч, Стереометр | **Р:**Стереометр<br>**E:**Stereometer | Газрын, агаарын, сансрын зургаар стерео хос дүрс үүсгэж, дүрслэгдсэн объектын төрөл бүрийн хэмжилт хийх стереофотограмметрийн багаж |
| 950. | Статоскоп | **Р:**Статоскоп<br>**E:**Statoscope | Агаарын зураглалын явц дахь зураг авах өндрийн өөрчлөлтийг тодорхойлох багаж бөгөөд агаарын нислэгийн үеийн агаарын даралтын өчүүхэн өөрчлөлтийг гэрэл зургийн хальсан дээр бичих дифференциал барометрийн нэгэн төрөл |
| 951. | Дүрс тусгагуур, Стереопроектор | **Р:**Стереопроектор<br>**E:**Stereoprojector | Тусгажуулах гэрлийн холбоосоор объектын загвар дүрсийг байгуулах стереофотограмметрийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | өндөр нарийвчлалын энгийн багаж |
| 952. | Дүрс харуур, Стереоскоп | **Р:**Стереоскоп<br>**E:**Stereoscope | Хоёр өөр байрлалаас авсан стерео хос зургаар (гурван хэмжээстийн) объект буюу гадаргын ээлэхүүн дүрсийг харах оптик багаж |
| 953. | Фототрансформатор | **Р:**Фототрансформатор<br>**E:**Phototransformer | Гэрэл зургийн дүрсийг өгөгдсөн масштабд хэвтээ тусгагд шилжүүлэх фотограмметрийн багаж |
| 954. | Аналитик стереофото-грамметрийн багаж | **Р:**Аналитический стереофото-грамметрический прибор<br>**E:**Analytical stereophotogrammetric instrument | Компьютерыг ашиглаж аналитик аргаар зураглалын объектын дүрсний загварыг бий болгох стереофотограмметийн багаж |
| 955. | Аналог стереофото-грамметрийн багаж | **Р:**Аналоговый стерео-фотограмметрический прибор<br>**E:**Analog Stereo Photogrammetric instrument | Оптикийн, оптик-механикийн, механик багажуудыг ашиглан аналог аргаар зураглалын объектын дүрсний загварыг бий болгох стереофотограмметийн багаж |
| 956. | Нислэгийн бичлэг | **Р:**Аэропрофилограф<br>**E:**Airborne profile recorder | Агаарын нислэгийн замналыг автоматаар бичигч |
| 957. | Тоон фотограмметрийн багаж | **Р:**Цифровой фотограмметрический прибор<br>**E:**Digital photogrammetric instrument | Гэрэл зургийн дүрсийг тоон хэлбэрт шилжүүлэх фотограмметрийн багаж |
| 958. | Зайнаас тандан судалгаа | **Р:**Дистанционное зондирование (ДЗ)<br>**E:**Remote sensing | Дэлхийн газрын гадаргын тухай мэдээллийг сансраас ажиглах, хэмжих замаар эсвэл эх газар, далай тэнгис, агаараас ойсон цахилгаан соронзон долгионыг ашиглах замаар байгалийн үзэгдэл, нөөц баялгийг судлах, тэдгээрийн өөрчлөлтийг тогтоох зэрэг олон төрлийн явц үйл явдлын тухай мэдээллийг олж авах үйл ажиллагаа |
| 959. | Зайнаас тандан судалгааны өгөгдөл | **Р:**Данные дистанционного зондирования, ДДЗ<br>**E:**Remote sensing data | Сансрын хөлөг, объект дээр байрлуулсан зайнаас тандан судлах аппаратын тусламжтайгаар эсвэл |

| | | | |
|---|---|---|---|
| | | | тэдгээрийн дамжуулж буй, цахилгаан соронзон дохио, гэрэл зургийн хальс, соронзон тууз зэрэг бусад аргаар Дэлхийд ирүүлсэн анхдагч материалыг боловсруулах замаар ашиглах анхдагч өгөгдлүүд |

## ФОТОГРАММЕТРИЙН БОЛОВСРУУЛАЛТ ФОТОГРАММЕТРИЧЕСКАЯ ОБРАБОТКА PHOTOGRAMMETRIC PROCESSING

| | | | |
|---|---|---|---|
| 960. | Аналитик фотограмметрийн боловсруулалт | **P:**Аналитическая фотограмметрическая обработка **E:**Analytical photogrammetric processing | Гэрэл зургийн цэгийн дүрсний солбицол тодорхойлоход оптик-механикийн, харин объектын загварыг байгуулахын тулд тооцоолон бодох техник ашиглах үйлдвэрлэлийн арга |
| 961. | Аналог фотограмметрийн боловсруулалт | **P:**Аналоговая фотограмметрическая обработка **E:**Analog photogrammetric processing | Гэрэл зургийн дүрслэлийн цэгүүдийн солбицол тодорхойлох, объектын геометр загвар байгуулахын тулд оптик-механикийн багаж ашиглах үйлдвэрлэлийн арга |
| 962. | Фотограмметрийн өтгөрүүлэлт (геодезийн сүлжээний) | **P:**Фотограмметрическое сгущение **E:**Aerotriangulation bridging | Гэрэл зургийн хэмжилтээр байр зүйн тулгуур цэгүүдийн геодезийн солбицол тодорхойлох арга |
| 963. | Фотограмметрийн өтгөрүүлэлт (геодезийн тулгуур сүлжээний) | **P:**Фотограмметрическое сгущение (опорной геодезической сети) **E:**Photogrammetric thickening (geodetic reference network) | Фотограмметрийн зургийн дараагийн үе шатны боловсруулалт хийхэд зориулсан фотограмметрийн зураглалын объектын нэмэлт цэгүүдийн орон зайн солбицлыг тодорхойлох арга |
| 964. | Фототриангуляцийн сүлжээний хөрвүүлэг | **P:**Редуцирование фототриангуляционных сетей **E:**Reduction of phototriangulation networks | Зохиомол масштабд гүйцэтгэсэн фототриангуляцийн сүлжээг өгөгдсөн масштабд шилжүүлэх арга |
| 965. | Фотограмметрийн зургийн чиглүүлэг | **P:**Ориентирование (фотограмметрического) снимка **E:**Orientation (photogrammetric) photo | Фотограмметрийн зураг авах агшны байрлал, чиглэлийн утгуудыг орон зай дахь өөр ямар нэгэн системтэй харьцангуйгаар тодорхойлох үйл ажиллагаа |
| 966. | Харилцан чиглүүлэг | **P:**Взаимное ориентирование | Стерео хос фотограмметрийн зургийн нэгийг нөгөө зурагтай |

| | | | |
|---|---|---|---|
| | | (фотограмметрических) снимков<br>**E:**Relative orientation (photogrammetric photos) | харьцангуйгаар чиглүүлэг хийх арга |
| 967. | Аналитик аргаар харилцан чиглүүлэг хийх | **Р:**Взаимное ориентирование аналитическим методом<br>**E:**Analytical relative orientation | Стерео хос фотограмметрийн зургийн нэгийг нөгөө зурагтай харьцангуйгаар аналитик аргаар чиглүүлэг хийх арга |
| 968. | Гэрэл зургийн харилцан чиглүүлгийн элементүүд | **Р:**Элементы взаимного ориентирования фотоснимков<br>**E:**Elements of relative orientation | Газрын гадаргын хос зургийн орон зайн харилцан байрлалыг илэрхийлэгч хэмжигдэхүүнүүд |
| 969. | Харилцан чиглүүлгийн элементүүд | **Р:**Элементы взаимного ориентирования (фотограмметрических) снимков<br>**E:**Elements of relative (photogrammetric) orientation | Фотограмметрийн стерео хос зургийн нэг зургийн байрлалыг нөгөө зурагтай харьцангуйгаар байрлалыг нь тодорхойлох геометр үзүүлэлт |
| 970. | Гадаад чиглүүлэг | **Р:**Внешнее ориентирование (фотограмметрического) снимка<br>**E:**External orientation (photogrammetric photo) | Фотограмметрийн зураглалын объектын солбицолтой харьцангуйгаар фотограмметрийн зургийн чиглүүлэг хийх арга |
| 971. | Гадаад чиглүүлгийн элемент | **Р:**Элементы внешнего ориентирования (фотограмметрического снимка)<br>**E:**Element of external orientation (photogrammetric picture) | Зураглалын үед фотограмметрийн зураглалын объекттой харьцангуйгаар фотограмметрийн зургийн байрлал, чиглэлийг тодорхойлох геометр үзүүлэлт |
| 972. | Гадаад чиглүүлгийн шугаман элементүүд | **Р:**Линейные элементы внешнего ориентирования (фотограмметрического) снимка<br>**E:**Linear elements of external orientation (photogrammetric) the photo | Фотограмметрийн зураглалын объектын солбицлын тогтолцоо дахь фотограмметрийн зургийн оптик тусгагийн төвийн солбицол |
| 973. | Дотоод чиглүүлгийн элемент | **Р:**Элемент внутреннего ориентирования (фотограмметрического) снимка | Фотограмметрийн зургийн оптик тусгагийн төвтэй харьцангуйгаар түүний байрлалыг тодорхойлох фотограмметрийн зургийн геометр үзүүлэлт.*Тайлбар:* |

| | | | |
|---|---|---|---|
| | | **E:**Element of internal orientation (photogrammetric photo) | *Дотоод чиглүүлгийн элементэд зураглалын аппаратын фокусын зай, гэрэл зургийн солбицлын тогтолцоо дахь фотограмметрийн гэрэл зургийн гол цэгийн солбицол хамаарна.* |
| 974. | Гадаад чиглүүлгийн өнцгийн элемент | **Р:**Угловой элемент внешнего ориентирования (фотограмметрического) снимка<br>**E:**Angular element of external orientation (photogrammetric photo) | Фотограмметрийн зураглалын объектын солбицлын тогтолцоонд фотограмметрийн зургийн өнцгийн чиглүүлгийг тодорхойлж буй үзүүлэлтийн нэг. *Тайлбар: Чиглүүлгийн дээрх үзүүлэлтэд зарим тохиолдолд фотограмметрийн гэрэл зургийн налуугийн өнцөг ба эргэлтийн өнцгийн өсөлтийг ашиглана.* |
| 975. | Фотограмметрийн хосолмол боловсруулалт | **Р:**Комбинированная фотограмметрическая обработка<br>**E:**The combined photogrammetric processing | Фотограмметрийн аргаар дүрс боловсруулах олон аргуудыг хамтатгах үйлдвэрлэлийн арга |
| 976. | Стерео (гурван хэмжээст) гэрэл зураг | **Р:**Стереоскопический снимок<br>**E:**Stereoscopic image/stereo image/stereo photo | Объектын дүрсийг 2 өөр байрлалаас авсан давхцал бүхий гэрэл зураг |
| 977. | Фотограмметрийн зургийн тусгагийн (оптикийн) төв | **Р:**Центр (оптического) проектирования (фотограмметрического снимка)<br>**E:**(optical) Design Center (photogrammetric image) | Фотограмметрийн зураглалд ашиглаж байгаа зураглалын аппаратын объективын зангилаа цэг. *Тайлбар: Объективын арын ба урдах зангилаа цэг гэж ангилна.* |
| 978. | Фотограмметрийн зургийн үндсэн цэг | **Р:**Главная точка (фотограмметрического) снимка<br>**E:**Main point (photogram-metric) photo | Фотограмметрийн зургийн хавтгайн цэг, зураглал авах аппаратын оптик тэнхлэгтэй огтлолцох цэг |
| 979. | Фотограмметрийн огтлол | **Р:**Фотограмметрическая засечка<br>**E:**Photogrammetric crossing/intersection | Агаарын зургаар газрын гадаргын цэгүүдийн солбицол тодорхойлох, агаарын зургийн гадаад чиглүүлэг хийх арга |
| 980. | Газрын фотограмметрийн зураг | **Р:**Наземный (фотограмметрический) снимок | Газрын цэгээс эсвэл хөдөлгөөнт газрын зураглалын |

| | | | |
|---|---|---|---|
| | | **E:**Ground (photogram-metric) photo | техникээр авсан фотограмметрийн зураг |
| 981. | Фотограмметрийн зургийн цэгийн солбицол | **P:**Координаты точки (фотограмметрического) снимка<br>**E:**Point coordinates (photogram-metric photo) | Фотограмметрийн зургийн солбицол дахь цэгүүдийн дүрслэлийн солбицол |
| 982. | Фотограмметрийн зургийн надир цэг | **P:**Точка надира (фотограмметрического) снимка<br>**E:**Point nadir (photogrammetric) photo | Фотограмметрийн зургийн хавтгай, фотограмметрийн зургийн оптик тусгагийн төвийг дайрч буй эгц цацрагтай огтлолцох цэг |
| 983. | Фотограмметрийн зургийг өөрчлөн хувиргах | **P:**Преобразование фотограмметрического снимка<br>**E:**Transformation of the photogrammetric photo | Фотограмметрийн зургийн дүрсийг өгөгдсөн тусгаг ба масштабд хувиргах арга |
| 984. | Фотограмметрийн тулгуур цэг | **P:**Опорная точка (фототопография)<br>**E:**Reference point (photo-topography) | Фотограмметрийн байгуулалт хийхэд тулгуур болох геодезийн солбицолтой цэг |
| 985. | Фотограмметрийн өргөн дэлгэцийн зураг | **P:**Панорамный (фотограмметрический) снимок<br>**E:**Panoramic (photogrammetric) photo | Дүрслэгдэх элементүүд нь бортгон гадаргуу дээр төвийн тусгагаар хэлбэршдэг сканер (фотограмметрийн) зураг |

## АГААРЫН БАЙР ЗҮЙ, АГААРЫН ЗУРАГЛАЛ
## АЭРОФОТОТОПОГРАФИЯ И АЭРОФОТОСЪЁМКА
## AEROPHOTOTOPOGRAPHY AND AERIAL PHOTOGRAPHY

| | | | |
|---|---|---|---|
| 986. | Агаарын байр зүй | **P:**Аэрофототопография<br>**E:**Aero phototopography | Агаарын зураглалын материалаар байр зүйн ба дэвсгэр зураг гаргах аргыг судалж боловсруулах байр зүйн ухааны нэгж |
| 987. | Агаарын зургийн аппарат (АФА) | **P:**Аэрофотоаппарат (АФА)<br>**E:**Aerial camera (AFA) | Агаар, сансрын техникээс газрын гадаргуун зураг авах оптик-механикийн эсвэл оптик-цахим аппарат, бөгөөд авах зургийн хэмжээ, фокусын зайгаар үзүүлэлт нь өөр өөр байна |
| 988. | Агаарын зураглалын аппаратын удирдлагын товчлуур | **P:**Пульт управления аэрофотоаппарата<br>**E:**Aerial camera control panel | Агаарын зураглалын аппаратыг зайнаас удирдах, хянах хэрэгсэл |
| 989. | Агаарын зураглалын | **P:**Фокусное расстояние аэрофотокамеры | Агаарын зураглалын аппаратын объективын арын зангилаа цэгээс аппаратын |

| | | | |
|---|---|---|---|
| | аппаратын (АФА) голлолтын зай | **E:**Aerial camera focal length | хальс барих хавтгайд буулгасан перпендикулярын урт эсвэл АФА-ын голлолтын зай энэ аппаратын объективын голлолтын зайтай тэнцүү хэмжигдэхүүн |
| 990. | Агаарын зураглалын аппаратын голлол (фокус) тааруулах | **P:**Фокусировка аэрофотокамеры<br>**E:**Focusing the aerial camera | Гэрэл зургийн тод дүрслэлийн хавтгайг, агаарын зургийн гэрэл мэдрэмтгий материалын хавтгайтай давхцуулах арга |
| 991. | Өргөн дэлгэцийн агаарын зураглалын аппарат | **P:**Панорамный аэрофотоаппарат<br>**E:**Panoramic aerial camera | Зургийн хальс нь бортгон гадаргуу дээр байрлаж хальсан доор байрлуулсан нарийн зурвасаар тасралтгүй үргэлжлүүлэн зураг авах агаарын зураглалын аппарат |
| 992. | Нарийн завсарт агаарын зураглалын аппарат | **P:**Щелевой аэрофотоаппарат<br>**E:**Continuous strip camera | Зургийн хальсан дор байрлуулсан завсрыг ашиглан тасралтгүйгээр үргэлжлүүлэн зураг авах агаарын зургийн аппарат |
| 993. | Өргөн өнцөгтэй объектив | **P:**Широкоугольный объектив<br>**E:**Wide-angle lens | Дурангийн харах талбай 60-аас их өнцөгтэй объектив.<br>*Тайлбар:Дурангийн хэвийн харах талбайн өнцөг 15-60 байдаг.* |
| 994. | Хувьсах голлолын зайтай объектив | **P:**Объектив с переменным фокусным расстоянием<br>**E:**Lens with variable focal length | Голлолын зай нь аажмаар эсвэл огцом өөрчлөгддөг объектив |
| 995. | Урт голлолтой объектив | **P:**Длиннофокусный объектив<br>**E:**Long focus lens | 1000 мм-ээс урт голлолтой объектив.*Тайлбар:байр зүйн зураглалын объективүүд:Богино фокустай 150 мм-ээс ихгүй, дунд фокустай 150-300 мм, урт фокустай 300 мм-ээс их* |
| 996. | Объективын өрц | **P:**Диафрагма объектива<br>**E:**Lens aperture | Объективын гадна эсвэл дотно суурилуулах гэрлийн тусгалын хэмжээг зургийн хальсан дээр тохируулах хэрэгсэл |
| 997. | Агаарын зураглалын аппаратын объективын хэсэг | **P:**Объективная часть аэрофотокамеры<br>**E:**Objective part aerial camera | Нэг буюу хэд хэдэн объектив угсарсан агаарын зураглалын аппаратын хэсэг |
| 998. | Агаарын зураглал | **P:**Аэрофотосьёмка<br>**E:**Aerial photography | Нисэх онгоц, нисэх төхөөрөмжөөс газрын |

| | | | |
|---|---|---|---|
| | | | гадаргын гэрэл зураг авах үйл ажиллагаа |
| 999. | Агаарын байр зүйн дэвсгэр зураглал | **Р:**Плановая (топографическая) аэрофотосъемка<br>**Е:**Vertical photography | Гэрэл зургийн аппаратын оптик тэнхлэгийн эгц босоо байрлал $3^0$-аас ихгүй хазайлттай үед авсан байр зүйн дэвсгэр зураглал |
| 1000. | Агаарын алслал (байр зүйн) зураглал | **Р:**Перспективная (топографическая) аэрофотосъемка<br>**Е:**Oblique photography | Агаарын зураглалын аппаратын оптик тэнхлэг эгц босоо тэнхлэгээс $3^0$-аас их хазайлтын үед авсан байр зүйн агаарын зураглал |
| 1001. | Агаарын өргөн дэлгэцийн зураглал | **Р:**Панорамное аэрофотографирование<br>**Е:**Panoramic aero photography | Тусгагийн төвийг, тусгажуулах цацраг тасралтгүй тойрон эргэлдэх үед төвийн тусгагийн хуулийн дагуу газрын гадаргын дүрс хэсэг хэсэг дүрсийн нийлбэр болох агаараас зураглах үйл ажиллагаа |
| 1002. | Хосолмол зураглал | **Р:**Комбинированная аэрофототопографическая съемка<br>**Е:**The combined aero photosurvey | Хүрээвчийн зураг эсвэл дэвсгэр зургийг агаарын байр зүйн зураглалын аппаратаар авах, харин гадаргын дүрсийг газрын хэмжилтээр авах агаарын байр зүйн зураглал |
| 1003. | Замналын зураглал | **Р:**Маршрутная аэрофотографическая съемка<br>**Е:**Strip aerial photography | Нисэх төхөөрөмжөөр төлөвлөсөн замналын дагуу агаараас газрын гадаргуун зурвас зураглал авах үйл ажиллагаа |
| 1004. | Олон замналын зураглал | **Р:**Многомаршрутное аэрофотографирование<br>**Е:**Multiroute aero photography | Агаарын нисэх техник хэрэгслийн нэг чиглэлийн дагуух нислэгээр олон замналын зураглал авах үйл ажиллагаа |
| 1005. | Дулааны агаарын зураглал | **Р:**Воздушная тепловая съемка<br>**Е:**Airborne thermal imaging survey | Хот суурин газрын орон сууц барилгын дулааны алдагдлыг илрүүлэх агаараас зураглах арга |
| 1006. | Агаараас зураг авах завсар | **Р:**Интервал аэрофотографирования<br>**Е:**Aero photography interval | Агаараас замналын дагуу зураг авахад агаарын зургийн дагуугийн давхцалын хэмжээг гаргахын тулд зураг авах аппаратын дараалсан кадр хоорондын барилтын хугацаа |
| 1007. | Агаарын зураглалын масштаб | **Р:**Масштаб аэрофотографирования<br>**Е:**Aero photography scale | Агаарын зургийн аппаратын голлолтын зайг гэрэл зураг авах алслалд харьцуулсан харьцаа |

| | | | |
|---|---|---|---|
| 1008. | Зураг авах суурь | **Р:**Базис фотографирования<br>**E:**Photographic basis | Агаараас болон газрын гадаргын гэрэл зураг авсан зэрэгцээ хоёр цэгүүдийн хоорондын зай |
| 1009. | Агаарын зураглалын алслал | **Р:**Дальность аэрофотографирования<br>**E:**Aero photography range | Агаараас зураг авах аппаратын объективын өнцгийн өврийн цэгээс аппаратын оптик тэнхлэгийн дагуу газрын гадаргын зураг авах хэсгийн дундаж хавтгай хүртэл зай |
| 1010. | Агаарын зургийн холболтын хээрийн ажил | **Р:**Полевая привязка топографических аэроснимков<br>**E:**Field preparation of topographic images | Агаарын байр зүйн зураг дээр объектыг таньж илрүүлэх, тэдгээрийн солбицол, өндрийг тодорхойлох технологи |
| 1011. | Байр зүйн хосолмол зураглал | **Р:**Комбинированная фототопографическая съемка<br>**E:**The combined photosurvey | Газрын объектын тухай мэдээллийг байр зүйн гэрэл зургаар, харин гадаргын тухай мэдээллийг газрын хэмжилтээр авах байр зүйн зураглал |
| 1012. | Агаарын зураглалын аппаратын оптик тэнхлэг | **Р:**Оптическая ось аэрофотоаппарата<br>**E:**Optical axis aerial camera | Агаарын зургийн гол цэгийг объективын арын зангилаа цэгтэй холбож буй шулуун |
| 1013. | Агаарын зураглалын аппаратын оптик систем | **Р:**Оптическая система аэрофотоаппарата<br>**E:**Optical system aerial camera | Агаарын зураглалын аппарат дотор оптик дүрс үүсгэхэд зориулсан оптик элементүүдийн нэгдэл |
| 1014. | Агаарын зураглалын аппаратын харах өнцөг | **Р:**Угол поля зрения аэрофотокамеры<br>**E:**Aerial camera field of view | Агаарын зураглалын аппаратын харах талбайн хэмжээнд газрын гадаргын дүрс байгуулах өнцөг |
| 1015. | Ортофото зураг | **Р:**Ортофотоснимок<br>**E:**Orthophoto image | Агаар, сансрын гэрэл зургийн газрын гадарга болон камерын линзний геометрийн гажилтыг тэгш өнцгийн тусгагаар засаж үүсгэсэн ижил масштабтай гэрэл зургийн дүрс |
| 1016. | Байр зүйн гэрэл зургийг ортофото зурагт хувиргах | **Р:**Ортофототранс-формирование (топографического фотоснимка)<br>**E:**Orthophoto transformation | Байр зүйн гэрэл зургийн анхдагч тусгагаас тэгш өнцгийн тусгагд шилжүүлэн хувиргах фотограмметрийн боловсруулалтын арга |
| 1017. | Анаглиф, сөлжир | **Р:**Анаглифия<br>**E:**Anaglyph | Туслах гэрлүүдийг ашиглаж стерео загвар гаргаж авах фотограмметрийн арга |

| | | | |
|---|---|---|---|
| 1018. | Анаглиф зураг | **P:**Анаглифический снимок<br>**E:**Anaglyphic photograph | Стереохос зургийн нэгийг өнгөөр, нөгөөг нь бага зэрэг шилжүүлэн нэг дэвсгэр дээр өөр өөр өнгөөр буулгаж гаргасан зураг |
| 1019. | Дүрсний масштаб | **P:**Масштаб изображения<br>**E:**Image scale | Агаарын зураг дээрх шугамын уртыг түүнд харгалзах газар дээрх тавилын урттай харьцуулсан харьцаа |
| 1020. | Аналитик сүлжээ | **P:**Аналитическая сеть<br>**E:**Analytic network | Агаарын зургийн цэгүүдийн хэмжилтээр солбицол тодорхойлогдсон цэгүүдийн сүлжээ |
| 1021. | Агаарын гэрэл зураг | **P:**Аэрофотоснимок<br>**E:**Air photograph | Нисэх онгоц болон бусад нисэх төхөөрөмжөөс авсан газрын гадаргын гэрэл зураг |
| 1022. | Хөндлөнгийн параллакс | **P:**Параллакс поперечный<br>**E:**Parallax ross | Агаараас авсан зэргэлдээ орших хоёр гэрэл зураг дээр байгаа нэг нэрийн цэгүүдийн ординатын зөрүү |
| 1023. | Сансрын зураг | **P:**Космический снимок<br>**E:**Satellite image | Хиймэл дагуулаас зураглалын системийн аппаратаас авсан газрын гадарга, үзэгдэл, биет юмсын гэрэл зураг |
| 1024. | Сансрын байр зүйн гэрэл зураг | **P:**Космический (топографический) фотоснимок<br>**E:**Space (topographic) photograph | Сансараас байр зүйн зураглал үйлдэх зорилгоор авсан гэрэл зураг |
| 1025. | Сансрын зургийн газар зүйн холболт | **P:**Географическая привязка космических снимков<br>**E:**Geographic reference of satellite images/georeferencing | Сансрын зураг дээр дүрслэгдсэн элементүүдийн газар зүйн солбицол бодох үйлдэл |
| 1026. | Агаарын зургийн масштаб | **P:**Масштаб аэроснимка<br>**E:**Photograhic scale | Агаарын зураг дээрх шугамын уртыг газар дээрх уртад харьцуулсан харьцаа |
| 1027. | Фотограмметрийн алслал зураг | **P:**Перспективный (фотограмметрический) снимок<br>**E:**Oblique(photogrammetri) photograph | Агаарын зураглалын аппаратын оптик тэнхлэг $3^0$-аас их хазайлтын үед авсан фотограмметрийн кадр гэрэл зураг |
| 1028. | Агаарын тэгш өнцгийн зураг | **P:**Аэроснимок ортогнальный<br>**E:**Orthogonal aerial | Анх авсан гэрэл зургийг тэгш өнцгийн тусгагд хувиргасан газрын гадаргын зураг |
| 1029. | Агаарын хэвтээ зураг | **P:**Аэроснимок горизонтальный<br>**E:**Horizontal aerial photograph | Агаарын зураглалын аппаратын оптик тэнхлэг нь яг эгц босоо байрлалтай байх үед авсан агаарын зураг |

| | | | |
|---|---|---|---|
| 1030. | Агаарын солонгон бүсчлэлийн зураг | **P:**Спектрозональный аэрофотоснимок<br>**E:**Spectral Aerial photograph | Газрын гадаргын объектыг урьдчилан төлөвлөсөн солонгон бүсчлэлээр авсан өнгөт зураг |
| 1031. | Агаарын зургийн ашигтай талбай | **P:**Полезная площадь аэроснимка<br>**E:**Useful area aerial photograph | Зэргэлдээ орших агаарын зургуудтай давхацсан давхцалын дундуур татсан шугамаар хязгаарлагдсан талбай |
| 1032. | Агаарын зургийн үндсэн цэгүүд | **P:**Основные точки аэроснимка<br>**E:**Main points of the aerial photograph | Агаарын зургийн фотограмметрийн боловсруулалтын ажилд ашигладаг хэвтээ хавтгай, зургийн талбай, агаарын зургийн төв цэг, төвийн тусгаг, үндсэн босоо хавтгай, агаарын зургийн гажилтын цэгүүд |
| 1033. | Агаарын зургийн төвийн цэг | **P:**Центральная точка аэроснимка<br>**E:**Central point of aerial photograph | Солбицлын цэгээс тодорхой радиусаар татсан дугуйн хүрээн дотор багтах дурын цэгүүд |
| 1034. | Агаарын зургийн солбицлын цэг | **P:**Координатная точка аэроснимка<br>**E:**Coordinate point of the aerial photograph | Агаарын зургийн харилцан эсрэг орших солбицлын тэмдэгтүүдийг холбоход тэдгээрийн огтлолоор үүсэх цэг |
| 1035. | Сканер (фотограм-метрийн) зураг | **P:**Сканерный (фотограмметрический) снимок<br>**E:**Scanner (photogrammetric) image | Дүрслэгдсэн элемент бүр цаг хугацааны янз бүрийн агшинд өөр хоорондоо ялгагдах гадаад чиглүүлгийн элемент бүхий фотограмметрийн гэрэл зураг.*Тайлбар: Фотограмметрийн сканер зургийг ангавт, дэлгэцийн, оптик-механикийн зэрэг агаарын зураглалын аппаратаар авна.* |
| 1036. | Агаарын зургийн гажилтгүй цэг | **P:**Точка нулевых искажений аэроснимка<br>**E.**Equal-angle point of photograph | Агаарын зураглалын аппаратын оптик тэнхлэгийн хазайх өнцгийн биссектрис, гол босоо шулуунтай огтлолцох цэг |
| 1037. | Оптик тусгагийн төв (байр зүйн зургийн) | **P:**Центр оптического проектирования (топографического фотоснимка)<br>**E:**Center of optical design (topographical picture) | Фототопографийн зураглалд ашиглаж байгаа зураглалын аппаратын объективын зангилаа цэг |
| 1038. | Агаарын зургийн гол цэг | **P:**Главная точка аэрофотоснимка | Агаарын зургийн тусгалын төвийн цэгээс зургийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | **E:**Principal point of the aerial photograph | хавтгайд перпендикуляр татахад үүссэн цэг |
| 1039. | Гэрэл зургийн гол цэг | **Р:**Главная точка фотоснимка<br>**E:**Principal point photograph | Тусгагийн төвийн цэгээс агаарын зургийн хавтгайд перпендикуляр татахад үүссэн цэг |
| 1040. | Дагуугийн займраа-параллакс | **Р:**Продольный параллакс (фототопография)<br>**E:**Horizontal parallax | Байр зүйн гэрэл зургийн хос дүрс үүсгэж байгаа газрын гадаргын зохих цэгүүдийн абцисс тэнхлэгийн зөрүү |
| 1041. | Хөндлөн займраа-параллакс | **Р:**Поперечный параллакс<br>**E:**Vertical parallax | Стерео хос гэрэл зураг үүсгэж байгаа зохих цэгүүдийн ординат тэнхлэг зөрүү |
| 1042. | Зүймэл зураг | **Р:**Накидной монтаж фотоснимков местности<br>**E:**Provisional layout composition | Гэрэл зургуудыг өөр хооронд нь давхцуулан зах нийлүүлж эвлүүлсэн зураг |
| 1043. | Агаарын зургийн давхцал | **Р:**Перекрытие (фотограмметрических снимков, аэрофото-снимков)<br>**E:**Overlap, lap | Зэргэлдээ байрлалаас авсан гэрэл зургууд дээрх ерөнхий дүрслэгдсэн хэсэг |
| 1044. | Гэрэл зургийн сөргүү хальс | **Р:**Негатив<br>**E:**Negative | Эсрэг дүрсийг харуулсан гэрэл зургийн хальс |
| 1045. | Тодруулалт /тайлал | **Р:**Дешифрирование<br>**E:**Interpretation | Аливаа мэдээлэл, зурсан зураг, объектын гэрэл зургийн ойлгомжгүй зүйлийг тайлах үйлдэл |
| 1046. | Тодруулалтын шинж тэмдэг | **Р:**Дешифровочные признаки (фототопография)<br>**E:**Interpretation signs | Байр зүйн тодруулалт хийхэд ашиглах объектын гэрэл зургийн дүрсний онцлог шинж тэмдгүүд |
| 1047. | Тодруулалтын шууд бус шинж тэмдэг | **Р:**Дешифровочные признаки косвенные<br>**E:**Interpretation indirect signs | Газрын гадаргын объектууд хоорондын харилцан холбоос болон бусад объектын нөлөөгөөр нэг объектын чанарын өөрчлөлтийг тооцох үзүүлэлтүүд |
| 1048. | Тодруулалтын шууд шинж тэмдэг | **Р:**Дешифрировочные признаки прямые<br>**E:**Interpretation direct signs | Объектын шууд шинж тэмдгийн чанар, үзүүлэлтээр тодруулалт хийх ажиллагаа |
| 1049. | Байр зүйн тодруулалт | **Р:**Топографическое дешифрирование<br>**E:**Topographical interpretation | Газрын элементүүдийг байр зүйн зурагт буулгахад тэдгээрийн хил хязгаар, тоон мэдээллийг оруулах үйл ажиллагаа |
| 1050. | Гэрэл зургийн тодруулалт | **Р:**Дешифрирование фотоснимка | Гэрэл зураг дээр дүрслэгдсэн объектыг илрүүлэх, танин мэдэх,чанарын ба тоон |

| | | | |
|---|---|---|---|
| | | **E:**Photo/image interpretation | үзүүлэлтийг тодорхойлох үйл ажиллагаа |
| 1051. | Сансрын гэрэл зургийн тодруулалт | **P:**Дешифрирование космических снимков<br>**E:**Interpretation of space images | Гэрэл зураг дээр объект хоорондын дүрслэгдэх шинж тэмдэг, үзүүлэлтээр ялгагдах объектуудыг сансраас авсан зураг дээр илрүүлэх, таних ажиллагаа |
| 1052. | Агаарын зургийн хээрийн тодруулалт | **P:**Полевое дешифрирование (топографического фотоснимка)<br>**E:**Field interpretation (topographic photo) | Хээрийн ажлын судалгааны явцад хийх агаарын зургийн тодруулалт |
| 1053. | Суурин тодруулалт | **P:**Камеральное дешифрирование<br>**E:**Cameral interpretation | Суурин аргаар объектын байр зүйн зургийн тодруулалт хийх үйлдэл |
| 1054. | Хосолмол тодруулалт | **P:**Комбинированное дешифрирование<br>**E:**The combined interpretation | Байр зүйн ба гэрэл зургийн хээрийн ба суурин тодруулалтыг хослуулан хэрэглэх арга |
| 1055. | Тодруулалтын жишиг (байр зүйн гэрэл зураг) | **P:**Эталон дешифрирования<br>**E:**Standard interpretation (topographic photo) | Өвөрмөц тогтоцтой газрын гадаргын хээрийн тодруулалт хийсэн жишиг гэрэл зургийг ашиглан бусад гэрэл зураг дээр дүрслэгдсэн тухайн газрын төрх байдлыг суурин аргаар тодруулах үйлдэл |
| 1056. | Байр зүйн гэрэл зургийн хээрийн холболт | **P:**Полевая подготовка (топографических фотоснимков)<br>**E:**Field preparation (topographical pictures) | Байр зүйн гэрэл зураг дээр газрын гадаргын цэгүүдийн дүрслэлийг таньж илрүүлэх, тэдгээрийн байрлалын солбицол, өндрийг тодорхойлох технологийн үйлдэл |
| 1057. | Таних цэг | **P:**Опознак<br>**E:**Pinpoint | Фотограмметрийн гэрэл зураг дээр танигдсан объектын хээрийн хэмжилтээр солбицол, өндөр нь тодорхойлогдсон фотограмметрийн зураглалын объектын цэг. *Тайлбар: Таних цэг байрлалын, байрлал-өндрийн эсвэл өндрийн байна* |
| 1058. | Тэмдэглээс цэг | **P:**Маркировочный знак<br>**E:**Aerial resolution target | Агаар мандлаас газрын зураг авах нислэгийн чиглэлийг газар дээр тэмдэглэх цэгүүд |
| 1059. | Агаарын зургийн байрлалын холболт | **P:**Плановая привязка<br>**E:**Horizontal reference | Агаарын зургийн таних цэгийн солбицол тодорхойлох геодезийн хэмжилт |

| | | | |
|---|---|---|---|
| 1060. | Олон бүсчлэлийн зураглал | **Р:**Многозональное фотографирование<br>**E:**Multispectral photograhy | Сансраас газрын гадаргуун олон өнгийн давхарга, солонгон зураг авах арга |

**ЗУРАГ ЗҮЙ**
**КАРТОГРАФИЯ**
**CARTOGRAPHY**
**ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ**
**ОБЩИЕ ПОНЯТИЯ**
**GENERAL CONCEPTS**

| | | | |
|---|---|---|---|
| 1061 | Зураг зүй | **Р:**Картография<br>**E:**Cartography | Газрын гадаргын дүрс, байгаль, түүний зүй тогтол, нийгмийн үзэгдэл, юмсын хоорондын харилцан хамаарал, учир шалтгааныг шинжлэн дүгнэж, тэдгээрийн цаашдын хувьсал, өөрчлөлтийн чиг хандлага, нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтийг харуулсан тодорхой зориулалт, тусгаг, масштаб бүхий газрын зураг, атласыг зохиож хэвлэх үйл ажиллагаа |
| 1062 | Математик зураг зүй | **Р:**Математическая картография<br>**E:**Mathematical cartography | Газрын зургийн математик буюу тоон үндэслэл судлах, зураг зүйн тусгагийн онол боловсруулах, дүн шинжилгээ хийх ба гажилтыг тодорхойлдог зураг зүйн шинжлэх ухааны нэг салбар шинжлэх ухаан |
| 1063 | Тоон зураг зүй | **Р:**Цифровая картография<br>**E:**Digital cartography | Тоон зураг зүйн онол, бүтээж ашиглах хүрээг хамарсан зураг зүйн хэсэг |
| 1064 | Газрын зураг судлал | **Р:**Картоведение<br>**E:**Cartography/Map Science | Зураг зүйн бүтээгдэхүүний төрөл, хэлбэр ба шинж чанарыг судлах, ашиглах, дүн шинжилгээ хийх арга, аргачлал болон зураг зүйн түүхийг судалдаг зураг зүйн салбар. |
| 1065 | Газрын зургийн хэмжил судлал | **Р:**Картометрия<br>**E:**Cartometry | Газрын зургаар төрөл бүрийн хэмжилт, солбицол, зай, урт, өндөр, талбай, хэмжээ, чиглэл зэргийг тодорхойлох арга, аргачлалыг судлах зураг зүйн хэсэг |
| 1066 | Морфометр | **Р:**Морфометрия<br>**E:**Morphometry | Газар зүйн объектын хэлбэр, бүтцийн үүсэл, холбоосыг тооцоолон бодох аргыг судлах зураг зүйн судалгааны арга |
| 1067 | Геомэдээллийн зураглал | **Р:**Геоинформационное картографирование | Газар зүйн мэдээллийн технологи, газар зүйн, геологийн, экологийн болон |

| | | | |
|---|---|---|---|
| | | **E:**Geoinformation mapping | эдийн засаг, нийгмийн суурь мэдлэгт суурилсан газрын зураг, ашиглах зураг зүйн салбар |
| 1068 | Зураг зүйч | **Р:**Картограф<br>**E:**Cartographer | Газрын зургийн төсөл зохиох, редакц хийх, ерөнхий газар зүйн, сэдэвчилсэн, тусгай хэрэгцээний зураг, атлас, цахим зургийн зохиолтын эх бэлтгэх, хэвлэлд бэлтгэх зэрэг зураг зүйн мэргэжлийн үйлдвэрлэлийн мэргэжилтэн |
| 1069 | Газарзүйч-зураг зүйч | **Р:**Географ-картограф<br>**E:**Geographer-cartographer | Газарзүйн мэдлэг дээр суурилсан газар зүйн зураг атлас зохиох, шинжлэх ухаан, хэрэглээнд ашиглах салбар, газар зүйн мэдээллийн системийн мэргэшсэн зураг зүйч |
| 1070 | Газрын зургийн нэр судлал | **Р:**Картографическая топонимика<br>**E:**Cartographic toponymy | Газрын зураг дээр газар зүйн нэрийг хэрэглэх онол, хөрвүүлэх, хэрэглэх аргыг судлах зураг зүйн хэсэг |
| 1071 | Зураг зүйн ерөнхийлөл | **Р:**Картографическая генерализация<br>**E:**Cartographic generalization | Газрын зургийн зориулалтын сэдэв, масштабаас хамааран зураглаж буй объектыг сонгон хэрэглэх арга |
| 1072 | Автомат (зураг зүйн) ерөнхийлөл | **Р:**Автоматизированная (картографическая) генерализация<br>**E:**Automated (cartographic) generalization | Компьютерын тусламжтайгаар зураг зүйн тоон мэдээллийг ерөнхийлөх үйлдэл |
| 1073 | Зураг зүйн судалгаа /хамрах хүрээ/ Зураг зүйн бүтээлийн хангалт | **Р:**Картографическая изученность<br>**E:**Map coverage | Тухайн газрын зурагжуулалтын зургаар хэрхэн хангагдсаныг илэрхийлэх байдал буюу шаардагдах газрын зургийн хангагдсан байдал |
| 1074 | Зураг зүйн мэдээлэл | **Р:**Картографическая информация<br>**E:**Cartographic information | Зураг зүйн бүтээгдэхүүнийг зохиох, шинэчлэх шаардлагыг агуулсан, бүтээгдэхүүн хэлбэрээр илэрхийлэгдсэн зураг зүйн бүтээлээр дамжуулан нийтэд хүргэх мэдээлэл |
| 1075 | Зураг зүйн мэдээллийн тоожуулалт | **Р:**Метрическая картографическая информация<br>**E:**Mapping information | Солбицлын тогтолцоонд объектын орон зайн байрлалыг агуулсан зураг зүйн мэдээлэл |
| 1076 | Зураг зүйн бичвэр мэдээлэл | **Р:**Семантическая картографическая информация | Зураг зүйн объектын шинж чанарыг харуулсан бичвэр мэдээлэл |

| | | | |
|---|---|---|---|
| | | **E:**Semantic cartographic information | |
| 1077 | Зурагжуулалт | **Р:**Картографирование<br>**E:**Mapping | Нутаг дэвсгэрийн орон зай, од гариг, сансар огторгуй судлал г.м төрөл бүрийн газрын зургаар хангах арга |
| 1078 | Зураг зүйн үйлдвэрлэл | **Р:**Картографическое производство<br>**E:**Map production | Зураг зүйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбар |
| 1079 | Зураг зүйн ажлууд | **Р:**Картографические работы<br>**E:**Cartographic works | Зураг зүйн бүтээгдэхүүнийг төлөвлөх, төсөл боловсруулах, зураг зүйн эх материал цуглуулах, дүн шинжилгээ хийх, зохиогчийн эх, загвар боловсруулах, хэвлэлийн эх бэлтгэх, зураасан болон өнгөт сорьц хэвлэх, түүнд бүх төрлийн хяналт хийх, хэвлэх бүх шатны ажил |
| 1080 | Зураг зүйн элемент | **Р:**Объект картографирования<br>**E:**Map elements | Газрын зурагт дүрслэгдэх биет зүйл ба үзэгдэл |
| 1081 | Газрын зургийн хуудасны зах нийлэлт | **Р:**Сводка листов карты<br>**E:**Edge matching | Нэг төрлийн газрын зураг олон хуудсанд хуваагдаж, зэрэгцээ хуудас дамжсан элементүүдийг бүрэн нийлүүлж тохируулах ажиллагаа |

**ГАЗРЫН ЗУРГИЙН ЭЛЕМЕНТҮҮД БА ЗУРАГ ЗҮЙН ДҮРСЛЭЛИЙН АРГА**
**ЭЛЕМЕНТЫ КАРТЫ И СПОСОБЫ КАРТОГРАФИЧЕСКОГО ИЗОБРАЖЕНИЯ**
**CARD ELEMENTS AND METHODS CARTOGRAPHY**

| | | | |
|---|---|---|---|
| 1082. | Газрын зургийн программ | **Р:**Программа карты<br>**E:**Mapping program | Газрын зургийн төрөл, зориулалт, түүний математик үндэслэл, агуулга, ерөнхийллийн зарчим, таних тэмдэг, зураг зүйн эх материал, түүний ашиглалт болон зураг зохиох технологи зэргийг тогтоосон баримт |
| 1083. | Газрын зургийн геометр нарийвчлал/ Зургийн нарийвчлал | **Р:**Геометрическая точность карты Точность карты<br>**E:**Map accuracy | Газрын зурагт дүрслэгдсэн объект, элементүүдийн газар дээрх бодит байрлалтай зохицох зэрэглэл |
| 1084. | Газрын зургийн агуулгын үнэн бодит байдал | **Р:**Достоверность карты<br>**E:**Map reliability | Үнэмлэхүй болон харьцангуй алдааны утгуудыг үнэлэх замаар газрын зураг дээрх объектын байрлал, хэмжээ болон өндрийн утгын үнэн зөвийг үнэлэх байдал |
| 1085. | Газрын зургийн гоо үзэмж | **Р:**Наглядность карты<br>**E:**Map design | Газрын зургийн элементүүдийн өнгө, дүрслэлийг хүлээн авах чадвар |

| | | | |
|---|---|---|---|
| 1086. | Газрын зургийн уншилт | **Р:**Читаемость карты<br>**E:**Map readability | Газрын зургийн объект, элементүүдийн болон зураг зүйн дүрслэл хоорондын ялгарал |
| 1087. | Газрын зургийн ачаалал | **Р:**Нагрузка карты<br>**E:**Map loading | Тухайн газрын зургийн таних тэмдэг, тоо, бичиглэлийн ачааллын байдал |
| 1088. | Зураг зүйн дүрслэл | **Р:**Картографическое изображение<br>**E:**Cartographic representation | Дэлхий, гариг ертөнц, орчлонгийн гадаргуу, түүн дээр байрлаж буй объектыг зураг зүйн аливаа системд таних тэмдгээр үзүүлсэн дүрслэл |
| 1089. | Зураг зүйн дүрслэлийн арга | **Р:**Способ картографического изображения<br>**E:**Mapping method | Байгаль нийгмийн үзэгдлийг газрын зурагт үзүүлэх зураг зүйн арга |
| 1090. | Газрын зургийн агуулга | **Р:**Содержание карты<br>**E:**Map content | Тодорхой зорилго, сэдвийн хүрээнд боловсруулагдсан газрын зурагт дүрслэгдсэн элементүүд |
| 1091. | Газрын зургийн агуулгын элементүүд | **Р:**Элементы содержания карты<br>**E:**Map features | Байгаль дээрх юмсыг газрын зурагт зураг зүйн дүрслэлийн аргаар ялган дүрслэх элементүүд |
| 1092. | Газрын зургийн хүрээ | **Р:**Рамка карты<br>**E:**Map borders/neat line | Газрын зургийг нэг буюу хэд хэдэн хязгаарласан шугам |
| 1093. | Газрын зургийн минутын хүрээ | **Р:**Минутная рамка карты<br>**E:**Minute frame/Graticule | Голдоч ба зэргэдийг минутын нарийвчлалын хуваарьтайгаар үзүүлсэн газрын зургийн хүрээ |
| 1094. | Газрын зургийн хүрээний градусын хуваарь | **Р:**Градусная рамка (карты)<br>**E:**Degree frame (map)/Graticule | Голдоч ба зэргэдийг градусаар үзүүлсэн зургийн хүрээ |
| 1095. | Газрын зургийн дотоод хүрээ | **Р:**Внутренняя рамка карты<br>Внутренняя рамка<br>**E:**Inner frame | Газрын зургийн агуулга, дүрслэлийг хязгаарлах зургийн хүрээ шугам |
| 1096. | Газрын зургийн гадна хүрээ | **Р:**Внешняя рамка карты<br>**E:**External frame | Газрын зургийн хүрээний гаднах үзэмжийг сайжруулсан хүрээ шулуунууд |
| 1097. | Газрын зургийн хуваалга | **Р:**Разграфка карты<br>**E:**Sheet indexing | Нэг төрлийн газрын зургуудыг хуудсаар хуваaж дугаарлах тогтолцоо |
| 1098. | Нэрэлбэр | **Р:**Номенклатура листов карты<br>**E:**Sheet index /nomenclature | Хуваалгаар үүссэн газрын зургуудыг системчлэн дугаарлаж хэрэглэх арга |
| 1099. | Газрын зургийн чиглүүлэг | **Р:**Ориентирование карты<br>**E:**Map orientation | Ертөнцийн зүгээр газрын зургийн хүрээг чиглүүлэн байрлуулах үйлдэл |

| | | | |
|---|---|---|---|
| 1100. | Газрын зургийн элементүүд | **P:**Элементы содержания карты **E:**Map elements | Газрын зурагт дүрслэгдэх газар зүйн объект болон үзэгдэл |
| 1101. | Зураг зүйн материал | **P:**Картографический материал **E:**.Map source | Газрын зураг зохиох, шинэчлэх, ашиглахад хэрэглэгдэх бүх төрлийн өгөгдөл, мэдээ, баримтууд |
| 1102. | Таних тэмдэг | **P:**Картографические условные знаки **E:**Symbols | Газрын зурагт дүрслэгдэх төрөл бүрийн объект тэдгээрийн тоон болон чанарын үзүүлэлтийн геометрийн, уран сайхны, тоон ба үсгэн тэмдэглэгээ |
| 1103. | Масштабын бус таних тэмдэг | **P:**Внемасштабные картографические условные знаки Внемасштабные знаки **E:**Point symbol | Зурагжуулж буй объектын талбайн хэмжээ, зургийн масштабд тусгах хэмжээнээс бага тохиолдолд хэрэглэх зураг зүйн таних тэмдэг |
| 1104. | Газар зүйн нэр | **P:**Географические названия **E:**Geographic name/place names | Газрын гадарга дээрх байгалийн болон барьж байгуулсан объектуудыг өөр хооронд нь ялган таних зорилгоор оноосон болон дэвсгэр нэр |
| 1105. | Газар зүйн нэрийн товьёог | **P:**Указатель географических названий **E:**Geographical names index | Газрын зураг, атлас дээр дүрслэгдсэн газар зүйн объектын нэрийн цагаан толгойн дараалын жагсаалт |
| 1106. | Газар зүйн нэрийг галиглах | **P:**Передача географических названий **E:**Transcribing geographic names | Газар зүйн объектын нэрийг гадаад хэлэнд галиглах, тухайн хэл дээрх нэрийг авиа зүйн галиг, зөв бичих дүрмийн онцлогийг харгалзан эх хэл рүү хөрвүүлэн үзүүлэх арга |
| 1107. | Газрын зургийн гадна хүрээний чимэглэл | **P:**Зарамочное оформление (карты) **E:**Framing map elements | Зураг ашиглахад хялбар цогц өгөгдлийг зургийн гадна хүрээнд байрлуулах |
| 1108. | Газрын зураг дээрх тайлбар | **P:**Пояснительные подписи на карте **E:**Credits | Газрын зургийн объектын тоон болон чанарын үзүүлэлтийн тайлбар бичиг |
| 1109. | Газрын зургийн таних тэмдгийн тайлбар | **P:**Легенда карты Легенда **E:**Legend | Газрын зургийн агуулгыг унших таних тэмдгийн тайлбарын нэгдэл |
| 1110. | Зураг зүйд хэрэглэгдэх бичиглэлүүд | **P:**Картографические шрифты **E:**Cartographic labeling | Газрын зураг дээрх үсгийн хэлбэрүүд |
| 1111. | Газрын тухай лавлах/Газар | **P:**Справка о местности **E:**Gazetteer | Байр зүйн зургийн агуулгын нэмэлт болгосон, хэсэгчилсэн |

ТООН

| | | | |
|---|---|---|---|
| | зүйн нэрийн лавлах | | газрын үзүүлэлтийн агуулга бүхий бичгийн баримт |
| 1112. | Тэнцүү утгат шугам | **P:**Способ изолиний **E:**Method of isolines | Тэнцүү утгат шулууны утгаар илэрхийлсэн тоон үзүүлэлтийн дүрслэл |

**ЗУРАГ ЗҮЙ**
**ЦИФРОВАЯ КАРТОГРАФИЯ**
**DIGITAL CARTOGRAPHY**

| | | | |
|---|---|---|---|
| 1113. | Тоон зураг | **P:**Цифровая карта **E:**Digital map | Газрын зургийн төрөл, масштаб, агуулгад нийцсэн тоон зураг зүйн загвар |
| 1114. | Газрын гадаргын тоон зураг | **P:**Цифровые карты местности **E:**Digital relief map | Математикийн тодорхой үндэслэл, газрын зургийн тусгаг, хуваалгын дагуу кодолж, сонгосон масштаб, нарийвчлал, агуулгаар бүтээсэн газрын гадаргын тоон загвар |
| 1115. | Цахим байр зүйн зураг | **P:**Электронная топографическая карта **E:**Electronic topographic map | Математикийн болон геодезийн суурьтай, агуулга, дүрслэл, өнгийн бэлдэц нь улсын байр зүйн зургийн хэмжээнд бүтээгдсэн цахим (векторын эсвэл зураасан) байр зүйн зураг |
| 1116. | Цахим газрын зураг | **P:**Электронная карта **E:**Electronic map | Зургийн төрөл, агуулгад нийцсэн, тусгай тогтолцооны таних тэмдгээр дүрсэлсэн, мэдээллийн хэрэгслийн дэлгэц дээр харах, хэмжиж болох загвар |
| 1117. | Цахим атлас | **P:**Электронный атлас **E:**Electronic atlas/e-Atlas | Хөтөлбөрөөр нэгдсэн программаар зохиосон цахим газрын зургийн атлас |
| 1118. | Гадаргуун тоон загвар | **P:**Цифровая модель местности (ЦММ) **E:**Digital elevation model (DEM) | Нийтлэг өгөгдөхүүнд тулгуурлан тогтоосон торлолын огтлол бүр дээр өндрийн үргэлжилсэн утгаар үүсгэгдсэн газрын гадарга |
| 1119. | Газар зүйн объектын тоон загвар | **P:**Цифровая модель объектов местности **E:**Digital terrain model (DTM) | Объект байрласан газрын байрлал ба өндрийн мэдээллийг агуулсан газрын тоон загвар |
| 1120. | Газрын гадаргын тогтцын тоон загвар | **P:**Цифровая модель рельефа (ЦМР) **E:**Digital Relief model (DMR) | Газрын гадаргыг илэрхийлэх солбицол, өндөртэй олон тооны цэгүүдээс үүсэх загвар |
| 1121. | Газар нутаг, орчин | **P:**Местность **E:**Terrain | Газрын гадаргын бүх элементүүд (хэв шинж, хот суурин, замын сүлжээ, ус зүй, ургамлын бүрхүүл, хөрс г.м)-ийг агуулсан нэг хэсэг |

| | | | |
|---|---|---|---|
| 1122. | Газрын гадарга, хотгор, гүдгэр | **Р:**Рельеф<br>**E:**Relief | Дэлхийн дотоод ба гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр үүссэн газрын гадаргын тогтцын ижил бус байдлын бүтэц |
| 1123. | Газрын гадаргын тогтцын тоон загвар | **Р:**Цифровая модель рельефа<br>**E:**Digital model of relief | Газрын гадаргыг илэрхийлэх солбицол, өндөртэй олон тооны цэгүүдээс үүсэх загвар |
| 1124. | Тоон зураг зүйн загвар | **Р:**Цифровая картографическая модель<br>**E:**Digital cartographic model | Зурагжуулах объект, тэдгээрийн хоорондын харьцааг дотоод зүй тогтол-математикаар тоон хэлбэрээр илэрхийлэх үйлдэл |
| 1125. | Тоон зураг зүйн загварчлал | **Р:**Цифровое картографическое моделирование<br>**E:**Digital cartographic modeling | Тоон зураг зүйн загвар зохиох, ашиглах үйлдэл |
| 1126. | Газрын зургийн хэвлэлийн эхийн тоон загвар | **Р:**Цифровая модель издательского оригинала карты<br>**E:**Digital model of the map design | Газрын зургийн хэвлэлийн эхийн тоон хэлбэр |
| 1127. | Сэдэвчилсэн тоон загвар | **Р:**Тематическая цифровая модель<br>**E:**Digital thematic model | Тоон зураг зүйн төрөл бүрийн сэдэвчилсэн агуулгатай загвар |
| 1128. | Тоон зураг зүйн бүтээгдэхүүн | **Р:**Цифровая картографическая продукция<br>**E:**Digital cartographic products | Зураг зүйн тоон мэдээлэл ашигласан бүтээл |
| 1129. | Тоон зураг зүйн үйлдвэрлэл | **Р:**Цифровое картографическое производство<br>**E:**Digital cartographic production | Зураг зүйн тоон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбар |
| 1130. | Тоон зураг зүйн нийтийн хэрэгцээний бүтээгдэхүүн | **Р:**Цифровая картографическая продукция открытого пользования<br>**E:**Digital cartographic products for public use | Нийтийн хэрэгцээнд зориулсан сэдэвчилсэн, тусгай төрлийн, хот суурин газрын төрөл бүрийн сэдэвчилсэн агуулгатай газрын зураг зүйн тоон зураг |
| 1131. | Тоон газрын зургийн агуулгын элемент | **Р:**Элемент содержания цифровой карты<br>**E:**Element contents of digital map | Газрын зургийн объектыг группээр нэгтгэж тоон газрын зургийн нэгж |
| 1132. | Цахим зургийн тогтолцоо | **Р:**Система электронных карт | Нэгдмэл утга санаа, журам, тохирсон масштаб, солбицлын |

| | | | |
|---|---|---|---|
| | | **E:**Electronic map system | тогтолцоо, тусгаг, агуулга, таних тэмдэг зэрэг цогц бүхий нэгдсэн шаардлагын дагуу бүтээгдсэн цахим зургийн бүрдэл |
| 1133. | Тоон (цахим) зураг зүйн хангамж | **Р:**Картографическое обеспечение (цифровое) **E:**Cartographic support (digital) | Тоон зураг зүйн бүтээгдэхүүн зохиох, ашиглах, хадгалах, хэрэглэгчдэд түгээх хангагдсан байдал |
| 1134. | Цахим зурагтай ажиллах орчин | **Р:**Графическая среда пользователей электронных карт [планов] **E:**Graphical user interface | Тоон зураг зүйн мэдээлэлтэй ажиллах программын, технологийн, мэдээллийн, хэл зүйн хангалтын хэрэгсэл |
| 1135. | Тоон газрын зургийн (цахим зургийн) паспорт | **Р:**Паспорт цифровой [электронной] карты **E:**Passport of digital [electronic] map | Лавлахын-технологийн агуулгатай мэдээллийг өгөгдөл тээгч дээр тогтоосон формат, кодоор бичсэн тоон зургийн бүтцийн нэгж |
| 1136. | Тоон газрын (цахим) зургийн объект | **Р:**Объект цифровой [электронной] карты **E:**Object of digital [electronic] map | Тухайн объект, газрын шинж төрх, үзүүлэлтийг тодорхойлсон тоон зургийн бүтцийн нэгж |
| 1137. | Тоон байр зүйн зургийн цэгэн объект | **Р:**Точечный объект цифровой топографической карты **E:**Point object of the digital topographic map | Нэг цэгийн солбицлын байрлалын тухай илэрхийлсэн тоон байр зүйн зургийн объект |
| 1138. | Талбайн объект (тоон ба цахим зургийн) | **Р:**Площадной объект (цифровой [электронной] карты) **E:**Areal object (digital [electronic] map) | Битүүрсэн хүрээтэй цэгийн байрлалын солбицлын тоог, тойргийг дагуулан бичсэн тоон (цахим) зургийн объект |
| 1139. | Шугаман объект (тоон ба цахим зургийн) | **Р:**Линейный объект (цифровой [электронной] карты) **E:**Linear object (digital [electronic] map) | Байрлалын солбицлын мэдээллийн тоог дараалуулан бичсэн тоон (цахим) зургийн объект |
| 1140. | Иж бүрдэл объект (тоон ба цахим зургийн) | **Р:**Комплексный объект (цифровой [электронной] карты) **E:**Complex object (digital [electronic] cards) | Иж бүрдэл объектуудаас бүрдсэн тоон ба цахим зургийн объект |
| 1141. | Объектын код (тоон зургийн) | **Р:**Код объекта (цифровой карты) **E:**Object code | Тоон зургийн объектод ~~нэгэн адил~~ тохирох тоо, үсгийн хослол |

| | | | |
|---|---|---|---|
| 1142. | Объектын үзүүлэлтийн код | **Р:**Код характеристики объекта (цифровой карты)<br>**E:**Object characteristic code (digital cards) | Тоон зургийн объектын шинж байдал, үзүүлэлтэд нэгэн адил тохирох тоо, үсгийн хослол |
| 1143. | Бичиглэлийн формат (тоон зураг зүйн мэдээлэл) | **Р:**Формат записи (цифровой картографической информации)<br>**E:**Recording format (digital cartographic data) | Тоон зураг зүйн мэдээллийн файлд объектын төрөл, үзүүлэлтийг байршуулах бүтэц |
| 1144. | Вектор хэлбэр (тоон зураг зүйн мэдээлэл) | **Р:**Векторная форма представления (цифровой картографической информации)<br>**E:**Vector representation (digital cartographic information) | Зураг зүйн мэдээллийн утгуудыг вектор хэлбэрт оруулах арга |
| 1145. | Растер хэлбэр (тоон зураг зүйн мэдээлэл) | **Р:**Растровая форма представления (цифровой картографической информации)<br>**E:**Raster representation (digital cartographic data) | Тоон зураг зүйн тоон мэдээллийн элемент болох өнгийн кодыг матрицын хэлбэрт оруулах арга |
| 1146. | Зураг зүйн материалыг тоон хэлбэрт оруулах | **Р:**Цифрование картографического материала<br>**E:**Digitization of cartographic materials | Зураг зүйн мэдээллийг тоон хэлбэрт хөрвүүлэх |
| 1147. | Аэродромын зураглалын өгөгдлийн сан | **Р:**Картографическая база данных аэродрома<br>**E:**Aerodrome mapping database | Тодорхой бүтэцтэй өгөгдлийн багц болгон системчилсэн аэродромын зураглалын өгөгдлийн цуглуулга |
| 1148. | Аэродромын зураг зүйн өгөгдөл | **Р:**Картографические данные аэродрома<br>**E:**Aerodrome mapping data | Аэродромын зураглалын мэдээллийг бүрдүүлэх зорилгоор цуглуулсан өгөгдөл |
| 1149. | Үсгийн бичиглэлийн сан (цахим зургийн) | **Р:**Библиотека шрифтов (электронных карт)<br>**E:**Font library (e-cards) | Цахим зурагт дүрслэгдэх объектын үзүүлэлт, тэдгээрийн газар зүйн нэр болон бусад тайлбарыг цэгцэлсэн бичгийн үсгийн сан |
| 1150. | Ангилал кодын систем | **Р:**Система классификации | Тоон зурагжуулалтын объектыг ангилан кодлох арга ба бүрдэл |

| | | | |
|---|---|---|---|
| | | и кодирования (для цифрового картографирования) **E:**Classification and coding system (for digital mapping) | |
| 1151. | Зураг зүйн мэдээллийн ангилагч (тоон зурагжуулах) | **P:**Классификатор картографической информации (для цифрового картографирования) **E:**Classifier of cartographic information (for digital mapping) | Тоон газрын зургийн объектын өгөгдлийг ангилагч систем |
| 1152. | Тоон тайлбарын дүрэм (зураг зүйн мэдээллийн) | **P:**Правила цифрового описания (картографической информации) **E:**Rules of digital description (cartographic information) | Зураг зүйн тоон мэдээллийг тайлбарлах дүрэм |
| 1153. | Тоон зураг зүйн мэдээллийн давхарга | **P:**Слой (цифровой картографической информации) **E:**Digital cartographic layer | Аливаа шинж тэмдэг эсвэл групп шинжээр бүлэглэсэн тоон болон цахим зургийн объект |
| 1154. | Тоон зураг зүйн мэдээллийг хянан тохиолдуулах | **P:**Редактирование цифровой картографической информации **E:**Editing of digital cartographic information | Тоон зураг зүйн программын хэрэгслээр мэдээллийг шалгах, засах үйлдэл |
| 1155. | Тоон газрын зургийг хянан тохиолдуулах | **P:**Редактирование цифровой карты **E:**Editing of digital map | Тоон газрын зургийг зохиох, хянах, засварлах үйлдэл |
| 1156. | Тоон зураг зүйн мэдээллийн сан | **P:**База цифровой картографической информации **E:**Digital cartographic information database | Тодорхой дүрмийн дагуу зохион байгуулсан тоон зураг зүйн мэдээллийн сангийн иж бүрдэл |
| 1157. | Тоон зураг зүйн өгөгдлийн сан | **P:**Банк цифровых картографических данных **E:**Digital cartographic database | Тоон зураг зүйн бүтээгдэхүүнийг төвлөрсөн журмаар бүрдүүлэх техникийн, программын, мэдээллийн, хэл зүйн ба зохион байгуулалтын хэрэгсэл, хадгалах, боловсруулах, түгээх иж бүрдэл |

| | | | |
|---|---|---|---|
| 1158. | Тоон (цахим) зургийн архив | **Р:**Архив цифровых [электронных] карт<br>**E:**Digital [electronic] map archive | Тоон ба цахим зураг, мэдээлэл тээгч, эдгээрийн тухай бүртгэл, лавлах-бүртгэлийн мэдээллийг тогтоосон журмын дагуу хадгалах иж бүрэн хэрэгсэл |
| 1159. | Цахим зургийн объектын зэрэглэл | **Р:**Ранг объекта электронной карты<br>**E:**The rank object of e-map | Цахим зургийн объектын ач холбогдлын код |
| 1160. | Тоон (цахим) зураг зохиох редакцын бэлтгэл ажил | **Р:**Редакционно-подготовительные работы по созданию цифровой [электронной] карты [обновлению]<br>**E:**Preparation work for editing digital map | Чанарын шаардлагыг хангасан тоон (цахим) зураг зохиох техник зохион байгуулалтын иж бүрэн арга хэмжээ |
| 1161. | Тоон ба цахим зургийн бүртгэл | **Р:**Каталог цифровых и электронных карт<br>**E:**Catalogue of digital and electronic map | Тоон ба цахим зурагт нэвтрэх боломжийг хангах зориулалтаар хийсэн тоон зураг зүйн агуулгын системчилсэн тайлбар жагсаалт |

## ЗУРАГ ЗҮЙН БҮТЭЭГДЭХҮҮН
## ПРОДУКТЫ КАРТОГРАФИЯ
## CARTOGRAPHY PRODUCTS

| | | | |
|---|---|---|---|
| 1162. | Зураг зүйн бүтээгдэхүүн | **Р:**Картографическая продукция<br>**E:**Cartographic products | Аналог, тоон зураг зүйн мэдээлэл, зураг зүйн бүтээлүүд, эдгээр зориулсан программын хангалт |
| 1163. | Газрын зураг | **Р:**Карта. план<br>**E:**Map/Chart plan | Дэлхийн гадарга, огторгуй ертөнцийн бусад бодит биет буюу тэдгээрийн хэсгийг хавтгайд тодорхой масштаб, тусгаг, таних тэмдэг ашиглан жижгэрүүлэн буулгаж дүрсэлсэн зураг |
| 1164. | Анаглиф зураг | **Р:**Анаглифическая карта (анаглиф<br>**E:**Anaglyphic (al) map, anaglyph | Туслах гэрлүүдийг ашиглаж гурван хэмжээсээр гаргаж авах фотограмметийн аргад тулгуурласан тусгай нүдний шилээр харах өнгөт газрын зураг |
| 1165. | Аналитик зураг | **Р:**Аналитическая карта<br>**E:**Analytic map | Тусгайлан нэгтгээгүй эсвэл бага хэмжээгээр нэгтгэсэн үзүүлэлтийг харуулсан зураг |
| 1166. | Ашигт малтмалын зураг | **Р:**Карта полезных ископаемых<br>**E:**Mineral resources map | Ашигт малтмал үүсэх нөхцөл, нөөц, байрлалыг харуулсан сэдэвчилсэн зургийн төрөл |

| | | | |
|---|---|---|---|
| 1167. | Бүдүүвч зураг | **Р:**Карта-схема **E:**Schematic map | Агуулгын дүрслэлийн элементүүдийг хялбаршуулж, нэгтгэсэн зураг |
| 1168. | Картограмм | **Р:**Картограмма **E:**Cartogram | Тодорхой нэгжийн аливаа үзэгдлийн дундаж эрчимжилтийг дэвсгэрлэн дүрслэх арга |
| 1169. | Газар зүйн зураг | **Р:**Географическая карта **E:**Geographic map | Байгаль, нийгэм, эдийн засгийн үзэгдэл юмсын байршлын зүй тогтол, тэдгээрийн уялдаа холбоо, орон зай, цаг хугацааны өөрчлөлт, хөгжлийг зураг зүйн тусгагт тодорхой таних тэмдгийн тогтолцоогоор багасган харуулах аргаар бүтээсэн зураг |
| 1170. | Газар хөдлөлийн зураг | **Р:**Тектоническая карта **E:**Tectonic card/Seismic map | Газар хөдлөлийн үйл явцыг чичирхийллийн хэмжээ, голомтын гүн, газар хөдлөлтийн төв зэрэг үзүүлэлтийг тусгасан газрын зураг |
| 1171. | Геологийн зураг | **Р:**Геологическая карта **E:**Geological map | Геологийн хайгуул судалгааны тулгуур хэмжигдэхүүнүүдэд тулгуурлан газар нутгийн геологийн тогтцыг харуулсан зураг |
| 1172. | Гидрогеологийн зураг | **Р:**Гидрогеологическая карта **E:**Hydrogeological map | Газар доорх усны байршил, тархалтын нөхцөл, эртний сууръ чулуулгийн усны даралтын тогтолцоо, уст давхаргын шинж чанар, усан хангамжийн үзүүлэлтийг тусгасан газрын зураг |
| 1173. | Далай тэнгисийн газрын зураг | **Р:**Карты морские **E:**Ocean map/Nautical map/chart | Хөлөг онгоцыг удирдахад ашиглах далай тэнгисийн ёроолын хотгор, гүдгэр, ул хөрсний шинж чанар, усны урсгал ба түлхэлт, соронзон хазайлт, хөлөг онгоцонд аюултай газрыг заасан газрын зураг |
| 1174. | Динамик газрын зураг | **Р:**Динамическая карта **E:**Dynamic map | Дэлхийн хөрсний гүн, агаар мандал, усан бүрхүүл, шим мандлын өөрчлөлтийн зүй тогтлыг тусгасан, харилцан үйлчлэлийн бүсийг нь тодорхойлсон, тодорхой цаг хугацаагаар холбогдох гурван хэмжээст газрын зураг. Цаг хугацаа нь дөрвөн хэмжээст газрын зураг болно |

| | | | |
|---|---|---|---|
| 1175. | Ерөнхий тойм зураг | **Р:**Обзорная карта<br>**E:**Chorographic map | Зурагжуулж буй салбартай нийтэд нь танилцах зориулалтын газрын зураг |
| 1176. | Ерөнхий газар зүйн зураг | **Р:**Общегеографическая карта<br>**E:**Topographic map | Дэлхийн гадаргын хэлбэр дүрс, далай тэнгис, гол мөрөн, хот суурин газрууд, улс орны болон засаг захиргааны хил хязгаар, гол авто зам,төмөр замын сүлжээ зэрэг Дэлхийн газрын гадаргын гадаад төрхийг үзүүлсэн газрын зураг |
| 1177. | Жижүүрлэлтийн зураг | **Р:**Дежурная карта<br>**E:**Map book | Газрын зургийн агуулгын өөрчлөлтийг тухай бүр бүртгэж, тэмдэглэсэн зураг |
| 1178. | Замын сүлжээний зураг | **Р:**Карта дорожных сетей<br>**E:**Road network map | Авто зам ба төмөр замын сүлжээ түүний (гүүр, хонгил, гарам) байгууламжууд, зай хэмжээ, шатахуун түгээх станц, зам дагуух хот суурины нэр, зочид буудал, хоолны газар г.м. мэдээлэл багтаасан сэдэвчилсэн зургийн төрөл |
| 1179. | Иж бүрдэл газрын зураг | **Р:**Комплексная карта<br>**E:**Complex card | Өөр хоорондоо холбоо бүхий хэд хэдэн объектыг үзүүлэлт бүрээр нь дүрсэлсэн газрын зураг |
| 1180. | Нислэгийн зураг | **Р:**Аэронавигационная карта<br>Навигационная карта<br>**E:**Air navigation chart<br>Navigation map | Газрын гадаргын хэсэг, түүний хиймэл байгууламж болон газрын тогтцыг агаарын навигацийн шаардлагад нийцүүлэн тусгайлан тодорхойлсон дүрслэл |
| 1181. | Оддын зураг | **Р:**Звездная карта<br>**E:**Star chart/<br>constellation map | Тэнгэрийн оддын газрын зураг |
| 1182. | Өндөр хэмжилт, гипсометр | **Р:**Гипсометрия<br>**E:**Hypsometry | Газрын гадаргын хотгор гүдгэр байдлыг хаялбараар өнгийн шатлалаар дүрслэх арга |
| 1183. | Өндөр хэмжилтийн арга | **Р:**Гипсометрический способ<br>**E:**Hypsometric method | Өндөр хэмжилтийн будалтыг хаялбартай хослуулан газрын гадаргуug шатлалаар дүрслэх арга |
| 1184. | Өндөр хэмжилтийн зураг | **Р:**Гипсометрическая карта<br>**E:**Hypsometric card | Газрын гадаргуун өндрийн шатлалыг өнгийн хамт хаялбараар дүрсэлсэн газрын зураг |
| 1185. | Сэдэвчилсэн зураг | **Р:**Тематические карты<br>**E:**Thematic map | Байгалийн ба нийгэм эдийн засгийн янз бүрийн үзэгдлийн байршил, хоорондын холбоо, |

| | | | |
|---|---|---|---|
| | | | хөгжлийн хурдцыг тусгасан газрын зураг |
| 1186. | Тусгай зориулалттай зураг | **Р:**Карта специального назначения<br>**Е:**Special-purpose map | Тодорхой чиглэлийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор хязгаартай хэрэглэгчид ашиглах газрын зураг |
| 1187. | Түүхийн зураг | **Р:**Историческая карта<br>**Е:**Historical card | Түүхийн үйл явдал, үзэгдлийн агуулгатай газрын зураг |
| 1188. | Усны ёроолын гүний зураг | **Р:**Батиметрическая карта<br>**Е:**Bathymetric map | Усан доорх гадаргыг хаялбараар дүрсэлж үзүүлсэн газрын зураг |
| 1189. | Товгор зураг | **Р:**Рельефная карта из пластики<br>**Е:**Plastic embossed model/3D map | Газрын гадаргыг эзлэхүүн хэлбэртэй товойлгож дүрсэлсэн газрын зураг |
| 1190. | Цагийн бүсийн зураг | **Р:**Карта часовых поясов<br>**Е:**Map of time zones | Цагийн бүсийн хил ба дугаар, өдөр солигдох шугамыг үзүүлсэн газрын зураг |
| 1191. | Физик газар зүйн зураг | **Р:**Физико-географическая карта<br>**Е:**Physical geographic map | Бодит гадарга ба усны гадаргын гаднах төрх байдлыг харуулсан ерөнхий газар зүйн зураг |
| 1192. | Эдийн засгийн газар зүйн зураг | **Р:**Экономико-географическая карта<br>**Е:**Economic map | Улс орны болон Дэлхийн эдийн засгийн байдал, хөгжлийн явцыг дүрсэлсэн газрын зураг |
| 1193. | Атлас | **Р:**Атлас<br>**Е:**Atlas | Ерөнхий хөтөлбөрийн дор бүтээгдсэн хоорондоо холбоо бүхий нэгдмэл шинж чанар, ижил чимэглэлтэй газрын зургийн цуглуулга |
| 1194. | Ерөнхий газар зүйн атлас | **Р:**Обще-географический атлас<br>**Е:**General atlas | Зурагжуулах хүрээнд бүх төрлийн иж бүрэн, олон талт үзүүлэлтийг багтаасан зургуудыг нэгтгэсэн атлас |
| 1195. | Газар зүйн атлас | **Р:**Географические атласы<br>**Е:** Geographic Atlases | Агуулга зориулалт зэргээрээ нэгдмэл газар зүйн зургийн системтэй цуглуулга |
| 1196. | Оддын атлас | **Р:**Звездный атлас<br>**Е:**Star atlas | Од эрхсийн атлас |
| 1197. | Сургалтын атлас | **Р:**Учебный атлас<br>**Е:**Educational atlas | Их, дээд, дунд сургуулийн газар зүйн хичээлийн сургалтад зориулан цомог болгон хэвлэж нэгтгэсэн атлас |
| 1198. | Үндэсний атлас | **Р:**Национальный атлас<br>**Е:**National atlas | Улсын нутаг дэвсгэрийн байгалийн байдал, түүний нөөц, хүн ам зүй, аж ахуйн салбар, түүх соёл, экологийн байдал зэргийг үзүүлсэн цогц агуулга бүхий улс орны атлас |

| | | | |
|---|---|---|---|
| 1199. | Бөмбөрцөг үйлдвэрлэл | **P:**Изготовление глобусов<br>**E:**Globe making | Тодорхой масштаб, зураг зүйн дүрслэл бүхий дэлхий болон бусад гаригийн бөмбөрцөг үйлдвэрлэл |
| 1200. | Газар зүйн бөмбөрцөг | **P:**Географический глобус<br>**E:**Globe | Дэлхийн гадаргыг дүрсэлсэн бөмбөрцөг |

**МАТЕМАТИК ЗУРАГ ЗҮЙ**
**МАТЕМАТИЧЕСКАЯ КАРТОГРАФИЯ**
**MATHEMATICAL CARTOGRAPHY**

| | | | |
|---|---|---|---|
| 1201 | *X*-абцисс тэнхлэг | **P:**Абсцисса<br>**E:**Abscissa | Зураг зүйн торлолын солбицлын тогтолцоо дахь зүүн-баруун тооллын шугамаас хойт чиглэлд нэмэх, өмнө зүг рүү хасах утгатай тоологдох шугаман зай |
